

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7436 дугаарт бүртгэв.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ШИЙДВЭР**

2025 оны 10 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар А/830, А/589

Чингис хот

### **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС ТОГТООХ, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 72 дугаар зүйлийн 71.1.2 дахь заалт, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэнтий аймгийн Чингис хотын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг 1 дүгээр, бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газар /Г.Энхмөнх/, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хэнтий аймгийн Байгаль орчны газар /Б.Амгаланбат/, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /Б.Хэрлэнчимэг/, Хэрлэн сумын Засаг дарга /Д.Эрдэнэбаатар/-д тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны Хэвлэл мэдээллийн алба /Б.Батбаатар/, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Золбоо/-д тус тус үүрэг болгосугай.

4.Хэнтий аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/492, А/557 дугаартай хамтарсан тушаал, захирамжийг хүчингүйд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хэнтий аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн  
А/830, А/589 дүгээр шийдвэрийн 1 дүгээр хавсралт*

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЧИНГИС ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ  
САЙЖРУУЛАХ БҮС**

| Бүс        | Баг     | Гудамж                                                                                               | Айл өрх тоо<br>/галлагаатай/ | Аж ахуйн<br>нэгж<br>байгууллага<br>тоот |
|------------|---------|------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|-----------------------------------------|
| 1-р<br>бүс | 1 Хийд  | 13,14,15,16,17,18,19,20,21,22,23,24,25                                                               | 208                          | 6                                       |
|            | Нисэх   | 9,10,11,12,13,14,15,16,17,18,19,20,21,22,<br>23,24,25,26,27,28,29,30                                 | 184                          | 1                                       |
|            | 2 Өргөө | 1а,1б,2а,2б,3а,3б,4а,4б,5а,5б,6а,6б,7а,<br>7б, 8а, 8б                                                | 158                          | 14                                      |
|            | Өлзийт  | 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13,14,15,16,17<br>,18,19,20,21,22,23,24,25,26,27,28,29,30,<br>31,32,33,34 | 529                          | 11                                      |
|            |         |                                                                                                      | 1079                         | 32                                      |



*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хэнтий аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн  
А/830, А/589 дүгээр шийдвэрийн 2 дугаар хавсралт*

## **ХЭНТИЙ АЙМГИЙН ЧИНГИС ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Хэнтий аймгийн Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг Хэнтий аймгийн Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### **Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

Хэнтий аймгийн Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Хэрлэн сумын Засаг даргаас зөвшөөрөл авах;

2.2.Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.3.Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох;

2.4.Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.5.Агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талаар Байгаль орчны газар, Сумын Засаг даргын Тамгын газарт үнэн зөв мэдээлэх;

2.6.Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх;

2.7.Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15кВт-аас дээш хүчин чадалтай агаар бохирдуулах эх үүсвэр шинээр байгуулахгүй байх;

2.8.Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллагууд үнс, нурам ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах /чийгшүүлэх/ арга хэмжээ авах;

2.9.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 кВт-с дээш хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий Хүхрийн давхар исэл, Азотын давхар исэл, тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах;

2.10.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших гэр хорооллын айл өрхүүд нэгдсэн халаалтын системд үе шаттай холбогдох;

2.11.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах өрх 5-аас доошгүй, аж ахуйн нэгж, байгууллагууд 30-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн болон нийтийн эзэмшлийн газарт тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.12.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших;

2.13.Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжаа нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

2.14.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд өдөр шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (Гэр, байшин барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх;

2.15.Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.16.Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн халаалтын шугамд холбогдох;

2.17.Агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

### **Гурав.Төрийн байгууллагуудын чиг үүрэг**

3.1.Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2.Байгаль орчны газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавина.

3.3.Ус, цаг уур, орчны шинжилгээний газар агаарын чанарын хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, олон нийтийг агаарын чанарын

мэдээллээр хангана.

3.4.Хотын тохижилт, үйлчилгээний газар гэр хорооллын айл өрхийн ангилан ялгасан үнс, ахуйн хог хаягдлыг гарагийн хуваарийн дагуу ангилж тээвэрлэнэ.

3.5.Түүхий нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах, гэр байшин сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй байгалийн хий болон сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэхийг сурталчлан таниулах, сургалт сурталчилгаа хийх;

3.6.Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.7.Байгаль орчны газар “Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.8.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад дотоод орчны агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг, Эрүүл мэндийн газар, Сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.

3.9.Байгаль орчны газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв хамтран холбогдох байгууллагуудаас мэдээ тайланг нэгтгэн 5 дугаар сарын 20-ны дотор Аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.

### **Дөрөв.Хяналт, хариуцлага**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Хэнтий аймгийн Байгаль орчны газар болон эрх бүхий албан тушаалтан, сум, багийн Засаг дарга, хэсгийн ахлагч нар хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг), Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ШИЙДВЭР**

2025 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар А/834, А/591

Зуунмод хот

### **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2 дахь заалт, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Зуунмод хотын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг нэгдүгээр, бүсэд мөрдөх журмыг хоёрдугаар, хилийн зааг байршил харуулсан зургийг гуравдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газар /Г.Энхмөнх/-т, журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Төв аймгийн Байгаль орчны газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Нарангэрэл/, Ус цаг уур орчны шинжилгээний төв /Э.Гэрэлтцогт/, Зуунмод сумын Засаг дарга /Б.Хатанбаатар/-д тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээллэхийг Төв аймгийн Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Нарангэрэл/,Төв аймгийн Засаг даргын Тамгын газар /С.Цогбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү хамтарсан захирамж, тушаал гарсантай холбогдуулан “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Төв аймгийн Засаг даргын 2022 оны А/425, А/585 дугаар хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Л.ТӨМӨРЧӨДӨР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Төв аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/834, А/591 дүгээр шийдвэрийн нэгдүгээр хавсралт*

**ЗУУНМОД ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС  
/2025-2026/**

| Баг                   | 1 дүгээр бүс<br>/гудамж/                                                                    | 2 дугаар бүс<br>/гудамж/                                        |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| Номт I баг            |                                                                                             | “Жишиг хороолол-2”                                              |
| Ланс II баг           | 9-20<br>Жалга 2-32<br>Хийд 1-9                                                              | 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8<br>Энгэрийн 1-9                          |
| Баянхошуу III баг     | 1-42                                                                                        | 0-12<br>43-55,<br>“Жишиг хороолол-1” 1-10                       |
| Зүүндэлгэр IV баг     | A14-21,<br>Б11-19,<br>Б8-1-12 Дугуй булаг, Баянбулаг,<br>Энгэр, Дэлгэрэх, Цэргийн<br>гудамж | A1-15,<br>Б1-10,<br>A0-Б0                                       |
| Нацагдорж V баг       | 0-12                                                                                        | Усны аж ахуйн А, Б хэсэг                                        |
| Баруун Зуунмод VI баг | 9, 10, 13, 15-25                                                                            | 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 14                              |
| Тайлбар               | Түүхий нүүрсний хэрэглээг<br>бууруулна.                                                     | Цахилгаан болон бусад эх<br>үүсвэрээр үе шаттайгаар<br>холбоно. |

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Төв аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/834, А/591 дүгээр шийдвэрийн хоёрдугаар хавсралт*

## **ЗУУНМОД ХОТЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Төв аймгийн Зуунмод хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг Төв аймгийн Зуунмод хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### **Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

Төв аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулагч томоохон суурин эх үүсвэр /усан халаалтын болон уурын зуух/ ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Зуунмод сумын Засаг даргаас зөвшөөрөл авах;

2.2.Агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэр /усан халаалтын болон уурын зуух/ ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд зуухандаа технологийн шинэчлэл хийж сайжруулах, шаталтыг бүрэн явуулах, бохирдлыг бууруулах зорилгоор /тортог баригч шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх г.м/ тоноглох;

2.3.Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж байгууллагууд үнс, нурам ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах /чийгшүүлэх/ арга хэмжээ авах;

2.4.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усан халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх;

2.5.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуйн нэгж байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

2.6. Агаарын чанарыг сайжруулах бүсэд аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгааны ажилд идэвхтэй оролцох;

2.7. Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2.8. Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших;

2.9. Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламжаа нүхэн жорлон, угаадасны нүх, техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх;

2.10. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд өдөр шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (гэр, байшин барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх;

2.11. Улсын байцаагчийн болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

2.12. Агаарын чанарын талаарх мэдээлэл болон агаар орчны бохирдлыг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

2.13. Агаарын чанарыг сайжруулах бүсэд 15 кв хүртэлх хүчин чадалтай зуухны тоог нэмэгдүүлэхгүй байх;

2.14. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүд 15-100квт хүртэлх хүчин чадалтай зууханд технологийн шинэчлэл хийх /хийн болон цахилгаан/;

2.15. Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй 101 квт-аас дээш хүчин чадалтай зуухны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, тоосонцор шүүх шүүлтүүрүүдийг суурилуулах;

2.16. Агаарын чанарыг сайжруулах бүсэд гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

### **Гурав. Төрийн байгууллагын чиг үүрэг**

3.1. Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2. Аймгийн Байгаль орчны газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3.Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.4.УЦУОШТөв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчны газарт хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

3.5.Байгаль орчны газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.1.Журмын хэрэгжилтийн талаар холбогдох мэдээ тайланг бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргад тайлагнана;

3.5.2.“Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;

3.5.3.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг Эрүүл мэндийн газар, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.


3.6.Аймгийн Засаг дарга агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилийн талаарх тайлан, мэдээг жил бүр БОУАӨЯ-нд ирүүлнэ.

### **Дөрөв.Хяналт, хариуцлага**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Төв аймгийн Байгаль орчны газар, /Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Зуунмод сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар/ хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийг этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн тухай тухай (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг) төрийн албан хаагчид Төрийн албаний хуульд заасан хариуцлага тооцно.

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Төв аймгийн Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/834, А/591 дүгээр шийдвэрийн гуравдугаар хавсралт*



Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7438 дугаарт бүртгэв.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ШИЙДВЭР**

2025 оны 10 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар А/836, А/642

Мөрөн сум

### **АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 72 дугаар зүйлийн 72.1.1, 72.1.2, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг нэгдүгээр, бүсэд мөрдөх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү хамтарсан тушаал, захирамжийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, журмыг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, зохицуулалтын газрын дарга (Г.Энхмөнх), журмын хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар (Д.Даваадорж), Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Д.Өнөрбат), Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр) нарт тус тус даалгасугай.

3.Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээллэхийг Хөвсгөл аймгийн Байгаль орчны газрын дарга (Д.Даваадорж), Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар (Р.Машбат) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү хамтарсан тушаал, захирамж гарсантай холбогдуулан “Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан 2016 оны 02-р сарын 23-ны өдрийн А/48, А/192 дугаар тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Б.БАТБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хөвсгөл аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн  
А/836, А/642 дугаар шийдвэрийн нэгдүгээр хавсралт*

**МӨРӨН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮС**

| Бүс            | Бүсэд хамрагдах баг, гудамж                                                                                      | Өрхийн тоо | Нийт галлагаатай айл өрхийн тоо |
|----------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------|
| 1 дүгээр бүс   | 5 дугаар багийн зах орчмын баруун талын хэсэг болон гэр хорооллын айл өрхүүд болон албан байгууллагууд хамаарна. | 184        | 184                             |
| 2 дугаар бүс   | 6 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүд болон албан байгууллагууд хамаарна.                                     | 967        | 519                             |
| Айл өрхийн тоо | 1151                                                                                                             |            |                                 |

*Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хөвсгөл аймгийн  
Засаг даргын хамтарсан 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн  
А/836, А/642 дугаар шийдвэрийн хоёрдугаар хавсралт*

## **МӨРӨН СУМЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг Мөрөн сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд ажиллаж, амьдарч байгаа иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### **Хоёр.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг**

2.1.Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд нь агаар бохирдуулагч аливаа эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөр дүгнэлт гаргуулан Мөрөн сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

2.2.Агаарын чанарын сайжруулах бүсэд халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж сайжруулах, шаталтыг бүрэн явуулах, бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжөөр (тортог баригч, шүүлтүүр, утаа сарниулагч суурилуулах, зуухны янданг боломжит хамгийн өндөр хэмжээнд хүртэл өндөрлөх гэх мэт) тоноглох.

2.3.Уурын болон усан халаалтын зуух хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллагууд стандартын шаардлага хангасан үнс баригч, шүүлтүүртэй зуух суурилуулах, үнсийг ахуйн хог хаягдлаас тусгайлан ангилж, битүүмжлэлтэй саванд хадгалж, ачиж тээвэрлэхдээ тоосжилт дарах /чийгшүүлэх/ арга хэмжээ авах.

2.4.Үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд халаалтын зууханд хаягдал дугуй, ашигласан тос масло, хуванцар хог, нийлэг уут гэх мэт зориулалтын бус түлш шатаахгүй байх.

2.5.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах иргэн 5-аас доошгүй, аж ахуй нэгж, байгууллагууд 10-аас доошгүй мод бутыг өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайд тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

2.6.Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрхүүд хашаандаа хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэнд оруулах.

2.7. Агаарын бохирдлын сөрөг нөлөөллөөс эрүүл мэндээ хамгаалах зорилгоор зуух, яндангийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийж, дотоод орчны агаарын чанараа сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.8. Агаарын чанарыг сайжруулах бүсийн иргэн аж ахуй нэгж байгууллага аймаг, сумаас зохион байгуулж буй сургалт, сурталчилгаа, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох.

2.9. Гэр хорооллын айл өрхүүд ариун цэврийн байгууламж, угаадасны нүхийг техникийн шаардлага MNS 5924:2015 стандартад нийцүүлэх.

2.10. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд өдөр, шөнийн 2 тарифт тоолуур суурилуулах, шөнийн цагаар түүхий нүүрс түлэхээс татгалзаж, цахилгаан халаагуур болон бусад дэвшилтэд технологи бүхий бүтээгдэхүүн (гэр, байшин, барилгын дулаан алдагдлыг багасгах, сайжруулсан зуух, түлш, сэргээгдэх эрчим хүч, хийн түлш гэх мэт)-ийг хэрэглээндээ үе шаттайгаар нэвтрүүлэх.

2.11. Байгаль орчны байцаагч, орчны эрүүл ахуйн байцаагч болон цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, байгаль орчны мэргэжилтнийг шаардлагатай тохиолдолд өөрийн эзэмшилд нэвтрүүлж, түүний тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

2.12. Ахуйн хэрэглээний түлшний үйлдвэрүүд, нөөцлөх агуулахууд, худалдан борлуулах цэгийн зориулалтаар ашиглаж, эзэмшиж буй газрынхаа эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, түлш хураах, хадгалах, худалдан борлуулах талбайг бетоноор цутгаж цугларсан түлшний хог хаягдлыг цуглуулах түр цэг байгуулж цэвэрлэн тогтмол зөөвөрлөж, гэрэлтүүлэг, камержуулалт байршуулах, тухайн орчны эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангаж хамгаалах.

2.13. Уурын болон усан халаалтын зуух ашиглагч аж ахуйн нэгж, иргэн халаалтын зуухны утааны сувагт хаягдал утааг хэмжих зориулалттай сорьцын цэг гаргаж жилд 1-ээс доошгүй удаа эх үүсвэрийн шинжилгээ хийлгэж стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг хянах.

2.14. Гэр, сууц, ажлын байрны дулаан алдагдлыг багасгах зориулалттай, стандартад нийцсэн нэмэлт дулаалга хийх.

2.15. Хуульд заасан бусад эрх, үүрэг.

### **Гурав. Төрийн байгууллагуудын чиг үүрэг**

3.1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

3.2. Аймгийн Байгаль орчны газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.3.Багийн Засаг дарга нар агаарын чанарыг сайжруулах бүсэд орших айл өрх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж, дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвд хүргүүлнэ.

3.4.УЦУОШТөв нь агаарын чанарыг сайжруулах бүсэд орших агаар бохирдуулах эх үүсвэрийн мэдээлэл болон агаарын чанарын төлөв байдлын талаарх тайлан мэдээг Байгаль орчны газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газарт хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

3.5.Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар нь ухаалаг тоолуур, угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд олгохдоо хариуцлагын гэрээ байгуулан ашиглалт, хамгаалалтын асуудлыг шийдвэрлэнэ.

3.6.Байгаль орчны газар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.6.1.Байгаль орчны газар Мөрөн сумын Засаг даргын Тамгын газартай хамтран журмын хэрэгжилтийн талаар холбогдох мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана;

3.6.2.“Агаарын тухай хууль тогтоомж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, шийдвэр”-ийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана;

3.6.3.Өвлийн улиралд бага насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өндөр настнуудад агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөв дадал, хэрэглээг хэвшүүлэх сурталчилгааг Эрүүл мэндийн газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна;

3.6.4.Хуульд заасан бусад эрх үүрэг.

### **Дөрөв.Хяналт, хариуцлага**

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, сум, багийн Засаг дарга нар хяналт тавина.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай болон Эрүүгийн тухай хууль (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг), төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7439 дүгээрт бүртгэв.

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар А/565

Улаанбаатар  
хот

### **МАЛ ҮРЖҮҮЛЭГ, ТЕХНОЛОГИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ЖИШИГ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, төлбөрийн жишиг үнийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний жишиг үнийг орон нутагт хүргүүлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг баталсан үнэлгээгээр тооцож жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн)-д үүрэг болгосугай.

3. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд шаардагдах зардлыг баталсан үнэлгээгээр тооцож жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.ЭНХБАЯР

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/565 дугаар тушаалын хавсралт*

**МАЛ ҮРЖҮҮЛЭГ, ТЕХНОЛОГИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНД  
БАРИМТЛАХ ЖИШИГ ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

| № | Ажил үйлчилгээний ангилал                                                                                                                                                                     | Гүйцэтгэх ажил үйлчилгээ                                                            | Малын төрөл | Хэмжих нэгж    | Жишиг үнэ /төгрөгөөр/ |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|-------------|----------------|-----------------------|
| 1 | Үндсэн сайжруулагчаар ашиглаж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт явуулж стандартын шаардлага хангасан цөм сүргийг бүрдүүлэх, үржлийн өсвөр мал бойжуулах, баталгаажуулах | Ангийн ангилалт                                                                     | Бод         | Толгой тутам   | 3,000                 |
|   |                                                                                                                                                                                               |                                                                                     | Бог         |                | 2,000                 |
|   |                                                                                                                                                                                               | Хувьсын ангилалт                                                                    | Бод         | Толгой тутам   | 10,000                |
|   |                                                                                                                                                                                               |                                                                                     | Бог         |                | 5,000                 |
| 2 | Малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох                                                                                                                                      | Малыг ээмэглэх, ялган тэмдэглэх                                                     | Бод         | Толгой тутам   | 2,500                 |
|   |                                                                                                                                                                                               |                                                                                     | Бог         |                | 1,500                 |
|   |                                                                                                                                                                                               | Малын бүртгэл хөтлөх, нэгдсэн санд мэдээлэх                                         | Бүх мал     | Толгой тутам   | 2,000                 |
|   |                                                                                                                                                                                               | Үржүүлгийн бүтээгдэхүүний бүртгэл хөтлөх, програмд шивэх                            |             | Толгой         | 2,000                 |
|   |                                                                                                                                                                                               | Удам зүйн үнэлгээний бүртгэл хөтлөх, програмд шивэх                                 |             | Толгой тутам   | 2,500                 |
|   |                                                                                                                                                                                               | Уламжлалт мэдлэгийн бүртгэл хөтлөх, програмд шивэх                                  |             | Өрхөөр         | 2,500                 |
| 3 | Малын генийн үндэсний санг баяжуулах, хээлтүүлэгч малын үржлийн чанарыг үнэлэх                                                                                                                | Гойд ашиг шимт хээлтүүлэгч малаас үр авч хадгалах                                   | Бод         | Нэг тун тутамд | 3,500                 |
|   |                                                                                                                                                                                               |                                                                                     | Бог         |                | 2,000                 |
|   |                                                                                                                                                                                               | Үржлийн үнэт чанараар гойд ашиг шимт мал шалгаруулах, улсын үржлийн дэвтэрт бүртгэх | Бод         | Толгой тутам   | 50,000                |
|   |                                                                                                                                                                                               |                                                                                     | Бог         |                | 35,000                |

|   |                                                                       |                                                            |          |              |         |
|---|-----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------|----------|--------------|---------|
| 4 | Зөгийнд үзлэг ангилалт хийх                                           | Зөгийг бүлээр жинлэх /үүр хайрцаг/                         |          | Бүл тутам    | 3,000   |
|   |                                                                       | Эх зөгийн биеийн хэмжээ авч, галбир үнэлэх                 | эх зөгий | Толгой тутам | 3,000   |
|   |                                                                       | Бүлийн хүчийг тодорхойлох /Завсрын зайгаар/                |          | Бүл тутам    | 2,000   |
|   |                                                                       | Зөгийн үржлийн удмын бүртгэл хөтлөх                        |          | Бүл тутам    | 2,000   |
| 5 | Мал, амьтанд им тэмдэг тавих                                          | Хүйтэн аргаар тамгалах                                     | Бод      | Толгой тутам | 15,000  |
|   |                                                                       | Эх зөгийнд тэмдэг тавих /будгаар/                          |          | эх зөгий     | 6,000   |
|   |                                                                       | Гахайг имнэж дугаарлах                                     |          | толгой тутам | 3,000   |
| 6 | Биотехнологийн дэвшилтэт аргаар мал, амьтанд зохиомол хээлтүүлэг хийх | Гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх               | Бод      | толгой тутам | 80,000  |
|   |                                                                       |                                                            | Бог      |              | 60,000  |
|   |                                                                       | Хүйс жолоодсон үрээр зохиомол хээлтүүлэг хийх              | Бод      | толгой тутам | 180,000 |
|   |                                                                       | Гардан хээлтүүлэг хийх                                     | Бод      | толгой тутам | 20,000  |
|   |                                                                       |                                                            | Бог      |              | 10,000  |
|   |                                                                       | Хөврөл шилжүүлэн суулгах                                   | Бод      | толгой тутам | 800,000 |
|   |                                                                       |                                                            | Бог      |              | 400,000 |
|   |                                                                       | Хээлтүүлэгчээс үр авч шингэлэн зохиомол хээлтүүлэг хийх    | Бод      | толгой тутам | 20,000  |
|   |                                                                       |                                                            | Бог      |              | 12,000  |
|   |                                                                       | Үрийн чанарыг баллаар үнэлэх                               | Бод      | толгой тутам | 6,000   |
|   |                                                                       |                                                            | Бог      |              | 3,500   |
|   |                                                                       | Гахайд зохиомол хээлтүүлэг хийх                            | мэгж     | толгой тутам | 15,000  |
|   |                                                                       | Эх зөгийд зохиомол хээлтүүлэг хийх                         | эх зөгий | толгой тутам | 25,000  |
|   |                                                                       | Гүн хөлдөөсөн үрээр гахайнд зохиомол хээлтүүлэг хийх       | мэгж     | толгой тутам | 30,000  |
|   |                                                                       | Гүн хөлдөөсөн үрээр эх зөгийнд зохиомол хээлтүүлэг хийх    | эх зөгий | толгой тутам | 35,000  |
|   |                                                                       | Өндөр ашиг шимтэй хээлтүүлэгч эр зөгийнөөс үр авч хадгалах | эх зөгий | толгой тутам | 20,000  |
|   |                                                                       | Зөгийн үрийн чанар үнэлэх                                  | эх зөгий | толгой тутам | 7,000   |

|    |                                                                                                                  |                                                  |               |              |        |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|---------------|--------------|--------|
| 7  | Мал, амьтны хээл тодорхойлох                                                                                     | Шулуун гэдсээр                                   | Бод           | толгой тутам | 20,000 |
|    |                                                                                                                  | Тэмтрэх, харах, чагнах аргаар                    | Бод           | толгой       | 2,500  |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 2,000  |
|    |                                                                                                                  | Эхо аппаратаар                                   | Бод           | толгой       | 30,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 15,000 |
|    |                                                                                                                  | Эх зөгийн хээл тодорхойлох                       | эх зөгий      |              | 4,000  |
| 8  | Баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн гарц тогтоох, түүхий эд бүтээгдэхүүнд чанарын үзлэг шинжилгээ хийх | Ноос, ноолуурын гарц, чанар тодорхойлох          | Тэмээ         | 1 дээж       | 7,000  |
|    |                                                                                                                  |                                                  | Сарлаг        | 1 дээж       | 10,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Хонь          | 1 дээж       | 3,000  |
|    |                                                                                                                  |                                                  | Ямаа          | 1 дээж       | 4,000  |
|    |                                                                                                                  | Сүүний гарц, чанар тодорхойлох                   | Бод           | 1 дээж       | 10,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | 1 дээж       | 10,000 |
|    |                                                                                                                  | Зөгийнд үзлэг, заазлалт хийх                     |               | Бүл тутам    | 1,800  |
| 9  | Хээлтүүлэгч малын үржлийн үнэт чанарыг үнэлэх                                                                    | Өсвөр хээлтүүлэгчийг хянан баталгаажуулах        | Бод           | толгой       | 20,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 10,000 |
|    |                                                                                                                  | Удам гарвалаар:                                  | Бод           | толгой       | 35,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 30,000 |
|    |                                                                                                                  | Үр төлөөр:                                       | Бод           | толгой       | 50,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 35,000 |
|    |                                                                                                                  | Ашиг шимээр:                                     | Бод           | толгой       | 50,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 35,000 |
|    |                                                                                                                  | Үржлийн үнэт чанараар:                           | Бод           | толгой       | 50,000 |
|    |                                                                                                                  |                                                  | Бог           | тутам        | 30,000 |
|    |                                                                                                                  | Хээлтүүлэгч эр зөгий болон эх зөгийг сонгож авах | аж ахуй, нэгж |              | 20,000 |
|    |                                                                                                                  | Зөгийн үүлдэр тодорхойлох                        | Бүл тутам     |              | 10,000 |
| 10 | Тэжээлийн чанарт үнэлгээ өгөх                                                                                    | Өвс, сүрэл                                       | 1 дээж        |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Дарш                                             |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Багсармал тэжээл                                 |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Хүчит тэжээл                                     |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Амьтаны гаралтай тэжээл                          |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Эрдэс тэжээл                                     |               |              | 15,000 |
|    |                                                                                                                  | Үйлдвэрийн гаралтай тэжээл                       |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Уураг витаминт тэжээл                            |               |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Бэлчээр хадлангийн ургац тогтоох                 | 100 га        |              | 25,000 |
|    |                                                                                                                  | Нуруулдсан өвсний хэмжээ тогтоох                 | нуруу тутам   |              | 15,000 |
|    |                                                                                                                  |                                                  |               |              |        |

|                                        |                                                                                                   |                                                                    |          |                            |              |
|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|----------|----------------------------|--------------|
|                                        |                                                                                                   | Даршны хэмжээ тогтоох                                              | тн тутам | 15,000                     |              |
|                                        |                                                                                                   | Үйлдвэрийн гаралтай зөгийн тэжээл                                  | 1 дээж   | 4,000                      |              |
| 763                                                                                                             | 51011100 | Хяргасан ноос                                                                                                                                                                                   | кг     |
| 764                                                                                                             | 51011900 | Бусад                                                                                                                                                                                           | кг     |
| 765                                                                                                             | 51012    | Угаасан, карбоны уусмалд цэвэрлээгүй                                                                                                                                                            | кг     |

|     |          |                                                                                                                                     |    |
|-----|----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 766 | 51012100 | Хяргасан ноос                                                                                                                       | кг |
| 767 | 51012900 | Бусад                                                                                                                               | кг |
| 768 | 51013    | Карбоны уусмалд цэвэрлэсэн                                                                                                          | кг |
| 769 | 51013000 | Карбоны уусмалд цэвэрлэсэн                                                                                                          | кг |
| 770 | 5102     | Сэмлээгүй эсвэл самнаагүй, мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс, ноос, хялгас                                                         | кг |
| 771 | 51021    | Мал, амьтны нарийн эс, ноос                                                                                                         | кг |
| 772 | 510211   | Кашмир ноолуурын чиглэлийн ямааны                                                                                                   | кг |
| 773 | 5102111  | Угаагаагүй ноолуур                                                                                                                  | кг |
| 774 | 51021110 | Угаагаагүй ноолуур                                                                                                                  | кг |
| 775 | 5102112  | Угаасан ноолуур                                                                                                                     | кг |
| 776 | 51021120 | Угаасан ноолуур                                                                                                                     | кг |
| 777 | 5102114  | Ямааны завод ноос                                                                                                                   | кг |
| 778 | 51021141 | Ноолуур агууламж нь 120% буюу түүнээс бага                                                                                          | кг |
| 779 | 51021142 | Ноолуур агууламж нь 12,0%-иас их                                                                                                    | кг |
| 780 | 5102115  | Ямааны хялгас                                                                                                                       | кг |
| 781 | 51021150 | Ямааны хялгас                                                                                                                       | кг |
| 782 | 510219   | Бусад                                                                                                                               | кг |
| 783 | 5102193  | Сарлагийн саваг, хөөвөр                                                                                                             | кг |
| 784 | 51021930 | Сарлагийн саваг, хөөвөр                                                                                                             | кг |
| 785 | 5102194  | Тэмээний ноос                                                                                                                       | кг |
| 786 | 51021941 | Угаагаагүй эр ноос                                                                                                                  | кг |
| 787 | 51021942 | Угаасан эр ноос                                                                                                                     | кг |
| 788 | 51021943 | Угаагаагүй эм ноос                                                                                                                  | кг |
| 789 | 51021944 | Угаасан эм ноос                                                                                                                     | кг |
| 790 | 5102195  | Тэмээний завод ноос                                                                                                                 | кг |
| 791 | 51021951 | Ноолуур агууламж нь 220% буюу түүнээс бага                                                                                          | кг |
| 792 | 51021952 | Ноолуур агууламж нь 220%-иас их                                                                                                     | кг |
| 793 | 51021990 | Бусад                                                                                                                               | кг |
| 794 | 51022    | Мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас                                                                                                 | кг |
| 795 | 51022040 | Үхрийн хөөвөр                                                                                                                       | кг |
| 796 | 51022050 | Адууны хөөвөр                                                                                                                       | кг |
| 797 | 51022090 | Бусад                                                                                                                               | кг |
| 798 | 5103     | Хонины хаягдал ноос эсвэл мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгасны хаягдал, ээрмэлийн хаягдал (сэргээсэн сэмэрдэс орохгүй) | кг |
| 799 | 51031    | Хонины ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосны самнуурын сэв                                                                        | кг |
| 800 | 51031000 | Хонины ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосны самнуурын сэв                                                                        | кг |
| 801 | 51032    | Хонины бусад хаягдал ноос буюу мал, амьтны нарийн үс, ноосны бусад хаягдал                                                          | кг |
| 802 | 5103201  | Ямааны ноолуурын сэв хялгас                                                                                                         |    |

|     |          |                                                                                                                         |    |
|-----|----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 803 | 51032011 | Ноолуурын агууламж нь 120% буюу түүнээс бага                                                                            | кг |
| 804 | 51032012 | Ноолуурын агууламж нь 120%-иас их                                                                                       | кг |
| 805 | 5103202  | Тэмээний ноосны сэв хялгас                                                                                              |    |
| 806 | 51032021 | Ноолуур агууламж нь 220% буюу түүнээс бага                                                                              | кг |
| 807 | 51032022 | Ноолуур агууламж нь 220%-иас их                                                                                         | кг |
| 808 | 5103209  | Бусад                                                                                                                   |    |
| 809 | 51032090 | Бусад                                                                                                                   | кг |
| 810 | 51033    | Мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгасны хаягдал                                                                           |    |
| 811 | 51033000 | Мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгасны хаягдал                                                                           | кг |
| 812 | 5104     | Хонины ноосны эсвэл мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгасны сэргээсэн сэмэрдэс                                |    |
| 813 | 51040000 | Хонины ноосны эсвэл мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгасны сэргээсэн сэмэрдэс                                | кг |
| 814 | 5105     | Сэмлэсэн эсвэл самнасан, хонины ноос буюу мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс, ноос, хялгас (самнасан тайрмал ноос орно) | кг |
| 815 | 51051    | Сэмлэсэн (анхан шатны бүдүүн самналт хийсэн) хонины ноос                                                                | кг |
| 816 | 51051000 | Сэмлэсэн (анхан шатны бүдүүн самналт хийсэн) хонины ноос                                                                | кг |
| 817 | 51052    | Хонины ноосон топс болон бусад самнасан ноос                                                                            |    |
| 818 | 510521   | Самнасан тайрмал ноос                                                                                                   |    |
| 819 | 51052100 | Самнасан тайрмал ноос                                                                                                   | кг |
| 820 | 510529   | Бусад                                                                                                                   |    |
| 821 | 51052910 | Ноосон топс                                                                                                             | кг |
| 822 | 51052990 | Бусад                                                                                                                   | кг |
| 823 | 51053    | Сэмлэсэн эсвэл самнасан, мал, амьтны нарийн үс, ноос                                                                    | кг |
| 824 | 510531   | Кашмир ноолуурын чиглэлийн ямааны                                                                                       | кг |
| 825 | 51053110 | Самнасан ноолуур                                                                                                        | кг |
| 826 | 51053120 | Бөмбөгөн ноолуур                                                                                                        | кг |
| 827 | 51053130 | Дахин боловсруулсан богино ноолуур                                                                                      | кг |
| 828 | 510539   | Бусад                                                                                                                   | кг |
| 829 | 5105391  | Тэмээний ноос                                                                                                           | кг |
| 830 | 51053911 | Самнасан ноос                                                                                                           | кг |
| 831 | 51053912 | Бөмбөгөн ноос /топс/                                                                                                    | кг |
| 832 | 5105399  | Бусад                                                                                                                   |    |
| 833 | 51053990 | Бусад                                                                                                                   | кг |
| 834 | 51054    | Сэмлэсэн эсвэл самнасан, мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас                                                            | кг |
| 835 | 51054000 | Сэмлэсэн эсвэл самнасан, мал, амьтны бүдүүн үс, ноос, хялгас                                                            | кг |
| 836 | 5106     | Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл                                              | кг |
| 837 | 51061000 | Жингийн 85% буюу түүнээс их ноос агуулсан                                                                               | кг |

|     |          |                                                                                                           |                   |
|-----|----------|-----------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| 838 | 51062000 | Жингийн 85%-иас бага ноос агуулсан                                                                        | кг                |
| 839 | 5107     | Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, хонины сэмлэсэн ноосон ээрмэл                                | кг                |
| 840 | 51071000 | Жингийн 85% буюу түүнээс их ноос агуулсан                                                                 | кг                |
| 841 | 51072000 | Жингийн 85%-иас бага ноос агуулсан                                                                        | кг                |
| 842 | 5108     | Жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, мал, амьтны нарийн үс, ноосон сэмлэсэн эсвэл самнасан ээрмэл | кг                |
| 843 | 51081000 | Сэмлэсэн                                                                                                  | кг                |
| 844 | 51082000 | Самнасан                                                                                                  | кг                |
| 845 | 95081000 | Явуулын цирк, явуулын амьтны хүрээлэн                                                                     | Толгой/<br>ширхэг |

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7441 дүгээрт бүртгэв.

## **ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар А/866

Мандалговь

### **СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, 16.2.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Сар бүрийн 01,15-ны өдрүүдэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг хориглосугай.

2.Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү захирамжийг холбогдох хууль, журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Энхмандал)-т, тухайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (М.Чинбат), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Гарсан шийдвэртэй холбогдуулан Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/628 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Ариунбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.МӨНХЧУЛУУН

*Аймгийн Засаг даргын 2025 оны  
11 дүгээр сарын 11-ний өдрийн  
А/866 дугаар захирамжийн хавсралт*

| № | Худалдаа, үйлчилгээний төрөл                                                                             | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарь |          |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------|
|   |                                                                                                          | Эхлэх цаг                                                   | Хаах цаг |
| 1 | Согтууруулах ундаа худалдах цагийн хуваарь                                                               | 09:00                                                       | 23:00    |
| 2 | Согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарь (ресторан, паб, зоогийн газар, кафе, баар, лоунж, караоке) | 11:00                                                       | 22:00    |
|   |                                                                                                          | 14:00                                                       | 02:00    |

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7442 дугаарт бүртгэв.

## **ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар VI/28

Бүрэнтогтох сум

### **ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧЭЭС АВАХ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62 дугаар зүйлийн 62.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан “Аргачлал батлах тухай” 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралт, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 1/1654 албан бичгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдал үүсгэгчээс авах хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдал үүсгэгчээс авах хураамжийг батлагдсан тарифын дагуу иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний газраас төлбөр хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, зохих журмын дагуу зарцуулж хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Л.Аззаяа), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Татварын Улсын байцаагч (С.Цэрмаа) нарт даалгасугай.

3.Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн улсын бүртгэл”-д бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

М.ЭСМЭДЭХ

*Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит  
VI хуралдааны 28 дугаар тогтоолын хавсралт*

**ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭСНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

| № | Хог хаягдал үүсгэгч эх<br>үүсвэр | Хугацаа                              | Сард төлөх<br>хураамж /төг/ | Нийт төлөх<br>хураамжийн дүн |
|---|----------------------------------|--------------------------------------|-----------------------------|------------------------------|
| 1 | 2                                | 3                                    | 4                           | 5                            |
| 1 | Иргэн бүр                        | Сар бүр                              | 300                         | 3600                         |
| 2 | Байгууллага, аж ахуй нэгж        | Сар бүр                              | 7000                        | 84000                        |
| 3 | Уурын зуух                       | 9 сарын 15-наас 5<br>сарын 15 хүртэл | 100000                      | 800000                       |

## **ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар  
хот

### **ДОРНОД АЙМГИЙН “ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ” ОНӨААТҮГ- ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ /Г.Амарбаясгалан/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ /Г.Амарбаясгалан/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах хорооны 2022 оны 186 дугаар тогтоолыг заасан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ  
Д.АНХБАТ  
Ц.БАТЗАЯА  
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татнуургаын ашиглалт,  
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны  
өдрийн дугаар тогтоолын хавсралт*

**Дорнод аймгийн “Дорнод нийтийн аж ахуй” ОНӨААТҮГ-ын  
цэвэр, бохир усны үйлчилгээний тариф**

Нэг. Айл өрх  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                | Хэмжих нэгж | Тариф |
|----------|----------------|-------------|-------|
| Цэвэр ус | Тоолууртай     | төг/л       | 2.6   |
|          | Тоолуургүй     | төг/л       | 3.2   |
|          | Ус түгээх байр | төг/л       | 2.6   |
| Бохир ус | Тоолууртай     | төг/л       | 2.1   |
|          | Тоолуургүй     | төг/л       | 3.1   |

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                                                         | Хэмжих нэгж | Тариф |
|----------|---------------------------------------------------------|-------------|-------|
| Цэвэр ус | Бусад ҮААНБ                                             | төг/л       | 5.9   |
|          | Төсөвт байгууллага                                      | төг/л       | 7.3   |
|          | Спирт, архи, пиво, усны үйлдвэр, машин угаалга          | төг/л       | 8.4   |
|          | Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр | төг/л       | 7.6   |
| Бохир ус | Бусад ҮААНБ                                             | төг/л       | 5.6   |
|          | Төсөвт байгууллага                                      | төг/л       | 5.9   |
|          | Спирт, архи, пиво, усны үйлдвэр, машин угаалга          | төг/л       | 8.4   |
|          | Ноос ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр | төг/л       | 7.6   |

## **ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар  
хот

### **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН “ЭМТ НАРАН” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Эмт наран” ОНӨААТҮГ /Л.Янжинлхам/-т үүрэг болгосугай.

3. Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эмт наран” ОНӨААТҮГ /Л.Янжинлхам/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах хорооны 2017 оны 72 дугаар тогтоолыг дээр дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ  
Д.АНХБАТ  
Ц.БАТЗАЯА  
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,  
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны  
өдрийн 119 дүгээр тогтоолын хавсралт*

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН “ЭМТ НАРАН”  
ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

Нэг. Айл өрх  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                | Хэмжих нэгж | Тариф |
|----------|----------------|-------------|-------|
| Цэвэр ус | Тоолууртай     | төг/л       | 2.0   |
|          | Тоолуургүй     | төг/л       | 2.4   |
|          | Ус түгээх байр | төг/л       | 2.0   |
| Бохир ус | Тоолууртай     | төг/л       | 2.0   |
|          | Тоолуургүй     | төг/л       | 2.4   |

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                                          | Хэмжих нэгж | Тариф |
|----------|------------------------------------------|-------------|-------|
| Цэвэр ус | Бусад үйлдвэр аж, ахуйн нэгж байгууллага | төг/л       | 2.5   |
|          | Төсөвт байгууллага                       | төг/л       | 3.0   |
| Бохир ус | Бусад үйлдвэр аж, ахуйн нэгж байгууллага | төг/л       | 2.5   |
|          | Төсөвт байгууллага                       | төг/л       | 3.0   |

## **ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар  
хот

### **ДОРНОГОВЬ АЙМГИЙН “ЧАНДМАНЬ-ИЛЧ” ХХК-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн “Чандмань-Илч” ХХК-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэний дараах сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Чандмань-Илч” ХХК /Д.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Чандмань-Илч” ХХК /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах хорооны 2023 оны 54 дүгээр тогтоолыг заасан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ  
Д.АНХБАТ  
Ц.БАТЗАЯА  
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,  
үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны  
өдрийн 121 дугаар тогтоолын хавсралт*

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН “ЧАНДМАНЬ-ИЛЧ”ХХК-ИЙН ЦЭВЭР,  
БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

Нэг. Айл өрх  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                                   | Хэмжих нэгж | Тариф |
|----------|-----------------------------------|-------------|-------|
| Цэвэр ус | Тоолууртай                        | төг/л       | 3.0   |
|          | Тоолуургүй                        | Төг/л       | 4.0   |
|          | Ус түгээх байр                    | төг/л       | 3.0   |
| Бохир ус | Тоолууртай                        | төг/л       | 2.8   |
|          | тоолуургүй                        | төг/л       | 4.0   |
|          | Бохир ус зөөврөөр татан зайлуулах | төг/л       | 13    |

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                                                         | Хэмжих нэгж | Тариф |
|----------|---------------------------------------------------------|-------------|-------|
| Цэвэр ус | Бусад ҮААНБ                                             | төг/л       | 7.0   |
|          | Төсөвт байгууллага                                      | төг/л       | 8.0   |
|          | Спирт, архи, пиво, усны үйлдвэр, машин угаалга          | төг/л       | 10.0  |
|          | Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад зөөврөөр            | төг/л       | 13    |
| Бохир ус | Бусад ҮААНБ                                             | төг/л       | 7.0   |
|          | Төсөвт байгууллага                                      | төг/л       | 8.0   |
|          | Спирт, архи, пиво, усны үйлдвэр, машин угаалга          | төг/л       | 10.0  |
|          | ҮААНБ-ын хэрэглэгчийн зөөврөөр бохир ус татан зайлуулах | төг/л       | 13    |

## **ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар  
хот

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “ТАЛЫН ИЛЧ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говьсүмбэр аймгийн “Талын илч” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн хугацааны дараа сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажиллахыг “Талын илч” ОНӨААТҮГ /Б.Энхтүвшин/-т даалгасугай.

3.Ус хангамж, ариутгах татуургын үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд хяналт тавьж, үргүй зардал, усны алдагдлыг бууруулж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Талын илч” ОНӨААТҮГ /Б.Энхтүвшин/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Зохицуулах зөвлөлийн 2020 оны 24 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг энэхүү тогтоолын 2 дахь заалтад заасан хугацаанаас эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ  
Д.АНХБАТ  
Ц.БАТЗАЯА  
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,  
үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ний  
өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт*

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “ТАЛЫН ИЛЧ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР,  
БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ**

Нэг. Хүн ам  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                      | Хэмжих нэгж | Тариф |
|----------|----------------------|-------------|-------|
| Цэвэр ус | Айл өрх /тоолууртай/ | төг/л       | 1.50  |
|          | Айл өрх /тоолуургүй/ | төг/л       | 4.50  |
| Бохир ус | Айл өрх /тоолууртай/ | төг/л       | 1.00  |
|          | Айл өрх /тоолуургүй/ | төг/л       | 1.50  |

Хоёр. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага  
(НӨАТ-гүй)

| Ангилал  |                    | Хэмжих нэгж | Тариф |
|----------|--------------------|-------------|-------|
| Цэвэр ус | ААНБайгууллага     | төг/л       | 7.50  |
|          | Төсөвт байгууллага | төг/л       | 8.50  |
| Бохир ус | ААНБайгууллага     | төг/л       | 6.00  |
|          | Төсөвт байгууллага | төг/л       | 6.50  |

## **ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар А/313

Улаанбаатар  
хот

### **ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах Иргэний нисэхийн дүрэм “ИНД-11 Иргэний нисэхийн дүрэм боловсруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх”-ийг нэгдүгээр хавсралтаар, “ИНД-13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Иргэний нисэхийн дүрмийг мөрдөж, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр), энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар (З.Туяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны “Дүрэм батлах тухай” 160 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын  
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн  
А/313 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

## **ИНД - 11 Иргэний нисэхийн дүрэм боловсруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх**

### **А Бүлэг - Ерөнхий зүйл**

#### **11.1. Зорилго**

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

- (1) Иргэний нисэхийн дүрэм шинээр боловсруулах;
- (2) Иргэний нисэхийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- (3) Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх;
- (4) Иргэний нисэхийн дүрэм хүчингүй болгох.

#### **11.3. Олон улсын стандарт шаардлага**

(а) Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын хэлэлцэн тохиролцогч улсын хувьд энэхүү Конвенцын 37 дугаар зүйлийн дагуу олон улсын стандартад нийцсэн, иргэний нисэхийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын дүрэмтэй байна.

(б) Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) нь Конвенцын Хавсралтад нийцүүлэн иргэний нисэхийн дүрмийг энэ дүрэм болон бусад хууль тогтоомжийн дагуу боловсруулна.

(с) Хэрэв иргэний нисэхийн дүрэм нь олон улсын стандарт шаардлагад бүрэн нийцээгүй бол Дарга зөрүүтэй байдлыг тодорхойлж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад зохих журмын дагуу мэдээлнэ.

(д) Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу Конвенцын Хавсралт 13-т нийцүүлэн дүрэм боловсруулахыг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага (цаашид “АХОЗШШБ” гэх) хариуцна.

#### **11.5. Дүрмийн бүртгэл**

(а) Дүрэм боловсруулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт болон дүрэмд хамааралтай бусад мэдээлэл нь Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “ИНЕГ” гэх)-ын дүрмийн боловсруулалт хариуцсан нэгжид бүртгэгдэнэ.

(б) Энэ зүйлийн (а)-д дурдсан бүртгэлд дараах баримт бичиг хамаарна:

(1) дүрэм боловсруулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрэм хүчингүй болгох болон дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт;

(2) дүрэм боловсруулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийн үндэслэл, тайлбар;

(3) хүсэлтийн хариу;

(4) дүрэм боловсруулахтай холбогдуулан цуглуулсан санал;

(5) дүрмийн шаардлагаас чөлөөлөх тухай шийдвэр, түүнд хамаарах нөхцөл.

### **11.7. Зөвлөмжийн цуврал**

(а) Дарга иргэний нисэхийн дүрмийн хэрэглээ болон дүрмийг хэрэгжүүлэх талаарх тайлбар, зааврыг агуулсан Зөвлөмжийн цувралыг батална.

(b) Дарга Зөвлөмжийн цувралаар дүрмийн тайлбар, заавраас гадна дүрмийн заалтыг хэрэгжүүлэх аливаа этгээдийн дагаж мөрдөх үйл ажиллагааны болон техникийн шаардлагыг тогтоож болно.

(с) Дарга энэ зүйлийн (b)-д заасны дагуу үйл ажиллагааны болон техникийн шаардлага тогтоосон тохиолдолд тухайн Зөвлөмжийн цувралд энэ талаар тодорхой заасан байна.

### **11.9. Дүрмийн боловсруулалт хариуцсан нэгжийн үйл ажиллагаа**

(а) Дүрмийн боловсруулалт хариуцсан нэгж нь энэхүү дүрмийн шаардлага болон Даргын баталсан Үйл ажиллагааны зааврын дагуу дүрэм боловсруулах үйл явцыг хариуцна.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан дүрмийн боловсруулалт хариуцсан нэгжийн Үйл ажиллагааны заавар дараах мэдээлэл болон журмыг тусгасан байна:

(1) дүрмийн төслийн ерөнхий бүтэц;

(2) дүрэм шинээр боловсруулж батлуулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх, дүрэм хүчингүй болгох дэлгэрэнгүй үйл явц, хугацаа, чиг үүргийг тодорхой заасан байх;

(3) нөлөөллийн шинжилгээ, үнэлгээ хийх журам;

(4) энэ дүрмийн 11.5(b)-д заасан бүртгэл хөтлөх журам.

### **В Бүлэг - Дүрэм боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах**

#### **11.51. Дүрэм боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах**

(а) Иргэн, хуулийн этгээд нь агаарын зайг хуваарилах, ашиглах дүрэм болон Нислэгт тэнцэх чадварын удирдамж (цаашид “AD” гэх)-аас бусад иргэний нисэхийн аливаа дүрэм боловсруулах санал гаргаж болно.

(b) Дараах тохиолдолд дүрэм шинээр боловсруулах, эсхүл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болно:

(1) Конвенц, түүний Хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох дүрэмд тусгах шаардлагатай гэж үзсэн;

(2) АХОЗШШБ-аас гаргасан аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу холбогдох дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн;

(3) иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа болон иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцож байгаа аливаа этгээдийн санал, хүсэлтийн дагуу холбогдох дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж Дарга үзсэн.

#### **11.53. Хүсэлт гаргах**

(а) Иргэн, хуулийн этгээд нь агаарын зайг хуваарилах, ашиглах дүрэм болон АД-аас бусад дүрэм шинээр боловсруулах, мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хүчингүй болгох тухай хүсэлтийг САА 24011/01 маягтын дагуу гаргаж, Даргад хүргүүлнэ:

(b) Хүсэлтэд дараах зүйлийг тусгасан байна:

(1) хүсэлт гаргагчийн нэр, хаяг;

(2) шинээр дүрэм боловсруулах, эсхүл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлага;

(3) нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох дүрмийн заалт;

(4) дүрмийг хүчингүй болгох үндэслэл, шаардлага;

(5) хүсэлтийг нотолсон аливаа мэдээлэл, санал, баримт нотолгоо.

#### **11.55. Хүсэлтийг шийдвэрлэх**

(а) Дарга шинээр дүрэм боловсруулах, эсхүл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг судалж, үнэлгээ хийсний үндсэн дээр шаардлагатай гэж үзвэл шинээр дүрмийн төсөл боловсруулах, эсхүл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлийг дүрмийн боловсруулалт хариуцсан нэгжид өгнө.

(b) Дүрмийг хүчингүй болгох тухай хүсэлтийг Дарга, тухайн дүрмийн хэрэгжилт болон бусад дүрэм, журам, баримт бичигтэй зөрчилдөх эсэх, нийтийн ашиг сонирхлыг хөндөж байгаа зэрэгт эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

#### **11.57. Дүрмийн төсөл боловсруулах**

(а) Дүрмийн боловсруулалт хариуцсан нэгж нь дүрэм шинээр боловсруулах, эсхүл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж Дарга үзсэн тохиолдолд шинэ дүрмийн, эсхүл дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг энэ дүрмийн 11.59-ийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, Даргад танилцуулна.

(b) Дүрмийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг ИНЕГ хариуцна.

### **11.59. Дүрмийн төсөлд тавигдах шаардлага**

(а) Шинэ дүрмийн, эсхүл дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) иргэний нисэхийн тухай олон улсын гэрээ, хууль болон бусад дүрмийн заалтуудтай уялдсан байх;

(2) тухайн дүрмийн агуулга, зорилго, үйлчлэх хүрээнд нийцсэн байх;

(3) хууль, бусад дүрэмд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх, нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх.

(b) Дүрмийн төсөлд ИНД-1 Нэр томъёоны тайлбарт тусгагдаагүй шинэ нэр томъёо хэрэглэсэн бол нэр томъёоны тайлбар хийнэ.

(c) Дараах тохиолдолд нэр томъёог гадаад хэл дээр хэрэглэж болно:

(1) нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

(2) нэр томъёог иргэний нисэхийн асуудлаарх олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

### **11.61. Дүрмийн төсөлд санал өгөх**

(а) Дарга шинээр боловсруулсан дүрмийн, эсхүл нэмэлт өөрчлөлтийн төслийг сонирхож буй аливаа этгээдийг дүрмийн төсөлд санал өгөх бололцоогоор хангана.

(b) Дүрмийн төслийг сонирхож буй аливаа этгээд төсөлд өгөх саналаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр Даргад хүргүүлж болно.

(c) Тухайн дүрмийн зохицуулалт нь үйл ажиллагаанд нь шууд хамааралтай аливаа этгээдийн саналыг заавал авсан байна.

### **11.63. Дүрмийг батлах, хэвлэх**

(а) Дарга дүрмийн төслийг боловсруулсны дараа Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж батлуулна.

(b) Батлагдсан дүрмийг холбогдох эрх зүйн мэдээллийн сангийн бүртгэлд бүртгүүлж, ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулна.

### **11.65. Дүрмийг хүчингүй болгох**

(а) Хүчингүй болсонд тооцож байгаа дүрмийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг тодорхой бичнэ.

(b) Дарга тухайн дүрмийг хүчингүй болгох үндэслэл, шаардлага, судалгаа зэргийг үндэслэлтэй гэж үзвэл дүрмийг хүчингүй болгох тухай хүсэлтийг холбогдох материалын хамт Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

(c) Хүчингүй болсон дүрмийн заалтын дугаарыг дараагийн заалтад шилжүүлэхгүй бөгөөд дугаарыг хэвээр үлдээн “Хүчингүй болгосон”

тэмдэглэгээ тавина.

(d) Бүхлээрээ хүчингүй болсон дүрмийг эрх зүйн мэдээллийн сангийн бүртгэлээс хасуулж, мэдээллийг ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулна.

### **С Бүлэг - Дүрмийн шаардлагаас чөлөөлөх**

#### **11.101. Дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх тухай хүсэлт**

(a) Дүрмийн тухайн заалтыг заавал биелүүлэхээр тусгайлан заагаагүй бол аливаа этгээд дүрмийн холбогдох шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийг дүрмийн шаардлагаас чөлөөлөгдөхөөр товлосон хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө САА 24011/02 маягтын дагуу гаргаж Даргад хүргүүлнэ.

(b) Хүсэлтэд дараах зүйлийг тусгасан байна:

(1) хүсэлт гаргагчийн нэр, хаяг;

(2) дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх үндэслэл, шаардлага, хугацаа;

(3) чөлөөлүүлэх дүрмийн заалтын цар хүрээ, өргөдөлд хамрагдсан бие хүн, агаарын хөлөг, түүнд хамаарах бүтээгдэхүүн, аэродром, нисэхийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний тухай танилцуулга, тайлбар болон тухайн хүсэлтийг дэмжсэн аливаа мэдээлэл, санал, баталгаа;

(4) холбогдох бусад зүйл.

#### **11.103. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх**

(a) Хууль болон дүрэмд тусгайлан заагаагүй бол, дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийг судалсны үндсэн дээр тухайн дүрмийн шаардлагаас чөлөөлснөөр нисэхийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтад сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга хүсэлт гаргагчийг дүрмийн шаардлагаас чөлөөлөх шийдвэр гаргаж болно.

(b) Аливаа хувь хүн, агаарын хөлөг, түүнд хамаарах бүтээгдэхүүн, аэродром, нисэхийн үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээг дүрмийн шаардлагаас чөлөөлсөн тухай Даргын шийдвэр нь зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчинтэй байна.

(c) Даргын шийдвэрт дүрмийн шаардлагаас чөлөөлөгдсөн хугацаанд нисэхийн аюулгүй байдлын талаар хүсэлт гаргагчийн мөрдөж ажиллах нөхцөлийг тодорхой заасан байна.

(d) Хэрэв дүрмийн шаардлагаас чөлөөлснөөр нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтад сөргөөр нөлөөлнө гэж үзвэл Дарга нь тухайн этгээдийг дүрмийн шаардлагаас чөлөөлөхөөс татгалзаж, энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

(e) Дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийн талаар Даргын гаргасан шийдвэрийг ИНЕГ-ын цахим хуудсаар мэдээлэх ба мэдээлэлд

дараах зүйлийг тусгасан байна:

(1) хүсэлт гаргагчийн нэр, хаяг;

(2) чөлөөлүүлэхийг хүссэн дүрмийн заалт;

(3) дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийн товч танилцуулга;

(4) Даргын гаргасан шийдвэр (зөвшөөрсөн, эсхүл татгалзсан), түүний үндэслэл.

(f) Энэ зүйлийн (a) заалт нь ИНД-67 Эрүүл мэндийн гэрчилгээ болон стандарт дүрэмд хамаарахгүй.

**11.105. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх хугацаа**

(a) Дарга нь аливаа этгээдийг дүрмийн шаардлагаас 12 сар хүртэл хугацаагаар чөлөөлнө.

(b) Дүрмийн шаардлагаас чөлөөлүүлсэн этгээд нь энэ зүйлийн (a)-д заасан хугацааг сунгуулахаар дахин хүсэлт гаргасан тохиолдолд Даргын шийдвэрээр 3 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно.

**11.107. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг баталгаажуулах**

(a) Дүрмийн шаардлагаас чөлөөлөх тухай Даргын шийдвэрийг мөрдөж эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө холбогдох үндэслэл, тайлбарын хамт Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, зөвшөөрөл авч баталгаажуулна.

(b) Дүрмийн шаардлагаас чөлөөлөх тухай Даргын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шийдвэрийг цуцлах талаар ИНЕГ-т мэдэгдэнэ.

*Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны  
өдрийн А/313 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

## **ИНД - 13 Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх**

### **А Бүлэг - Ерөнхий зүйл**

#### **13.1. Зорилго**

(а) Энэ дүрмээр Иргэний нисэхийн тухай хууль (цаашид “хууль” гэх), иргэний нисэхийн дүрэм (цаашид “дүрэм” гэх)-ийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүүд албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах замаар нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг хангуулахад дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.

#### **13.3. Нэр томьёо ба товчлол**

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

#### **13.5. Хамрах хүрээ**

(а) Нисэхийн баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээдийн хууль, дүрмийн шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүүд Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) энэ дүрмийн дагуу тохирсон, үр дүнтэй албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

(б) Нисэхийн баримт бичиг эзэмшигч хуулийн этгээдийн нэрийн өмнөөс дүрэмд заасан чиг үүргийн хүрээнд ажил, үүрэг гүйцэтгэж буй ажилтан нь хууль, дүрмийн шаардлагыг зөрсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдэд энэ дүрэмд заасан албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

#### **13.7. Албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах үндэслэл**

(а) Хууль, дүрмийн дагуу олгосон нисэхийн баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээдэд Дарга дараах үндэслэлээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авч болно:

- (1) хууль болон дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй;
- (2) хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;
- (3) нисэхийн аюулгүй байдалд эрсдэл дагуулах нөхцөл байдал үүссэн;
- (4) гэрчилгээ эзэмшигч хүн, хуулийн этгээд нь нислэгийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хангаж чадахгүй болсон, эсхүл болзошгүй гэж үзвэл;
- (5) энэ дүрмийн 13.51(а)(1)-д заасан зөвлөмж, шаардлагыг биелүүлээгүй;

(6) үнэмлэх, гэрчилгээгээр олгосон эрх, зөвшөөрлийн нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн;

(7) дүрмээр шаардсан бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй;

(8) эрх бүхий хяналтын байцаагчийг агаарын хөлөг, түүний эд анги, барилга байгууламж, талбай болон бүртгэлд үзлэг шалгалт хийх зорилгоор нэвтрэхэд саад болсон, эсхүл үндэслэл бүхий шалтгаанаар татгалзсан;

(9) үндсэн үйл ажиллагааны баримт бичиг, тайлан болон бүртгэлийг хуурамчаар үйлдсэн, эсхүл засварласан, нөхөн үйлдсэн;

(10) албан үүрэг гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн.

(b) Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын Хавсралт 19-ийн дагуу аюулгүй байдлын өгөгдөл дамжуулах тогтолцооны хүрээнд нууцаар, эсхүл сайн дураар дамжуулсан мэдээллийг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах үндэслэл болгохгүй бөгөөд зөвхөн тухайн мэдээллийн дагуу хийгдсэн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

(c) Хяналт шалгалтаар илэрсэн үл нийцэл, дутагдал нь тухайн байгууллага аюулгүй байдлын удирдлагын тогтолцооныхоо хүрээнд илрүүлж, эрсдэлийг үнэлэн, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа, эсхүл тухайн үл нийцэл, дутагдалд хамаарах хууль, дүрмийн заалтыг өөр хэлбэрээр, илүү үр дүнтэй аргаар хангасныг Дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авахгүй байж болно.

### **13.9. Албадан хэрэгжүүлэх арга хэмжээний зарчим**

(a) Дарга энэ дүрмийн дагуу албадан хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

(1) хууль, дүрмийг сайн дурын үндсэн дээр байнга даган мөрддөг байх соёлыг дэмжих;

(2) хууль, дүрмийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтын үйл ажиллагааг ил тод, шударгаар хэрэгжүүлэх;

(3) болзошгүй осол, зөрчлийг эрт илрүүлэх, давтан гарахаас урьдчилан сэргийлэх;

(4) хяналт шалгалтын явцад гарсан үл нийцэл, дутагдал бүрд тохирсон албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг байх;

(5) тэнцвэртэй байх, ижил төстэй зөрчилд ижил төрлийн албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

(6) хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

(7) хувийн ашиг сонирхлоос ангид байж, гадны нөлөөнд үл автах;

(8) хүйс, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоор ялгаварлахгүй байх.

(б) Эрх бүхий хяналтын байцаагч албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авахдаа зөвхөн тухайн нөхцөл байдалд үндэслэхгүйгээр, илэрсэн үл нийцэл, дутагдал гарах болсон шалтгаан нөхцөл болон үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдийн зөрчлийн түүх зэргийг харгалзан үзэх зарчмыг баримтална.

### **В Бүлэг - Албадан хэрэгжүүлэх арга хэмжээ**

#### **13.51. Албадан хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл**

(а) Дарга энэ дүрмийн 13.7-д заасан үндэслэлээр, тухайн зөрчлийн шинж чанар, үр дагавраас хамааруулан дараах төрлийн албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

(1) хяналт шалгалтын дагуу авах арга хэмжээ:

(i) зөвлөмж өгөх;

(ii) сануулга өгөх;

(iii) үл нийцэл, дутагдлыг залруулах хугацаат үүрэг өгөх;

(iv) албан шаардлага хүргүүлэх;

(v) үл нийцэл, дутагдлыг арилгах хүртэл ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох;

(2) шийтгэл оногдуулах;

(3) иргэний нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлэх;

(4) иргэний нисэхийн баримт бичгийг хүчингүй болгох.

#### **13.53. Хяналт шалгалтын дагуу авах арга хэмжээ**

(а) Дарга хяналт шалгалтын явцад илэрсэн үл нийцэл, дутагдалд тохирсон дараах арга хэмжээний аль нэгийг авна:

(1) Зөвлөмж өгөх – Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг дээшлүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх;

(2) Сануулга өгөх – Хяналт, зохицуулалтын хүрээнд тухайн үйлдэл, эсхүл эс үйлдэхүй нь зөрчилд хүргэж болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх сануулга өгөх;

(3) Үл нийцэл, дутагдлыг залруулах хугацаат үүрэг өгөх – Хяналт шалгалт, шинжлэн шалгах ажиллагаагаар илэрсэн үл нийцэл, дутагдал нь Зөрчлийн тухай хуульд хамаарахгүй бол иргэний нисэхийн хяналтын байцаагч нь дүгнэлт гаргаж, үл нийцэл, дутагдлыг залруулах хугацаат үүрэг өгөх;

(4) Албан шаардлага хүргүүлэх – Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэх.

(5) Ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох – Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь аливаа хэлбэрээр нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд тухайн этгээдийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох.

(с) Дарга энэ зүйлийн (b)(5)-д заасан арга хэмжээний хүрээнд, иргэний нисэхийн байгууламжийн үйл ажиллагааг зогсоох бол шийдвэр гарахаас нэгээс доошгүй хоногийн өмнө холбогдох байгууллагад албан бичгээр урьдчилан мэдэгдэх ба Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагаар дамжуулан зарлуулах арга хэмжээг авсан байна.

(d) Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн дүгнэлтэд тусгасан зөвлөмж, шаардлагыг холбогдох хүн, хуулийн этгээд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй зөрчилд Дарга шийтгэл оногдуулна.

### **13.55. Шийтгэл оногдуулах**

(а) Хууль, дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуульд шийтгэл оногдуулахаар заасан бол иргэний нисэхийн хяналтын байцаагч шийтгэл оногдуулна.

### **13.57. Иргэний нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлэх**

(а) Дарга дараах үндэслэлээр хууль, дүрмийн дагуу хүн, хуулийн этгээдэд олгосон нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлнэ:

(1) энэ дүрмийн 13.7-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн бол;

(2) зөрчилд шийтгэл оногдуулсан боловч зөрчил үргэлжилсэн хэвээр бол;

(3) эрх олгосон баримт бичгийг үргэлжлүүлэн ашиглах нь нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтад аюул учруулж болзошгүй.

(b) Дарга нисэхийн баримт бичгийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

(1) иргэний нисэхийн хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх хүртэл;

(2) Даргын тогтоосон хугацаагаар.

(с) Энэ зүйлийн (b)-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна.

(d) Энэ зүйлийн (a)(3)-д зааснаас бусад тохиолдолд, Дарга нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээдэд бичгээр хүргүүлж, тайлбар гаргах боломжийг олгоно.

(е) Нисэхийн баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээд энэ зүйлийн (d)-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор баримт бичгийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж

үзсэн тухай тайлбараа Даргад бичгээр ирүүлээгүй бол баримт бичгийг түдгэлзүүлнэ.

(ф) Дарга нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлсэн шийдвэрийг тухайн баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх бөгөөд түдгэлзүүлсэн үндэслэл, хугацааг тусгасан байна.

(г) Хамааралтай бол, хувь хүн үнэмлэх, гэрчилгээг хураалгахаас татгалзсан тохиолдолд Дарга шийдвэрээ тухайн ажил олгогч байгууллагад хүргүүлнэ.

(х) Түдгэлзүүлсэн баримт бичгийн эрхийг сэргээх хүртэл аливаа этгээд нь тухайн баримт бичгээр олгосон, түүнд хавсаргасан эрхийг эдлэхгүй.

(и) Нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн хүн, хуулийн этгээд зөрчлөө арилгаагүй бол Дарга баримт бичгийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

### **13.59. Нисэхийн баримт бичгийг хүчингүй болгох**

(а) Дарга дараах үндэслэлээр хууль, дүрмийн дагуу хүн, хуулийн этгээдэд олгосон нисэхийн баримт бичгийг хүчингүй болгоно:

(1) нисэхийн баримт бичиг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

(2) баримт бичгээр олгосон эрх, зөвшөөрлийн нөхцөл, хязгаарлалтыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;

(3) баримт бичгийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

(б) Дарга нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын шаардлагаар яаралтай арга хэмжээ авахаас бусад тохиолдолд нисэхийн баримт бичгийг хүчингүй болгох үндэслэлийг заасан мэдэгдлийг баримт бичиг эзэмшигч хуулийн этгээдэд бичгээр хүргүүлж, тайлбар гаргах боломжийг олгоно.

(с) Нисэхийн баримт бичиг эзэмшигч хуулийн этгээд энэ зүйлийн (б)-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор баримт бичгийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Даргад бичгээр ирүүлээгүй бол баримт бичгийг хүчингүй болгоно.

(д) Дарга нисэхийн баримт бичгийг хүчингүй болгосон шийдвэрийг тухайн баримт бичиг эзэмшигч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх бөгөөд хүчингүй болгосон үндэслэл, хугацааг тусгасан байна.

## **С Бүлэг - Бусад**

### **13.101. Мэдээллийн ил тод байдал**

(а) Дарга энэ дүрмийн 13.57, 13.59-д заасны дагуу нисэхийн баримт бичгийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон талаарх шийдвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд нийтэд мэдээлнэ.

### **13.103. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх**

(а) Иргэний нисэхийн хяналтын байцаагч хууль, дүрмийг албадан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсэж болзошгүй, олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл үүссэн бол холбогдох хуульд заасны дагуу мэдэгдэл, тайлбарыг “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”-аар тухай бүр Даргад гаргаж шийдвэрлүүлнэ.

### **13.105. Гомдол гаргах**

(а) Аливаа этгээд иргэний нисэхийн хяналтын байцаагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Даргад гомдол гаргах эрхтэй.

(b) Дарга энэ зүйлийн (а)-д заасан гомдлыг хянан үзэж гаргасан шийдвэрийг тухайн этгээд эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7448 дугаарт бүртгэв.

## **ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГА, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар А/78, А/183

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, мөн зүйлийн 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төмөр замын тээвэрт тусгай зориулалтын багаж, хэрэгсэл ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон бусад холбогдох байгууллагуудад даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр замын газрын Хяналтын газар (Ж.Болдхүү)-т, Тагнуулын ерөнхий газрын холбогдох салбар, нэгжид тус тус даалгасугай.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН  
ДАРГА

Б.АРТУР

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА

П.ОДОНБААТАР

*Төмөр замын газрын дарга,  
Тагнуулын ерөнхий газрын даргын  
2025 оны 11 дүгээр сарын 25-ны  
өдрийн А/78, А/183 дугаар хамтарсан  
тушаалын хавсралт*

## **ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН БАГАЖ, ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээвэрт ашиглах тусгай зориулалтын багаж, хэрэгслийг /цаашид “багаж, хэрэгсэл” гэх/ ашиглах, хадгалах түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Уг журмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өмчийн хэлбэр харгалзахгүй төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид дагаж мөрдөнө.

### **ХОЁР. БАГАЖ, ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛ**

2.1.Хэрэгсэл нь дараах төрөлтэй байна:

2.1.1.хөдлөх бүрэлдэхүүнийг зогсоох, мөн түүний өөрөө өнхрөх хөдөлгөөнийг хязгаарлан тогтоох тоормосны ивүүр /цаашид “ивүүр” гэх/;

2.1.2.хөдлөх бүрэлдэхүүний дугуйн дор тавьж замд оруулах мэлхийвч;

2.1.3.хөдлөх бүрэлдэхүүний дугуйн дор тавьж замд оруулах дов;

2.2.Багаж нь дараах төрөлтэй байна:

2.2.1.цахилгаан шилжүүлэгчтэй сумын шилжүүлгийг гараар шилжүүлэн эргүүлэгч /цаашид «сум шилжүүлэх түлхүүр» гэх/;

2.2.2.замын хадаас сугалагч ацат царил /цаашид “царил” гэх/;

2.2.3.зам төмөр, дэрний бэхэлгээний системийн тусгай түлхүүр;

2.2.4.замын дээд бүтэц угсрах, засварлах, ажилд ашиглах амтай, амгүй бүх төрлийн тусгай түлхүүр /цаашид “замын ажлын тусгай түлхүүр” гэх/;

2.3.Багаж, хэрэгслийг энэхүү журамд заасан зориулалтын дагуу ашиглана.

### **ГУРАВ. БАГАЖ, ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1.Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан багаж, хэрэгсэл нь стандартын дагуу үйлдвэрлэгдсэн, үйлдвэрлэгчийн тусгай таних тэмдэгтэй, тохирлын гэрчилгээтэй тагнуулын байгууллагад бүртгэгдсэн байна.

3.2.Багаж, хэрэгслийн хадгалалт, ашиглалт, хамгаалалт, хяналтыг

эзэмшигч байгууллага бүрэн хариуцна.

3.3.Энэхүү журмын 3.1, 3.2-т заасан шаардлага хангаагүй багаж, хэрэгслийг ашиглахыг хориглоно.

3.4.Багаж, хэрэгсэлд эзэмшигч нь ялгах тэмдэг, хувийн бүртгэлийн дугаарыг цохимол аргаар тавина.

#### **ДӨРӨВ. БАГАЖ, ХЭРЭГСЛИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ**

4.1.Ивүүрийг төмөр замын тээврийн байгууллага, салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч ашиглана.

4.1.1.төмөр замын тээврийн байгууллага, салбар зам эзэмшигчид байх ивүүрийн тоо, тэдгээрийг ашиглах горимыг төмөр замын тээврийн байгууллагын өртөө, зөрлөгийн техник захирамжийн акт, технологийн горим /салбар замд сэлгээний ажил хийх заавар/-оор тогтооно.

4.1.2.зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнд байвал зохих ивүүрийн тоог уг зүтгүүрийн эргэлтийн мөр, өртөө, зөрлөг, замын хэвгийг харгалзан төмөр замын тээврийн байгууллага тогтооно.

4.1.3.сунгуу уруудууртай хоорондын зам дахь төмөр замын хамгаалалттай гармын жижүүрийн байранд байх ивүүрийн тоог төмөр замын тээврийн байгууллага тогтооно.

4.2.Дов, мэлхийвчийг сэргээн босгох галт тэрэг, өртөөний шуурхай ажлын баг зүтгүүрийн депо, зам засварын хүнд машин механизмд заавал байлгана.

4.3.Сэлгээний зүтгүүрт хоёр ширхэг дов байж болно.

4.4.Багажийг зөвхөн төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, угсрах засварлах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эзэмшинэ.

4.5.Төмөр замын гармын жижүүрийн байранд замын ажлын тусгай түлхүүр хадгалж, ашиглах эсэхийг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч тогтооно.

#### **ТАВ. БАГАЖ, ХЭРЭГСЛИЙГ ХАДГАЛАХ, ХҮЛЭЭЛЦЭХ**

5.1.Багаж, хэрэгслийг эзэмшигч нь дараах үүрэгтэй:

5.1.1.багаж, хэрэгслийг цоожтой бат бэх, найдвартай саванд хадгалах;

5.1.2.хадгалж байгаа багаж, хэрэгслийн жагсаалт, тоо ширхгийг тусгасан бүртгэлтэй байх;

5.1.3.багаж, хэрэгсэл хариуцсан ажилтан нь ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа тоолж, бүртгэл хөтлөх;

5.1.4.бүртгэлийн дэвтэрт хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан хүний нэр, албан тушаал, гарын үсэг, хугацаа, олгосон багаж, хэрэгслийн төрөл, тэмдэг дугаар зэргийг тэмдэглэх.

#### **ЗУРГАА. БАГАЖ, ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫГ ХЯНАХ**

6.1.Багаж, хэрэгсэл эзэмшигч этгээд нь бүртгэл, жагсаалтыг жил

бүрийн IV улиралд багтаан төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тагнуулын байгууллагад хүргүүлнэ. Хэрэв жагсаалтад өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох тайлбар /ашиглалтаас хассан акт, устгасныг нотолсон баримт, алдагдсан тухай мэдэгдэл, мөн авсан арга хэмжээ/-ыг хавсаргана.

6.2.Багаж, хэрэгсэл эзэмшигч нь багаж, хэрэгслийн тооллогыг улиралд нэгээс доошгүй удаа хийх ба эвдэрч, гэмтэн ашиглах бололцоогүй болсон багаж хэрэгслийг хураан авч эзэмшигчээс томилсон комиссын /фото зураг болон дүрс бичлэгээр баримтжуулан/ хяналт дор дахин ашиглах боломжгүйгээр устгаж, акт бүрдүүлэн данснаас хасна.

6.3.Эзэмшигч байгууллага нь багаж, хэрэгслийг алдаж, үрэгдүүлсэн тохиолдолд дотоод хяналт хариуцсан албан тушаалтан, тагнуулын болон цагдаагийн байгууллага, төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

6.4.Алдагдсан багаж хэрэгслийг олдсон тохиолдолд ашиглах боломжтой бол төрийн захиргааны байгууллага, Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэнэ.

### **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

7.1.Энэ журамд заагдаагүй хүн, хуулийн этгээдэд багаж, хэрэгслийг эзэмших ашиглах, хадгалахыг хориглоно.

7.2.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7449 дүгээрт бүртгэв.

## **ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар А/79

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төмөр замын тээврийн зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудад даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын газар (Ж.Болдхүү)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АРТУР

*Төмөр замын газрын даргын  
2025 оны 12 дугаар сарын 19-ний  
өдрийн А/79 дүгээр тушаалын хавсралт*

## **ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАРТ ОБЪЕКТ БАЙРЛУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ, НЭВТРЭХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээврийн зориулалттай газарт объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Журмын нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн дүрэм, журам, үндэсний стандартад заасан утгаар ойлгоно.

1.3.Энэхүү журмыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид мөрдөх бөгөөд тус журмаар зохицуулсан харилцааг дотоод дүрэм, журмаар зохицуулахгүй.

### **ХОЁР.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАРТ СУУРЬ БҮТЭЦ БАРИХ**

2.1.Төмөр замын тээврийн зориулалттай газарт суурь бүтэц барих гэдэгт төмөр замын суурь бүтцийн чиглэл тогтоох, төмөр замын техникийн шаардлагыг тогтоох зэрэг үйл ажиллагаа хамаарна.

2.2.Төмөр замын суурь бүтэц, салбар замыг зориулалтаар нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т зааснаар ангилах бөгөөд эдгээр төмөр зам нь дараах техникийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1.нийтийн болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын суурь бүтэц нь үндэсний стандартад заасан төмөр замын шугамын 3-аас дээш зэрэглэлтэй байх;

2.2.2.салбар зам нь үндэсний стандартад заасан төмөр замын шугамын 4-өөс доош зэрэглэлтэй ба урт нь 15 км-ээс хэтрэхгүй байх.

2.3.Төмөр замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасны дагуу Нийтийн төмөр замын чиглэлийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын чиглэлийг мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д заасны дагуу Засгийн газар тогтооно.

2.4.Нийтийн болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын суурь бүтцийн чиглэлийг тогтоолгохдоо хуулийн этгээд нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3-т заасан шаардлагыг хангасан баримт бичгийг төмөр замын тээврийн асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/-д ирүүлнэ.

2.5.Төрийн захиргааны байгууллага нь төмөр замын чиглэл тогтоох хүсэлтийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан журмын дагуу хянаж, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.6.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажлыг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

2.7.Төмөр замын суурь бүтцийн барилга угсралтын ажил гүйцэтгэх, төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулахдаа Төмөр замын тээврийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг баримтална.

### **ГУРАВ.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАРТ САЛБАР ЗАМ БАРИХ, ӨРГӨТГӨЛ ХИЙХ, БУСАД ОБЪЕКТ БАЙРЛУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ**

3.1.Төмөр замын тээврийн зориулалттай газарт салбар зам барих, өргөтгөл хийх, бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах гэдэгт техникийн нөхцөлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа хамаарна.

3.2.Салбар замыг холбох, өргөтгөх, салаалах, барилга байгууламж байрлуулахтай холбоотой асуудлыг төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн саналыг харгалзан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

3.3.Төмөр замын тээврийн зориулалттай газарт салбар зам барих, өргөтгөх, барилга байгууламж байрлуулах зөвшөөрөл хүсэгч нь төрийн захиргааны байгууллагад дараах материалыг бүрдүүлэн хүсэлтээ гаргана:

3.3.1.хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл:

- хүсэлт;
- улсын бүртгэлийн гэрчилгээ;

3.3.2.салбар замын талаарх мэдээлэл:

- салбар замын чиг, байршлын бүдүүвч тойм зураг;
- салбар замын замуудын тоо, багтаамж, төхөөрөмж байгууламж, техник хэрэгсэл;
- салбар замын ачаа боловсруулах хүчин чадал;
- салбар замын газрын ашиглалт, эзэмшлийн талаарх баримт бичиг.

3.3.3.тээвэрлэлтийн талаарх мэдээлэл:

- салбар замын зориулалт, үйлчилгээний ба ачааны нэр, төрөл;
- ажил үйлчилгээний тойм хэмжээ /дамжуулах буюу

боловсруулах вагон, ачаа/.

3.4.Төрийн захиргааны байгууллага нь төмөр замын салбар зам барих, өргөтгөл хийх, барилга байгууламж байрлуулах техникийн нөхцөлийг судлан, магадлан шалгах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг томилж ажиллуулах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

3.4.1.салбар зам барих болон өргөтгөлийн ажил нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, үндэсний стандарт, норм нормативын шаардлагад нийцэх эсэх;

3.4.2.салбар замыг өртөө, зөрлөгийн замаас салаалах боломж, зохистой чиг, хувилбарууд, салбар замын зориулалт;

3.4.3.дохиолол, холбооны төхөөрөмжийг ашиглах боломж, хувилбар /галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын үүднээс суман шилжүүлгийг цахилгаан төвлөрүүлэлтэд холбох, сэлгээний дохиогоор, ойртох хэсгийг зам төмөр хэлхээгээр тоноглох/;

3.4.4.салбар замд суурилуулах шаардлагатай байгууламж, тоног төхөөрөмж;

3.4.5.шинээр салбар төмөр зам барихтай холбоотой тухайн суурь бүтцийн өртөө, зөрлөгийг өргөтгөх, сэлгээний хөдлөх бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх эсэх;

3.4.6.төмөр замын суурь бүтцийн одоогийн хүчин чадал, хүсэлтэд заасан тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх арга хэмжээ, шийдвэрлэх арга зам;

3.4.7.байршил, ачаа боловсруулалт болон бусад онцлогоос хамаарч зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт ажил, байгууламж, технологийн талаарх санал;

3.4.8.салбар зам, түүний өргөтгөл болон төмөр замын өртөө, зөрлөг, бусад салбар зам хоорондын харилцан ажиллагааны зарчим;

3.4.9.галт тэрэгний хөдөлгөөн ба ачаа боловсруулалт, сэлгээний ажлын зохион байгуулалтын талаар тээвэрлэгч болон салбар зам эзэмшигчдэд өгөх зөвлөмж, санал;

3.4.10.салбар зам барих болон өргөтгөлийн ажилтай уялдуулан инженерийн байгууламжийг зөөж шилжүүлэх, шинээр байгуулахтай холбогдон гарах зардлыг хүсэлт гаргагч хариуцах;

3.4.11.суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн болон бусад салбар замд тавьж буй суман шилжүүлгийн өмчлөл болон түүний арчлалтын хариуцагчийг тодорхойлох;

3.4.12.салбар төмөр замыг цаашид ашиглах зориулалтыг тодорхойлж, тухайн чиглэлээр ашиглах, хөгжүүлэх асуудлыг тусгах;

3.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбар замын зориулалт, байршлын онцлогийг харгалзан суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч,

тээвэрлэгч болон мэргэжлийн бусад байгууллага, салбар зам эзэмшигч, хүсэлт гаргагчийн төлөөллийг оролцуулна.

3.6.Хүсэлт гаргагч нь техникийн нөхцөлийг судлан, магадлан шалгах болон санал, дүгнэлт гаргахтай холбогдсон зардлыг хариуцна.

3.7.Аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр урьдчилсан дүгнэлт гаргаж болох бөгөөд тус урьдчилсан дүгнэлтийг зөвхөн судалгааны ажилд ашиглана.

3.8.Урьдчилсан дүгнэлтийн дагуу ажлын зураг хийж гүйцэтгэхийг хориглоно.

3.9.Төмөр замын тээврийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7-д заасны дагуу салбар зам эзэмшигч нь суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч өртөө, зөрлөгтөө өргөтгөл хийх, тухайн салбар замаас дахин өөр хэрэглэгч салбар зам салаалах нөхцөлд үндэслэлгүй татгалзахыг хориглоно.

3.10.Өртөө, зөрлөгөөс салаалах салбар зам нь ачааны эрчимжилт, тухайн өртөөний зохион байгуулалт зэргийг харгалзан үзэж, Төмөр замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2-т заасны дагуу удирдлага, хяналтын системээр тоноглогдсон байвал зохино.

3.11.Шинээр барих салбар төмөр зам нь суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн төмөр замын зурвас газартай давхцаж байгаа хэсэгт суурь бүтцийн хэвийн үйл ажиллагаа, нэгдсэн удирдлага, аюулгүй байдал, объектын өмчлөх эрхийг хангах үүднээс тухайн өртөө, зөрлөгөөс салаалсан эхний суман шилжүүлгийг уг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх эсхүл ашиглах эрхтэйгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр өмчлүүлж, ашиглуулна.

3.12.Шинээр салаалах салбар төмөр зам, ачиж, буулгах талбайг өөрийн эзэмшлийн газарт багтаан байгуулах, мөн шинээр барих салбар замын трассын дагуух газар нь давхцалгүй, үл хөдлөх хөрөнгийн эрхийн маргаангүй байна.

3.13.Энэхүү журмын 3.4-т заасан дүгнэлт нь нэг жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд техникийн нөхцөл олгогдсоноос хойш тухайн өртөө, зөрлөгт өргөтгөл шинэчлэл хийгдээгүй тохиолдолд дүгнэлтийг нэг удаа анх олгосон хугацаагаар сунгаж болно.

3.14.Салбар зам, шинээр байрлуулах барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

3.15.Салбар замын зориулалтад өөрчлөлт орох үед энэхүү журмын 3.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВ.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗАРТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ**

4.1.Төмөр замын тээврийн зориулалттай газарт төмөр замын байгууллага, салбар зам, талбай эзэмшигчид нь тээврийн технологийн зориулалттай ажил, үйлчилгээг төмөр замын тээврийн дүрэм, журмын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

4.2.Төмөр замын тээврийн бус хуулийн этгээд, хүн төмөр замын тусгай бүс дотор ажил үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

4.3.Төмөр замын тээврийн зориулалттай газарт байрлах төмөр замын өртөө, зорчигч үйлчилгээний буудлын орчинд зориулалтын шуудан, телефон холбоо, ном хэвлэл, бэлэг дурсгал, хүнсний бараа үйлчилгээний газар, цэгүүд ажиллаж болно.

4.4.Төмөр замыг төмөр зам, авто замаас бусад инженерийн дэд бүтэцтэй огтлолцуулах асуудлыг суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч шийдвэрлэнэ.

4.5.Төмөр замыг авто замтай огтлолцуулах үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14-т заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

## **ТАВ.ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

5.1.Энэхүү журмын хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллагын хяналт хариуцсан нэгж, мөн төмөр замын тээврийн байгууллагууд болон тэдгээрийн салбар, нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгж хяналт тавина.

5.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7450 дугаарт бүртгэв.

## **ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 10 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 46

Ховд

### **МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.14, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Амарсанаа)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолыг холбогдох материалын хамт Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (З.Эрхбаяр)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

З.ЭРХБАЯР

[illegible]

ကုမ္ပဏီ၏ နှစ်စဉ် အသက်မွေးဝမ်းကျောင်း (စာချုပ်အရ) - မှတ်တမ်း ထိန်းသိမ်းထားပါသည်။

[illegible]

ਸਿਰਜਣੀ ੨੨/ ੧੦/੧੯੯੯

ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ 20.1.3.35 ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ 35.1.14 རྒྱུ་ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ ལྷོ་ཁྱེད་ཀྱི་  
 ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ 64.1 ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ ལྷོ་ཁྱེད་ཀྱི་ 20

ל' אב תשס"ו ב' חשוון תשס"ז

ତଥା ୧୬

အိမ်ထောင် ကျန်းမာမှု မှ ကျန်းမာမှု မှ အဆိုးဆုံးအထိ မှ

*Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
46 дугаар тогтоолын хавсралт*

**МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ**

| д/д                                            | Ажил үйлчилгээ                                                                   | №  | Мал, амьтны төрөл   | Хэмжих нэгж  | Төлбөрийн хэмжээ |
|------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|----|---------------------|--------------|------------------|
| 1.Мал, амьтанд тарилга хийх                    |                                                                                  |    |                     |              |                  |
| 1.                                             | Булчин, арьсан доор тариа хийх                                                   | 1  | Бод мал             | Толгой тутам | 800              |
|                                                |                                                                                  | 2  | Бог мал             | Толгой тутам | 500              |
|                                                |                                                                                  | 3. | Нохой               | Толгой тутам | 1000             |
|                                                |                                                                                  | 4. | Муур                | Толгой тутам | 1000             |
| 2.                                             | Судас болон цагаан мөгөөрсөн хоолойгоор                                          | 1. | Бод мал             | Толгой тутам | 4000             |
|                                                |                                                                                  | 2. | Бог мал             | Толгой тутам | 2000             |
|                                                |                                                                                  | 3. | Нохой               | Толгой тутам | 5000             |
|                                                |                                                                                  | 4. | Муур                | Толгой тутам | 3000             |
| 3.                                             | Цээж хэвлийн хөндийд тариа хийх                                                  | 1  | Бод мал             | Толгой тутам | 2500             |
|                                                |                                                                                  | 2  | Бог мал             | Толгой тутам | 2000             |
|                                                |                                                                                  | 3  | Нохой               | Толгой тутам | 1500             |
| 2. Шимэгч хорхойг эмчлэн сэргийлэх арга хэмжээ |                                                                                  |    |                     |              |                  |
| 4.                                             | Туулгалт                                                                         | 1. | Бод мал             | Толгой тутам | 1500             |
|                                                |                                                                                  | 2. | Төл мал             | Толгой тутам | 500              |
|                                                |                                                                                  | 3. | Нохой               | Толгой тутам | 3000             |
|                                                |                                                                                  | 4. | Муур                | Толгой тутам | 2000             |
| 5.                                             | Угаалга /Ванн/                                                                   | 1. | Бод мал             | Толгой тутам | 1500             |
|                                                |                                                                                  | 2. | Бог мал             | Толгой тутам | 500              |
|                                                |                                                                                  | 3. | Төл мал             | Толгой тутам | 400              |
|                                                | Угаалга гар аргаар болон шүршиж угаах                                            | 1. | Бод мал             | Толгой тутам | 1500             |
|                                                |                                                                                  | 2. | Бог мал             | Толгой тутам | 800              |
|                                                |                                                                                  | 3. | Төл мал             | Толгой тутам | 800              |
| 6.                                             | Мах болон дайвар бүтээгдэхүүнд мэдрэхүйн эрхтний шинжилгээ хийх                  | 1. | Малын мах           | Кг           | 30               |
|                                                |                                                                                  | 2. | Дайвар бүтээгдэхүүн | Кг           | 60               |
| 7.                                             | Мал, амьтны хашаа, байр, саравч, шүрших, үйлдвэрийн байр, агуулах, зоорь, талбай | 1. | Бүх төрлийн         | Метр квадрат | 120              |

|                                           |                                                                   |    |                          |               |       |
|-------------------------------------------|-------------------------------------------------------------------|----|--------------------------|---------------|-------|
| 8.                                        | Мал, амьтны гаралтай түүхий эдэд мэдрэхүйн эрхтний шинжилгээ хийх | 1. | Бодын шир                | Ширхэг        | 500   |
|                                           |                                                                   | 2. | Бог малын арьс           | Ширхэг        | 100   |
|                                           |                                                                   | 3. | Ангийн арьс              | Ширхэг        | 100   |
|                                           |                                                                   | 4. | Ноос, ноолуур            | Кг тутам      | 50    |
|                                           |                                                                   | 5. | Өлөн гэдэс               | гогцоо        | 50    |
| 3. Мал эмнэлгийн шүүх, магадлан шинжилгээ |                                                                   |    |                          |               |       |
| 9.                                        | Малын насыг шүдээр нь тодорхойлох                                 | 1. | Бод                      | Нэг толгой    | 5000  |
|                                           |                                                                   | 2. | Бог                      | Нэг толгой    | 1000  |
| 10.                                       | Ясаар, им тамгаар мал, амьтны төрөл тодорхойлох                   | 1. | Бүх төрөл                | Нэг сорьц     | 8000  |
|                                           |                                                                   | 2. | Бүх төрөл                | Толгой тутамд | 3000  |
| 11.                                       | Мал амьтны бэртэл, гэмтэл тодорхойлох                             | 1. | Амьд                     | Толгой тутамд | 15000 |
|                                           |                                                                   | 2. | Үхсэн                    | Толгой тутамд | 15000 |
|                                           |                                                                   | 3. | Амьд /рентген /          | Толгой тутамд | 8000  |
| 4. Мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээ      |                                                                   |    |                          |               |       |
| 12.                                       | Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээ                                  | 1. | Машинаар                 | Нэг км        | 700   |
|                                           |                                                                   | 2. | Мотоциклоор              | Нэг км        | 300   |
|                                           |                                                                   | 3. | Эрүүл мэндийн үзлэг хийх | Бод мал       | 1000  |
|                                           |                                                                   |    |                          | Бог мал       | 300   |
| 5. Мэс ажилбар ба эх барихын тусламж      |                                                                   |    |                          |               |       |
| 13.                                       | Битүү төлийн мэс ажилбар                                          | 1. | Бод                      | Толгой тутамд | 10000 |
|                                           |                                                                   | 2. | Бог                      | Толгой тутамд | 5000  |
| 14.                                       | Ивэрхий засах мэс ажилбар                                         | 1. | Бод                      | Толгой тутамд | 15000 |
|                                           |                                                                   | 2. | Бог                      | Толгой тутамд | 8000  |
| 15.                                       | Буглааны мэс ажилбар                                              | 1. | Бод                      | Толгой тутамд | 15000 |
|                                           |                                                                   | 2. | Бог                      | Толгой тутамд | 6000  |
| 16.                                       | Мал, амьтан агтлах                                                | 1. | Адуу                     | Толгой тутамд | 10000 |
|                                           |                                                                   | 2. | Үхэр                     | Толгой тутамд | 4000  |
|                                           |                                                                   | 3. | Бог мал                  | Толгой тутамд | 300   |
|                                           |                                                                   | 4. | Нохой                    | Толгой тутамд | 10000 |
|                                           |                                                                   | 5. | Бусад                    | Толгой тутамд | 15000 |
| 17.                                       | Өндгөвч авах                                                      | 1. | Нохой                    | Толгой тутамд | 20000 |
|                                           |                                                                   | 2. | Муур                     | Толгой тутамд | 20000 |
| 18.                                       | Туурай, эврийн засал хийх                                         | 1. | Бод мал                  | Толгой тутамд | 4000  |
|                                           |                                                                   | 2. | Бог мал                  | Толгой тутамд | 2000  |
| 19.                                       | Эргүү өвчний мэс ажилбар                                          | 1. | Бод мал                  | Толгой тутамд | 30000 |
|                                           |                                                                   | 2. | Бог мал                  | Толгой тутамд | 15000 |
| 20.                                       | Хээлтэгчийн сав тайрах                                            | 1. | Бод мал                  | Толгой тутамд | 20000 |
|                                           |                                                                   | 2. | Бог мал                  | Толгой тутамд | 15000 |
| 21.                                       | Төлийн байрлал засах                                              | 1. | Бод мал                  | Толгой тутамд | 15000 |
|                                           |                                                                   | 2. | Бог мал                  | Толгой тутамд | 5000  |
| 22.                                       | Төлийг эвдэж авах                                                 | 1. | Бод мал                  | Толгой тутамд | 30000 |
|                                           |                                                                   | 2. | Бог мал                  | Толгой тутамд | 15000 |

|                                            |                                               |    |              |               |       |
|--------------------------------------------|-----------------------------------------------|----|--------------|---------------|-------|
| 23.                                        | Хээлтэгчийн савыг буцааж оруулах, гардаж авах | 1. | Бод мал      | Толгой тутамд | 20000 |
|                                            |                                               | 2. | Бог мал      | Толгой тутамд | 15000 |
| 24.                                        | Кесаровын хагалгаа                            | 1. | Бод мал      | Толгой тутамд | 60000 |
|                                            |                                               | 2. | Бог мал      | Толгой тутамд | 40000 |
| 6. Халдваргүй өвчний анхны тусламж үзүүлэх |                                               |    |              |               |       |
| 25.                                        | Гүзээнээс хий авах                            | 1. | Бод мал      | Толгой тутамд | 4000  |
|                                            |                                               | 2. | Бог мал      | Толгой тутамд | 1000  |
| 26.                                        | Залгиур хоолойд зон тавих                     | 1. | Бод мал      | Толгой тутамд | 4000  |
|                                            |                                               | 2. | Бог мал      | Толгой тутамд | 2000  |
| 27.                                        | Ходоод угаах                                  | 1. | Адуу         | Толгой тутамд | 5000  |
|                                            |                                               | 2. | Жижиг амьтан | Толгой тутамд | 3000  |
| 28.                                        | Дэлүү хатгах                                  | 1. | Адуу         | Толгой тутамд | 3000  |
|                                            |                                               | 2. | Үхэр         | Толгой тутамд | 2000  |
| 29.                                        | Нүдний налих хатгах                           | 1. | Бод          | Толгой тутамд | 2000  |
|                                            |                                               | 2. | Бог          | Толгой тутамд | 1000  |
| 30.                                        | Аранга авах                                   | 1. | Бод          | Толгой тутамд | 3000  |
|                                            |                                               | 2. | Бог          | Толгой тутамд | 2000  |

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар А/591

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Органик үйлдвэрлэлд тавигдах шаардлага, баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Батшагай)-т, тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актыг бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Төрийн захиргааны газар (Б.Отгонцэцэг)-т тус тус даалгасугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам, аргачлал батлах тухай” А/09 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болгосугай.

САЙД

Ж.ЭНХБАЯР

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/591 дүгээр тушаалын хавсралт*

## **ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, БАРИМТЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, мал, амьтан, тэжээл, бордоо, таримлын үр, суулгац, ойн дагалдах баялаг болон байгалийн ургамлыг органик зарчимд нийцүүлэн үржүүлэх, үйлдвэрлэх, бэлтгэх, түүж ашиглах, боловсруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, байгалийн тээвэрлэх, хадгалах, савлах, шошголох, худалдаалах, экспортлох, импортлох ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь өөрийн болон бусдын, эсхүл нийтийн эзэмшлийн байгалийн баялгийг тогтвортой ашиглаж, хамгаалан, үйлдвэрлэлийн аль ч шатанд органик үйлдвэрлэлийн зарчмыг баримтална.

1.3.Мал аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх талаарх зохицуулалт нь таван хошуу мал болон ашиг шимийг нь хүртэх зорилгоор ашигладаг тэжээвэр амьтанд мөн хамаарна.

1.4.Энэ журмын 1.1 дэх хэсэгт заасан органик үйлдвэрлэлийн бүх шатанд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу баталсан жагсаалтад заасан зөвшөөрөгдсөн бодис ашиглана.

1.5.Үйлвэрлэл эрхлэгч органик бус үйлдвэрлэлээс органик үйлдвэрлэлд шилжих хүсэлт баталгаажуулалтын байгууллагад гарган, шилжилтийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангана.

1.6.Иргэн, аж ахуйн нэгжийн энэ журмын 1.4-т зааснаас бусад бодисын хэрэглээг бүрэн зогсоож, энэ журмын 1.5-д заасан гэрээг баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан өдрийг органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үе эхлүүлсэн хугацаанд тооцно.

1.7.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь өөрийн болон бусдын, эсхүл нийтийн эзэмшлийн байгалийн баялгийг тогтвортой ашиглаж, хамгаалан, үйлдвэрлэлийн аль ч шатанд органик үйлдвэрлэлийн зарчмыг баримтална.

1.8.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн технологийг органик бус үйлдвэрлэлийн технологиор дахин сольж ашиглахгүй.

1.9.Зэрэгцээ болон тусгаарласан органик үйлдвэрлэлийн органик бус хэсэгт хувиргасан амьд организм, тэдгээрийн уламжлалыг ашиглахгүй.

1.10. Энэ журмын 1.5-д заасан гэрээнд хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний орц, түүхий эдийн ул мөрийг нэг алхмаар урагш мөрдөн тогтоох бүртгэлийг сүлжээний бүх үе шатанд хэрхэн хөтлөх, хувиргасан амьд организм, тэдгээрийн уламжлалыг ашиглан үйлдвэрлэсэн эсэхийг тогтоох асуудлыг тусгана.

1.11. Органик хүнс, хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах бүх үе шатанд бүтээгдэхүүнтэй харьцах гадаргуу, сав, баглаа, боодол нь нано бүтэцгүй, зориулалтын материалаар хийгдсэн байна.

1.12. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь усны нөөцийг зохистой ашиглах, борооны усыг эргүүлэн ашиглах чиглэлээр баталгаажуулалтын байгууллагатай байгуулах гэрээнд тусган, хэрэгжилтийг хангана.

1.13. Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн тус бүр нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9.1.1.-д заасан баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, 11.6-д заасан баталгаажуулалтын хүчин төгөлдөр гэрчилгээтэй, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сан [www.organic.gov.mn](http://www.organic.gov.mn) -д бүртгэгдсэн, бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэгтэй байна.

1.14. Органик бүтээгдэхүүнийг экспортлох, төрийн худалдан авалтад оролцох болон үйлчлүүлэгчийн хүсэлтээр хөндлөнгийн баталгаажуулалтад хамрагдах тохиолдолд хамтын баталгаажуулалтын үр дүнг ашиглаж болно.

1.15. Органик бүтээгдэхүүнийг сав баглаа боодолгүй бөөнөөр нь худалдаалах тохиолдолд баталгаажуулалтын гэрчилгээг нийтэд ил харагдахуйц газар байршуулна.

1.16. Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодист органик үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйд ашиглах бордоо, хөрс сайжруулагч, ургамал хамгааллын бодис, микробиологийн бүтээгдэхүүн, тэжээл ба тэжээлийн нэмэлт, үр/суулгац/үржүүлгийн материал, зөгийн аж ахуйн туслах материал хамаарах ба органик үйлдвэрлэлд хэрэглэх импортын бодисыг “органик бүтээгдэхүүн” гэж нэрлэхгүй бөгөөд энэхүү журмын 1.13-т заасан үндэсний органик тэмдэг, “органик” мэдэгдлийг хэрэглэхгүй.

1.17. Ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал (жишээлбэл, эмийн ургамал, мөөг, жимс, модны шүүс)-ыг түүж, ашиглах органик болохыг баталгаажуулахад дараах шаардлага тавигдана.

1.17.1. Ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал нь хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл, ургамал байх,

1.17.2. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9.1.1-т заасан баталгаажуулалтын байгууллага нь ойн дагалт баялаг болон байгалийн

ургамлыг түүж, ашиглах иргэн, аж ахуйн нэгжийг баталгаажуулах бөгөөд шаардлагын дагуу бүлгээр баталгаажуулж болно.

1.17.3.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.3-т заасан албан тушаалтны гарын үсэг, тэмдгээр баталгаажсан тодорхойлолтод ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал түүж, ашиглах бүс нутгийн хилийн зааг, хөрш аж ахуйн нэгж болон үйлдвэрийн бохирдлоос тусгаарласан хамгаалалтын зурвас бүс, бохирдлын эх үүсвэрийг тодорхойлж, тэмдэглэсэн газрын зургийг хавсаргаж баримтжуулсан байх;

1.17.4.Ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг түүх ажлыг гүйцэтгэж буй этгээд нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2.12.-т заасны дагуу өөрийн нэр, регистрийн дугаар, цуглуулж түүсэн газрын байршил, хамрагдсан талбай, түүсэн хэмжээ зэрэг мэдээллийг бүртгэн хөтлөх;

1.17.5.Органик баталгаажуулалт хийсэн ойн дагалт баялаг болон байгалийн ургамлыг худалдаалж буй нэгж нь нийлүүлэлтийн сүлжээний буюу хураалт, боловсруулалт, шошгололт, борлуулалт хүртэлх бүх шатны ул мөрийг мөшгөх мэдээллийг бүртгэх.

1.17.6.Байгалийн нөөцийг хэт ашиглахгүй, ургамлын нөхөн сэргээлтийг хангах, хөрсийг хамгаалахад чиглэсэн ямар арга ашиглан ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал түүж, ашиглах талаар Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.3-т заасан тодорхойлолтод тусгах;

1.17.7.Ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал нь түүж, хураасны дараа хориглосон бодисоор бохирдохоос сэргийлэх;

1.17.8.Ойн дагалдах баялаг болон байгалийн ургамал түүж, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх бол органик хүнс, хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тавигдах боловсруулалтын технологи, шошго, ерөнхий шаардлагад нийцсэн байх.

1.18.Органик хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь хөдөө аж ахуйн болон үйлдвэрлэлийн, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлсэн байна.

### **Хоёр.Органик мал аж ахуйн үйлдвэрлэлд тавигдах шаардлага**

2.1.Мал амьтныг байгалийн бэлчээрт уламжлалт аргаар маллах, байгалийн болон тарималжуулсан органик бэлчээрт жилд 120 хоногоос дээш хугацаанд бэлчээж, бусад хугацаанд энэ журамд нийцүүлэн байран маллах замаар мал аж ахуйн органик үйлдвэрлэлийг эрхэлж болно.

2.2.Мал амьтныг байгалийн бэлчээрт уламжлалт аргаар маллан, нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй этгээд нь бэлчээр, тавлаг байдал болон бүтээгдэхүүн боловсруулах шатанд энэ журамд заасан

шаардлагыг хангасан тохиолдолд органикаар баталгаажиг болно.

2.3. Мал нь аливаа өвчнөөс ангид, эрүүл, өвчингүй бүсээс гарал үүсэлтэй байх;

2.4. Битүү тор, хашаанд малласан мал, амьтан тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг “органик бус” гэж тооцох;

2.5. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь Монгол улсын Малын генетик нөөцийн тухай хуульд нийцүүлэн генетик нөөцийг ашиглан, мал амьтныг үржүүлэх;

2.6. Мал амьтныг үржүүлэхэд байгалийн үржил давамгайлах ба хиймэл хээлтүүлгийг зөвшөөрөх;

2.7. Хөврөл үр шилжүүлэн суулгах, үржлийн зориулалтаар дааврын эмчилгээ хийх, клонинг болон генийн инженерчлэлийг мал амьтны үржлийн ажилд ашиглахгүй байх;

2.8. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь Монгол улсын Малын генетик нөөцийн тухай хуулийн 14.1.1, 14.1.2 дахь хэсэгт заасны дагуу мал амьтны тавлаг байдлыг ханган, арчилж, маллан, хамгаалах;

2.9. Органик үйлдвэрлэл эрхлэгч нь Монгол улсын Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.7 дахь хэсэгт заасны дагуу мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэгдсэн байх ба мөн хуулийн 5.1.1 ба 5.2 дахь хэсэгт заасны дагуу мал, бэлчээр болон байран маллагааны талаарх бүртгэлийг хөтөлж, баталгаажуулалтад хамрагдах;

2.10. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9.1.1, 9.1.2, 9.2 дахь хэсэгт заасан баталгаажуулалтын байгууллагаас баталгаажуулсан мал, амьтны арьс, үс, ноос, ноолуур, гоо сайхан, ахуйн хэрэглээний ариутгалын бүтээгдэхүүний шошгод органик болохыг илэрхийлсэн тэмдэг тэмдэглэгээг ашиглах;

2.11. Малын гарал үүсэл ба шилжилтийн үеийн дараах хугацаанд малын гарал үүслийн шилжилтийн үед тооцно.

2.11.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн органик бус арга хэлбэрээс органик үйлдвэрлэлд шилжих хугацаа нь сүүний чиглэлийн мал амьтан болон махны чиглэлийн бог малын хувьд 6 сар, махны чиглэлийн мал амьтны хувьд 12 сар байх;

2.11.2. Байгалийн, эсхүл тарималжуулсан бэлчээрийн мал сүргийг ижил хугацаанд органик үйлдвэрлэлд шилжүүлж буй тохиолдолд шилжилтийн үеийн хугацаа 24 сар байх;

2.12. Мал аж ахуйн органик үйлдвэрлэлийг органик бус мал аж ахуйн үйлдвэрлэлтэй нэг дор хавсарч, зэрэгцээ байдлаар эрхлээгүй байх;

2.13. Мал амьтныг бэлчээрлэх, тэжээхдээ эх малыг хээлтүүлэхээс эхлэн төллөх хүртэлх хугацаанд органик тэжээлээр тэжээж, органик аргаар маллаж, арчилсан бол төлийг “органик төл” гэж тооцох;

2.14.Органик төлийг органик аргаар маллаж, арчлан, тэжээж гарсан бүтээгдэхүүнийг “органик бүтээгдэхүүн” гэж тооцно.

2.15.Эх малыг хээл авсан үеэс эхлэн төллөх, саалинд хамрагдах хүртэлх хугацаанд органик аргаар маллаж арчлан, органик тэжээлээр тэжээж гарсан сүүг “органик сүү” гэж тооцно.

2.16.Хоёр хоногийн настай тахианы дэгдээхийг өндөглөгч тахиа болтол органик аргаар тэжээж, арчилж гарсан өндгийг “органик өндөг” гэж тооцно.

2.17.Органик үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нь дэгдээхэй бойжуулдаггүй бол органик бус аж ахуйгаас 2 -оос доошгүй хоногийн настай дэгдээхэй авч болно.

2.18.Органик бус аж ахуйгаас органик аж ахуйд үржлийн зориулалтаар авчирч буй малын тоо нь тухайн төрлийн малын 10 хувиас хэтрэхгүй ба хээлтэгч мал нь хээлгүй байна.

2.19.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлсөн, шинэ төрөл, зүйлийн мал амьтныг үржүүлэх, эсхүл аж ахуйн үйл ажиллагааг өргөтгөх болон тухайн аж ахуй нь 10-аас цөөн тооны малтай бол үржлийн зориулалтаар органик бус аж ахуйгаас авчирч буй малын тоо жилд 10%-иас их байж болно.

2.20.Энэ журмын 2.11-д заасан шилжилтийн үеийн хугацаа өнгөрсний дараа органик бус аж ахуйгаас авчирч буй мал амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ бүхий шошго хэрэглэж, зах зээлд нийлүүлж болно.

2.21.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь мал амьтдыг тэдгээрийн физиологийн онцлог, тэжээллэгийн шаардлагад нийцсэн байгалийн болон тарималжуулсан органик бэлчээрт, эсхүл байран маллаж, шимт бодисыг тэнцвэртэй хэмжээгээр агуулсан органик тэжээлээр тэжээнэ.

2.22.Органик бэлчээрийг ашиглахдаа дараах горимыг мөрдөнө.

2.22.1.уламжлалт аргаар мал, амьтан адгуулж нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй байгалийн бэлчээрт 3 жил хүртэлх хугацаанд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т зааснаас бусад бодисыг хэрэглэхгүй.

2.22.2.бэлчээрийн хил зааг тодорхой байх;

2.22.3.бэлчээрийн төлөв байдал, даацад нийцүүлэн малын тоог зохистой хэмжээнд байлгах;

2.22.4.малын төрлийг бэлчээрийн хэв шинжид нийцүүлэх;

2.22.5.бэлчээрийн ургамалшилтыг сайжруулах зорилгоор сэлгэж, өнжөөж ашиглах;

2.22.6.бэлчээр сайжруулахад Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу баталсан бордоо, хөрс

сайжруулагчийг ашиглах, олон наст ургамлын органик үр цацах / хачирлах/ аргыг хэрэглэх;

2.22.7.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу баталсан жагсаалтад орсон бэлдмэл, бодис хэрэглэн бэлчээрийн хог ургамал, хортон мэрэгчидтэй тэмцэх;

2.22.8.бэлчээрийн зарим хэсгийг хашиж ашиглах тохиолдолд хашаа нь мал амьтанд гэмтэл учруулахааргүй байх.

2.22.9.Хивэгч малыг өдөр бүр бэлчээрлүүлнэ.

2.23.Энэ журмын 2.1-д заасны дагуу мал амьтныг байран маллаж байгаа тохиолдолд байр, хашаа саравч нь мал амьтан төрөлхийн (байгалийн) зан авираа илэрхийлэх, чөлөөтэй хөдлөх, тайван байх нөхцөлийг хангасан байхаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.23.1.тоосжилт, чийгшил, агаарын хэмийн огцом өөрчлөлт, хийн хуримтлал, агаар солилцоо зэргээс шалтгаалан малын эрүүл мэндэд эрсдэл учруулахааргүй нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд дулаан тусгаарлах, халаах, эсхүл хөргөх, агааржуулах тоног төхөөрөмжтэй байх;

2.23.2.байгалийн гэрэл тусах цонхны хэмжээ нь шалны нийт талбайн 3%-иас багагүй байх;

2.23.3.тэжээлийн болон усны онгоц нь хүрэлцээтэй, материал, хийц нь тухайн мал, амьтны биологийн болон тэжээллэгийн онцлогт нийцсэн байх;

2.23.4.малын хэвтэрт байгалийн гаралтай, органик материал ашиглах;

2.23.5.малын хэвтрийн талбайн 50 хувиас доошгүй хэсэг нь тэгш, хатуу гадаргуутай, ялгадас урсах, шингэх, цэвэрлэгээ, ариутгал хийх боломжтой байх;

2.23.6.Мал, амьтныг аль болох богино хугацаанд уяж, туших ба малын чөдөр, тушаа, бэхлэх хэрэгсэл нь байгалийн гаралтай материалаар хийгдсэн байх;

2.23.7.Мал амьтныг өвдөх, төллөхөөс бусад тохиолдолд ижил сүргээс тусгаарлаагүй байх;

2.24.Малын байр, хашаа, саравчинд эрүүл ахуйн горимыг сахиж, хортон шавж, мэрэгчдээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг дор дурдсан дарааллын дагуу авч хэрэгжүүлнэ.

2.24.1.шавж хорхой, мэрэгч малын байр руу нэвтрэх, үүрлэх, хөөө цуглуулахаас урьдчилан сэргийлэх;

2.24.2.зассан үүр, хөөөг устгах;

2.24.3.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дахь хэсэгт заасны дагуу баталсан жагсаалтад орсон

бодисоор малын байр, хашаа саравч, тоног төхөөрөмжийг ариутгах, халдваргүйжүүлэх, шавж устгалд хэрэглэх.

2.25.Нэгж малд ногдох тэжээлийн 70-аас дээш хувийг байгалийн бэлчээр болон өөрийн эзэмшлийн тарималжуулсан органик бэлчээрээс хангах ба үлдсэн хэсэг нь баталгаажсан, эсхүл шилжилтийн үеийн органик тэжээл байна.

2.26.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр энэ журмын 2.24-т заасныг биелүүлэх боломжгүй болсныг баталгаажуулалтын байгууллагаас тогтоосон тохиолдолд нэгж малд жилд ногдох тэжээлийн 30 хүртэлх хувиар тооцож, органик бус тэжээл өгч болно.

2.27.Органик үйлдвэрлэл эрхлэгч эхний жилд үйлдвэрлэсэн тэжээлээ органик тэжээлд тооцон өөрийн мал, амьтныг тэжээж болно.

2.28.Энэ журмын 2.25.-д заасан тэжээлийг органик болохыг илэрхийлсэн тэмдэг бүхий шошготойгоор зах зээлд нийлүүлэхгүй.

2.29.Дараах бодисыг нэмсэн малын тэжээлийг органик бус тэжээлд тооцно:

2.29.1.тухайн төрлийн мал амьтны нядалгааны дайвар бүтээгдэхүүнийг;

2.29.2.хивэгч малын тэжээлийн хувьд малын дайвар бүтээгдэхүүнийг;

2.29.3.мал амьтны баас, хоргол зэрэг бүх төрлийн ялгадсыг;

2.29.4.химийн гаралтай уусгагч бодисыг;

2.29.5.зохиомол аргаар нийлэгжүүлсэн амин хүчил, түүний охь, азотот нэгдлүүдийг;

2.29.6.өсөлт дэмжих ба хурдасгах зориулалт бүхий бодисууд, хоолны дуршил өдөөгч, нөөшлөгч бодисууд, өнгө, будаг оруулагч нэгдлүүдийг;

2.29.7.антибиотик болон бусад эмийн зүйлийг;

2.29.8.шүвтэр;

2.29.9.Байгалийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд зохиомол аргаар нийлэгжүүлсэн цууны, шоргоолжны болон пропаны хүчлийг органик тэжээлийг нөөшлөх зорилгоор хэрэглэж болно.

2.30.Малын тэжээлд дараах бодис, зүйлийг хэрэглэж болно:

2.30.1.бичил биет, мөөгөнцөр, пробиотик ба фермент;

2.30.2.хүнсний үйлдвэрийн байгалийн гаралтай бүтээгдэхүүнүүд;

2.30.3.ургамлын гаралтай бүтээгдэхүүнүүд;

2.30.4.байгалийн гаралтай амин дэм, эрдэс бодис ба нэмэлтүүд.

2.31.Мал, амьтны төлийг эхлээр, эсхүл тухайн төрлийн малын органик сүүгээр тэжээх ба дор дурдсан хугацааны дараа бүдүүн тэжээл өгч болно.

2.31.1.унага, тугалыг 3 сартайгаас;

2.31.2.тооройг 1.5 сартайгаас;

2.31.3.хурга, ишиг болон бусад төл малыг 2 сартайгаас.

2.32.Мал, амьтны эм, эмчилгээний үед органик тэжээлээр сайн тэжээх, стрессгүй орчин бүрдүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйг мөрдсөнөөр өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Өвчилсөн тохиолдолд байгалийн гаралтай эмчилгээ (ургамлын болон уламжлалт аргууд) хэрэглэнэ. Антибиотик, өсөлтийн даавар, химийн эм зэрэг синтетик бодис хэрэглэхийг хориглоно. Хэрэв антибиотик хэрэглэсэн бол тухайн амьтан тодорхой хугацаанд органик статусаа алдана.

2.33.Органик бүтээгдэхүүний хуулийн 7.4-т заасан жагсаалтад орсноос бусад зохиомол аргаар нийлэгжүүлсэн малын эм, антибиотик хэрэглэсэн мал, амьтнаас гарсан бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүнд тооцохгүй.

2.34.Малын чанар, дархлааг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.34.1.малын төрөл зүйл болон сүргийн бүтцийн зохистой харьцааг баримтлах;

2.34.2.тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг үржилд ашиглаж, малын чанарыг сайжруулах;

2.34.3.отор нүүдэл хийх, сэлгэн бэлчээрлүүлэх;

2.34.4.мал маллагааны дэвшилтэт болон уламжлалт арга туршлагыг нэвтрүүлэх, өвс, ус сайтай органик бэлчээрт тогтмол идээшлүүлж, тарга тэвээрэг авхуулах;

2.34.5.мал амьтны тавлаг байдлыг хангах, эрүүл ахуйг сайжруулах замаар мал, амьтны байгалийн өвчин эсэргүүцэх тэсвэрт чадвар, дархлааг сайжруулах.

2.35.Энэ журмын 2.34-т заасны дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй, мал, амьтан өвчилсөн бол тэдгээрийг тохиромжтой хашаа саравчинд тусгаарлан, ургамал, амьтан, эрдсийн гаралтай бэлдмэл, эмийн зүйл, бариа засал, зүү төөнүүр, хануур зэрэг уламжлалт эмчилгээний аргыг ашиглан эмчилнэ.

2.36.Органик статусаа хадгалах зорилгоор малын эм, антибиотикийг санаатайгаар хэрэглэхгүй, удаах, хойшлуулах, мал, амьтны биеийн байдлыг дордуулах, зовоож болохгүй.

2.37.Энэ журмын 2.34.1, 2.34.2, 2.34.3-т заасны дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй бол “Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэх бодисын жагсаалт”-ын 3 дах хэсэгт заасан Мал аж ахуйн органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрөгдсөн бодис”-ын жагсаалтад багтсан зохиомол аргаар нийлэгжүүлсэн малын эм, антибиотикийн эмчилгээг итгэмжлэгдсэн малын эмчийн хяналтын

дор 12 сарын хугацаанд 3 хүртэлх удаа (1 жилээс бага амьдралын мөчлөгтэй амьтны хувьд 1 удаа) хийж болно.

2.38.Энэ журмын 2.35-д заасан эмчилгээ хийлгэсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэсэн тухайн эмийн зааварт заасан биеэс гадагшлах хугацааг 2 дахин уртасгаж органик болохыг илэрхийлсэн тэмдэг бүхий шошготойгоор зах зээлд нийлүүлнэ. Биеэс гадагшлах хугацаа заагаагүй тохиолдолд доод тал нь 48 цагаар тогтооно.

2.39.Энэ журмын 2.37-д зааснаас олон давтамжтайгаар эмчилгээ хийгдсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдэл бүхий шошготойгоор дор дурдсан хугацаанд зах зээлд нийлүүлэхгүй.

2.39.1.бод мал бол 12 сар хүртэлх хугацаанд;

2.39.2.бог мал, гахай, сүүний үхэр бол 6 сарын хугацаанд;

2.39.3.махны чиглэлийн тахиа бол 10 долоо хоногийн дотор;

2.39.4.өндөглөгч тахиа бол 6 долоо хоногийн дотор;

2.40.Малын ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх, өсөлтийг сайжруулах зорилгоор аливаа зохиомол аргаар нийлэгжүүлсэн бодис, бэлдмэлийг хэрэглэхгүй.

2.41.Монгол улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтыг хийнэ.

2.42.Малыг засах, эврийг нь тайрахад өвдөлт, шаналгаа багатай арга хэрэглэх ба шаардлагатай тохиолдолд өвчин намдаах, мэдээ алдуулах эм хэрэглэнэ.

2.43.Малыг туух, ачиж буулгах, тээвэрлэх, төхөөрөх үед гэнэтийн цочролд оруулахуйц аливаа арга, хэрэгсэл хэрэглэхгүй, олон улсад мөрдөгдөж буй зарчмыг баримтална.

2.43.1.Малыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь Махны эрүүл ахуйн дадлын дүрэм MNS CAC RCP 58 : 2013 стандартын шаардлага хангасан байх;

2.43.2Тээвэрлэх болон төхөөрөх үед мал, амьтанд зохиомол аргаар нийлэгжүүлсэн тайвшруулах эм, өдөөгч хэрэглэхгүй ба шаардлагатай тэжээл, усаар хангах;

2.43.3.Малыг тасралтгүй тээвэрлэх хугацаа нь 8 цагаас илүүгүй байх ба тээвэрлэлтийн 8 цаг тутамд малыг амрааж, усалж байх;

2.43.4.Мал амьтныг гэнэтийн цочролд орохоос сэргийлж, тавлаг байдлыг хангаж, өөр төрлийн, үхсэн болон төхөөрч буй мал, амьтдаас тусгаарлах;

2.43.5.Малыг муужруулж, төхөөрнө. Муужруулах багаж хэрэгсэл нь шаардлага хангасан, эвдрэлгүй байх.

2.44.Малыг уламжлалт аргаар төхөөрөх тохиолдолд тайван, чимээгүй эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд гүйцэтгэнэ.

2.45.Мал төхөөрөх газар нь мах, махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.

### **Гурав.Зөгийн аж ахуйн үйлдвэрлэлд тавигдах шаардлага**

3.1.Зөгийн суурийн зохион байгуулалт ба арчилгаа, маллагаанд зөгийн суурь /балт ургамлын нөөцтэй бэлчээрт байрлуулсан хэсэг бүл/-ийг түүнээс 3 км-ын радиус бүхий тойрог дотор сүргийн тэжээлд хүрэлцэхүйц хэмжээний балт, тоост ургамал, усны эх үүсвэртэй органик газар тариалангийн болон атаршсан талбай, байгалийн бэлчээрт байршуулна.

3.2.Энэ журмын 3.1.-д заасан байршил нь органик бус тариалангийн талбай, эсхүл бохирдлын эрсдэл өндөртэй (хувиргасан амьд организм ашигласан таримлын талбай, суурин газар, үйлдвэрийн болон уул уурхайн бүс, асфальтан автозам, хогийн цэг, гэх мэт) газраас 5 км болон түүнээс дээш зайд алслагдсан байна.

3.3.Үйлдвэрлэл эрхлэгч нь зөгийн суурийн байршил, бэлчээр, отрын бэлчээр, нэмэлт тэжээл, тэжээллэг, зөгийн өвчний түүх, эмчилгээ, үр дүн, үржлийн болон өвчилсөн зөгийн бүлийг тусгаарласан эсэх, зөгийн балын гарц, бусад бүтээгдэхүүнийг хурааж авсан талаарх бүртгэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

3.4.Органик бус зөгийн аж ахуйгаас органик зөгийн аж ахуйд шилжих шилжилтийн үеийн хугацаа 12 сар байна.

3.5.Зөгийг сууриар нь органик үйлдвэрлэлд шилжүүлэх ба үржлийн болон сүрэг сэлбэх зөгийн бүл, бүлэнцрийг бүртгэлтэй, баталгаажсан зөгийн органик аж ахуйгаас сонгоно.

3.6.Органик болон органик бус зөгийн аж ахуйн үйлдвэрлэлийг нэг дор хавсарч, тусгаарласан, эсхүл зэрэгцээ байдлаар эрхлэхгүй.

3.7.Амьдрах чадвар, өвчин эсэргүүцэх, нөхөн үржих чадварыг харгалзан тухайн орон нутгийн цаг агаарын болон бусад нөхцөлд дасан зохицох, зөгийн бүл /тус тусын үүргийг гүйцэтгэж амьдардаг нэг эх, хэдэн зуун эр, олон арван мянган ажлын зөгий бүхий биологийн аж ахуйн нэгж /-ийг сонгоно.

3.8.Шилжилтийн үеийн хугацаанд сархиаг /үрвэлдэй бойжуулах, тоосормог, бал боловсруулж хадгалахад зориулагдсан лаваар хийсэн байгууламж/- ийг органик, эсхүл шилжилтийн үеийн сэмж /сархиаг бариулахад хэрэглэдэг ташаалавчны хээтэй лаван хуудас/-ээр солих ба пестицид болон бусад хориглосон бодисын үлдэгдэлгүйг баталгаажуулсан тохиолдолд органик бус сэмжийг ашиглаж болно.

3.9.Энэ журмын 3.4.-д заасан хугацаанд зөгийн суурийн сархиагийг органик сэмжээр солих боломжгүй бол баталгаажуулалтын байгууллага

нь органик үйлдвэрлэлд шилжих шилжилтийн хугацааг сунгана.

3.10.Зөгийн гэрт хуванцар материалаар хийсэн сэмжийг ашиглахгүй байх;

3.11.Зөгийн бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэлгүй, байгалийн гаралтай материалаар зөгийн гэр /зөгийн бүл амьдрахад зориулсан биологийн онцлогт нь тохирсон сууц/, жаазыг хийх;

3.12.Органик үйлдвэрлэл эрхэлдэг зөгийн аж ахуй нь сархиагийг 2 жил тутам шинэчлэх;

3.13.Эх зөгийн далавчийг тайрч болохгүй ба байгалиас заяагдмал физиологийн онцлог шинжийг хадгалах;

3.14.Эх зөгийг зохиомлоор хээлтүүлж болно.

3.15.Зөгийн суурийн ариутгал, халдваргүйтгэлд хортон шавж болон өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал, халдваргүйтгэл хийхдээ хүйтэнд хадгалах аргыг ашиглахаас гадна дараах бодисыг хэрэглэнэ.

3.15.1.сүүний болон шоргоолжны хүчил;

3.15.2.оксалик болон цууны хүчил;

3.15.3.хүхэр;

3.15.4.байгалийн гаралтай эфирийн тос (гаа, евкалипт, камфор гэх мэт);

3.15.5.туринжиенсис бацилус (*BACILLUS THURINGIENSIS*).

3.15.6.Усны уур, галын дөл, эсхүл каустик содоор гэр, жаазыг шууд ариутгаж болно.

3.16.Зөвшөөрөгдсөн бодис бүхий цавууг ашиглан хортон шавж нэвтрэхээс хамгаалж болно.

3.17.Халдварт өвчний үүсгэгчээр бохирдсон жааз, сархиаг ба бусад материалыг устгана.

3.18.Зөгийнд эмчилгээ хийхдээ зөгийн бүлийг сонгож үржүүлэх, зөгийн тэжээллэгийг сайжруулах, зөгийн үүр, жааз, бусад тоног төхөөрөмжийн ариун цэврийг сахих, эх зөгийг тогтмол солих, зөгийн бүл, эр зөгийн ташаалавч /сархиагийн үрвэлдэй бойжуулах, амтат шүүс, тоос хураах зориулалттай зургаан талт нүд/-д тогтмол үзлэг хийх замаар өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

3.19.Зөгийг аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэхэд ургамал, өвсний ханд, байгалийн гаралтай эмийн зүйл, уламжлалт эмчилгээг ашиглана.

3.20.Зайлшгүй шалтгааны улмаас Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэхь хэсэгт заасан жагсаалтад орсноос бусад зөвшөөрөгдөөгүй эм, эмийн зүйлийг хэрэглэсэн зөгийн бүлийг тусгаарлан, нэг жилийн хугацаанд шилжилтийн үед байлгах ба зөгийн бүтээгдэхүүнийг органик болохыг илэрхийлсэн тэмдэг,

тэмдэглэгээтэйгээр зах зээлд худалдахгүй.

3.21.Варроа хачгаар (VARROA MITES) өвчилсөн эр зөгийн сархиагийг устгана.

3.22.Зөгийн тэжээл ба зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнд энэхүү журмын шаардлагыг нэг жилээс доошгүй хугацаанд хангасан болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээтэйгээр зах зээлд худалдаалж болно.

3.23.Бал хураах үеэр, тайвшруулахад ус, цуугаар цацах, мод бусад ургамал, амьтны гаралтай материал ашиглан май тавих зэргээр байгалийн гаралтай дайжуулагчийг хэрэглэнэ.

3.24.Шатах, тослох материал ашиглан зөгийг дайжуулахыг хориглох ба сархиагт байгаа зөгийг устгахгүй.

3.25.Зөгийн балыг битүү орчинд хураана.

3.26.Өндөг, үрвэлдэйтэй сархиагаас бал хураахыг хориглоно.

3.27.Зөгийн балыг хураах, зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулахад дулаан нь цельсийн 45 хэмээс дээшгүй байна.

3.28.Зөгийн бүлийн тэжээлийг өвөлжилтийн хугацаанд зөгийн бүлийг хангалттай хэмжээний зөгийн бал, цэцгийн тоосормогийн нөөцтэй үлдээнэ.

3.29.Нэмэлт тэжээлийг намрын сүүлчийн бал хураалтаас хаврын эхний балт, тоост ургамал ургаж эхлэх үе хүртэл хэрэглэх ба тухайн аж ахуйн, эсхүл органик гаралтай зөгийн бал, органик элсэн чихэр байна.

### **Дөрөв.Органик газар тариалангийн үйлдвэрлэлд тавигдах шаардлага**

4.1.Органик таримлын сорт, үр үржүүлэгт орон нутгийн хөрс, цаг уурын нөхцөлд дасан зохицох чадвартай, ургамлын өвчин, хортон шавьжид тэсвэртэй, эрх бүхий байгууллагаас органик болохыг баталгаажуулсан, таримлын үр үрсэлгээ, төрөл, сортыг сонгож хэрэглэнэ.

4.2.Органик таримлын үр үрсэлгээ нь тоо хэмжээ, төрөл зүйлийн хувьд хүрэлцээгүй бол баталгаажуулалтын байгууллагын хяналтын дор шилжилтийн үед байгаа таримлын үр үрсэлгээ, зөвшөөрөгдөөгүй бодис, пестицид хэрэглээгүй, химийн боловсруулалт хийгдээгүй үр үрсэлгээ, органик баталгаажуулалттай үйлдвэрлэгчийн үрийг соёолуулах болон таримлын аль нэг хэсэг буюу ургал эрхтнийг ургуулах замаар гарган авсан үр үрсэлгээг ашиглаж болно.

4.3.Дотоодод үйлдвэрлэсэн болон импортын үр үрсэлгээг ариутгахад Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу баталсан жагсаалтад заасан бодисыг ашиглана.

4.4.Нэг наст таримлын үр үрсэлгээг нэг жилийн тариалалтын хугацаанд, олон наст таримлын үр үрсэлгээг хоёр жилийн тариалалтын хугацаанд органик зарчмаар үржүүлсэн тохиолдолд “органик үр

үрсэлгээ” гэж баталгаажуулж болно.

4.5.Органик бус газар тариалангийн үйлдвэрлэлээс органик газар тариалангийн үйлдвэрлэлд шилжих шилжилтийн үеийг дор дурдсан хугацаанд эхлүүлнэ:

4.5.1.нэг наст таримлыг тариалахаас 12 сарын өмнө;

4.5.2.бэлчээр болон нугын ургамлыг хадаж, бэлчээрийн зориулалтаар ашиглахаас 12 сарын өмнө;

4.5.3.олон наст таримлыг хураахаас 18 сарын өмнө;

4.5.4.жимсний мод, бутыг хураалтаас 24 сарын өмнө.

4.6.Хөрсний үржил шимийг хадгалах, хамгаалах болон бордоо хэрэглэхэд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан жагсаалтад орсноос бусад бодисыг ашигласан талбайгаас хураасан ургацыг органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдэл бүхий шошготойгоор зах зээлд нийлүүлэхгүй.

4.7.Тэг элдэншүүлэг, цомхотгосон технологи хэрэглэх, зурваслан, эсхүл сэлгэн тариалах, нөмрөг таримлыг ашиглах зэрэг арга технологийг ашиглан хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг бууруулахгүйгээр сайжруулах асуудлыг баталгаажуулалтын байгууллагатай хийх гэрээнд тусгана.

4.8.Таримлыг хортон шавж, хог ургамал, өвчнөөс биологийн аргаар хамгаална.

4.9.Органик тариалангийн үйлдвэрлэлд сэлгэн тариалалтыг заавал ашиглана.

4.10.Буурцагт ургамал, сахлаг болон голлосон үндэсний системтэй таримлыг сэлгээнд ашиглана.

4.11.Жимсний мод бутны мөр хоорондын зайд нөмрөг болон хучлага таримлыг хөрс хамгаалах зорилгоор тариалж болно.

4.12.Органик тариалангийн талбайг уриншлахдаа ногоон бордуурт уриншийг ашиглана.

4.13.Ургацаар алдагдсан шим тэжээлийн бодисыг хөрсөнд эргүүлэн өгөх зарчмыг хэвшүүлэн, сүрэл болон ургамлын үлдэгдлийг талбайд хучлага байдлаар үлдээж ашиглана.

4.14.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн жагсаалтад заасан хөрс, ус, хүрээлэн буй орчин, амьд биетэд сөрөг нөлөөгүй, хүнсний үйлдвэрлэл, ахуйн ялгаж ангилсан хаягдал, дайвар бүтээгдэхүүн, бичил биет, ургамал, амьтны үлдэгдлээр дотоод нөөц бололцоогоо ашиглан өөрийн аж ахуйд багсармал бордоо бэлтгэж ашиглана.

4.15.Хүнсний зориулалтаас бусад таримлын хөрсийг хүний ялгадас агуулсан бордоогоор бордож болно.

4.16.Байгалиас олборлож, буталж, жижиглэсэн эрдэс бордоог ашиглаж болно.

4.17.Хөрсгүй технологи (гидропоник г.м)-ийг ашиглан ургуулж тариалахыг хориглоно.

4.18.Органик аргаар мөөг тарих хөрс нь органик болон байгалийн гаралтай, химийн аргаар боловсруулаагүй хөрс, бууц, эрдэс, модны үртэс, сүрэл, зоргодос агуулсан байна.

4.19.Саарал ус (ахуйн болон албан байгууллагын шүршүүр, угаалтуур, угаалгын машин, аяга таваг угаагчийн хэрэглээнээс бий болсон хаягдал ус гм)-ыг хүнсний зориулалттай таримлыг услахад ашиглахгүй.

4.20.Хортон шавж, өвчин, хог ургамалтай тэмцэхэд биологийн, физик механик, нутгийн уламжлалт арга технологид суурилсан ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж, хортон шавж, хачиг, өвчин, дугариг хорхой, хог ургамал зэрэгтэй дараах байдлаар тэмцэнэ.

4.20.1.таримлын төрөл, зүйл, сортыг зохистой сонгох;

4.20.2.сэлгээ, холимог тариалалт, ногоон бордуур хэрэглэх, талбайг хучих зэрэг хөрс боловсруулах зохистой арга ажиллагааг ашиглах;

4.20.3.хөрс боловсруулалтыг гар болон механикжсан (химийн бус) аргаар гүйцэтгэх;

4.20.4.хог ургамлыг гар болон механик аргаар устгах;

4.20.5.хамгаалалтын зурвас байгуулан хортон шавжийн эсрэг ашигтай шавж, өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх;

4.20.6.урхи, хавх, хашлага нүх, суваг шуудуу, гэрэл, дуу чимээ, халуун уур, хөрс хөлдөөх, утаа ашиглах зэрэг механик арга хэрэглэх;

4.20.7.тухайн нутагт ургадаг, идэвхтэй бодис нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан жагсаалтад орсон, бусад орц нь хавдар, удамшлын болон төрөлхийн гажиг, тархины саажилт зэрэг өвчлөлийг үүсгэх эрсдэлтэй найрлага агуулаагүй ургамлын ханд, амьтан, бичил биетэн ашиглан бэлдмэл хийх.

4.21.Энэ журмын 4.20-д заасан арга хэмжээ нь хортон шавж, өвчин, хог ургамалтай тэмцэхэд үр дүн муутай бол Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан жагсаалтад орсон Органик газар тариалангийн үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн ургамал хамгааллын бодис болон өсөлт зохицуулагчийн жагсаалтад заасан бодисыг хэрэглэнэ.

4.22.Аюулт үзэгдлийн болон хог ургамлын тархалтын үед энэ журмын 4.20-д заасан арга хэмжээ үр дүнгүй бол үйлдвэрлэл эрхлэгч баталгаажуулалтын байгууллагын хяналтын дор зөвшөөрөгдсөнөөс

бусад бодисыг хэрэглэж болох ба ийнхүү хэрэглэснээс 36 сар хүртэлх хугацаанд хураасан ургацыг “органик” болохыг илэрхийлсэн тэмдэг, хаяг шошготойгоор зах зээлд нийлүүлэхийг хориглоно.

4.23.Органик үйлдвэрлэгч нь хөрс, ус, таримал, үр үрсэлгээ болон бусад орцууд нь хүрээлэн буй орчноос, эсхүл зөвшөөрөгдөөгүй бодисоор бохирдохоос сэргийлэх.

4.24.Талбайн түүхийн дэвтэр, таримал бүрд ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтөлнө.

4.25.Нийслэл хот, бусад төвлөрсөн хот суурин газарт эрлэх органик газар тариалангийн үйлдвэрлэл нь ачаалал ихтэй (жилийн дундаж үзүүлэлтээр тооцоход өдөрт 3,000-аас олон машин, тээврийн хэрэгсэл зорчих) зам, уулзвараас 300м, хүнд, хөнгөн үйлдвэрийн байгууламжаас 1000 м болон түүнээс дээш зайд байрлана.

4.26.Энэ журмын 4.22-д заасан шаардлага нь хүлэмжийн аж ахуй эрхлэхэд хамаарахгүй.

4.27.Органик газар тариалангийн үйлдвэрлэл нь органик бус аж ахуйгаас зурвас, саадаар тусгаарлагдсан байна.

4.27.1.ил талбайд органик болон органик бус аж ахуйг хавсран, зэрэг эрхэлдэг бол өөрийн эзэмшлийн химийн гаралтай пестицид хэрэглэсэн газраас 30м, химийн гаралтай бордоо хэрэглэсэн газраас 10м хүртэлх зурвасаар;

4.27.2.хөрш аж ахуй нь органик бус газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг бол органик тариалангийн газрыг 50м-ээс доошгүй зурвасаар.

4.28.Органик аж ахуйд органик бус газар тариалангийн аж ахуйд хэрэглэсэн, аливаа тоног төхөөрөмж, багажийг хэрэглэхээс өмнө Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасан жагсаалтад орсон тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн бодисоор сайтар ариутгаж, цэвэрлэнэ.

4.29.Хучлага, шавжны тор хийх, тэжээл, сүрэл бооход газрын хөрсөнд өөрөө задарч, шингэдэг сүрэл, эсгий зэрэг нийлэг бус материалыг ашиглана.

4.30.Энэ журмын 4.28-д заасан үйл ажиллагаанд зохиомол аргаар нийлэгжүүлсэн газрын хөрсөнд шингэдэггүй синтетик материал хэрэглэсэн тохиолдолд зөвхөн полиэтилен, полипропилен болон бусад поликарбонат суурьтай материалыг ашиглах ба ашиглалтын дараа талбайд шатаах, булахаас өөр аргаар, холбогдох хууль, журмын дагуу хөрснөөс зайлуулна.

4.31.Хамгаалагдсан хөрсний аж ахуйд үр үржүүлгээс бусад тохиолдолд таримлыг хөрсөнд ургуулна.

4.32.Хөрсийг нарны гэрлийн дулааныг ашиглан ариутгана.

4.33.Зохиомол гэрэлтүүлгийг шаардлагатай тохиолдолд ашиглах ба өдөрт 16 цагаас ихгүй байна.

4.34.Зохиомол гэрэлтүүлэг, дулаан, хөргөлт, агааржуулалт, чийгшил болон бусад бичил цаг уурын нөхцөл бүрдүүлэхэд шаардагдах эрчим хүчний хэрэглээг тогтмол хянаж, бүртгэн, үр ашигтай зарцуулна.

#### **Тав.Органик хүнсийг боловсруулах үйлдвэрлэлд тавигдах шаардлага**

5.1.Органик хүнс үйлдвэрлэлд бүхэлдээ шилжээгүй (тусгаарласан үйлдвэрлэл), эсхүл нэг ижил бүтээгдэхүүнийг органик болон органик бус зарчмаар нэг аж ахуйн нэгжид зэрэг үйлдвэрлэх (зэрэгцээ үйлдвэрлэл) шаардлагатай тохиолдолд органик үйлдвэрлэгч нь баталгаажуулалтын байгууллагад урьдчилан мэдэгдэх ба органик хүнсийг органик бус түүхий эд, бүтээгдэхүүнээс тусад нь боловсруулж, ангилан хадгалж, тээвэрлэж, бүртгэл хөтлөн, холбогдох бичиг баримтаар баталгаажуулна.

5.2.Үйлдвэрлэлийн үндсэн шугам, тоног төхөөрөмжид ариутгал, халдваргүйтгэл хийж, органик хүнсний түүхий эд болон бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдохоос сэргийлэх арга хэмжээг бүрэн авсны дараа органик бүтээгдэхүүнийг зэрэгцээ үйлдвэрлэж болно.

5.3.Органик хүнс үйлдвэрлэгч нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь хэсэгт заасны дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлж, түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хангана.

5.4.Органик хүнс үйлдвэрлэгч нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу органик хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хөтөлнө.

5.5.Органик хүнс үйлдвэрлэгч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэж, органик үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, мал амьтан, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг олж тогтоон, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.6.Органик хүнсний бүтээгдэхүүний орцод органик хүнсийг боловсруулахад баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, гэрчилгээ бүхий органик түүхий эдийг ашиглана.

5.7.Бүтээгдэхүүний үндсэн түүхий эдтэй химийн урвалд орж, шинж чанарыг нь өөрчилдөг хүнсний нэмэлт, боловсруулалтын үед ашиглах туслах бодис нь органик баталгаажуулалттай, эсхүл Органик

бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасан жагсаалтад орсон байх ба органик хүнсийг боловсруулахад баталсан нөхцөлийн дагуу ашиглана.

5.8.Органик хүнс үйлдвэрлэгч нь хүнсний бүтээгдэхүүнийхээ органик болон органик бус орцын хувь хэмжээг Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний органик орцын хувь хэмжээг тооцох аргачлалын дагуу тооцож, органик болохыг илэрхийлсэн тэмдгийг загварын дагуу хэрэглэж, нийтийн хэрэгцээнд нийлүүлнэ.

5.9.Энэ журмын 5.7-д заасан түүхий эдийн тоо хязгаарлагдмал, чанар хангалтгүй бол баталгаажуулалтын байгууллагын хяналтын дор энэ журам хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн хугацаанд хувиргасан амьд организм болон тэдгээрийг агуулаагүй, нано материал ашиглаагүй эсхүл шилжилтийн үед байгаа органик бус түүхий эдийг ашиглаж болно.

5.10.Хүнсний бүтээгдэхүүний орцод зэрэгцээ үйлдвэрлэсэн нэг ижил төрлийн органик болон органик бус түүхий эдийг хольж болохгүй.

5.11.Бүтээгдэхүүнд органик амт, үнэр оруулагчийг хэрэглэх ба эдгээрийн тоо хязгаарлагдмал бол баталгаажуулалтын байгууллагын хяналтын дор дараах шаардлага хангасан амт, үнэр оруулагчийг ашиглаж болно.

5.11.1.байгаль (ургамал, амьтан, эрдэс)-ийн гаралтай байх;

5.11.2.органик үйлдвэрлэлийн зарчимд нийцсэн арга технологиор боловсруулсан байх;

5.11.3.тос, ус, этанол, нүүрстөрөгчийн давхар ислийг уусгагчаар ашиглан механик болон физик аргаар боловсруулсан байх.

5.12.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад багтсан баяжуулагч бэлдмэл хэрэглэж болно.

5.13.Хувиргасан амьд организмаас гаралтай бичил биет болон түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бусад хүнсний үйлдвэрлэлд нийтлэг хэрэглэгддэг бичил биет ба ферментийн бэлдмэлийг хэрэглэж болно.

5.14.Органик хүнс болон малын тэжээлд органик орчинд өсгөвөрлөж, бэлтгэсэн, эсхүл өөрийн үйлдвэрт өсгөвөрлөсөн бичил биетийг ашиглаж болно.

5.15.Органик хүнсийг биологи, механик болон физикийн арга, эсхүл тэдгээртэй ижил төстэй уламжлалт, байгалийн арга технологийг ашиглан боловсруулна.

5.16.Органик үйлдвэрлэлд ус, этилийн спирт, нүүрстөрөгчийн давхар исэл, тосыг уусгагчаар ашиглана.

5.17.Дэвтээх, эсхүл шингэлэх зорилгоор усыг ашиглаж болно.

5.18.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу

жагсаалтаар баталсан бодисыг ашиглан шүүх ба шүүлтүүр нь азбест болон бүтээгдэхүүнд сөрөг нөлөө үзүүлэх эд анги, бодисыг агуулаагүй байна.

5.19.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу жагсаалтаар баталсан бодисыг хэрэглэн бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг дараах технологи ажиллагааг ашиглан уртасгаж болно.

5.19.1.агаарын бүрэлдэхүүнийг өөрчлөх (вакумдах г.м);

5.19.2.боловсруулах хэмийг тохируулах (хөлдөөх, гүн хөлдөөх, халаах, тогтмол температурт боловсруулах);

5.19.3.хатаах;

5.19.4.чийгшлийг тохируулах.

5.20.Органик хүнстэй харьцах гадаргуу, тоног төхөөрөмжийн материалын бүтэц нь нано бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй байна.

5.21.Органик хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав баглаа боодлын материал нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21-р зүйлийн 21.3 дахь хэсгийн шаардлагыг хангасан байна.

5.22.Сав баглаа боодлын материал нь дахин боловсруулсан болон зохиомол аргаар нийлэгжүүлсэн мөөгөнцрийн эсрэг бэлдмэл, нөөшлөгч бодис, үнэртэн болон нано бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй байна.

5.23.Органик хүнсийг эргэлтийн, дахин боловсруулах боломжтой, экологийн хувьд аюулгүй, байгальд шингэж, задардаг материал бүхий сав баглаа боодолд савлах бөгөөд материал болон хэлбэр загварын хувьд хэмнэлттэй байхаар төлөвлөгдөж, үйлдвэрлэгдсэн байна.

5.24.Үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу баталсан “Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэх бодисын жагсаалт”-д заасан бодисоор ариутгал цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх замаар органик хүнсийг хортон шавж, мэрэгч, тэдгээрээс гаралтай бохирдлоос хамгаална.

5.25.Органик үйлдвэрлэл эрхлэгч нь дор дурдсан аргыг дарааллын дагуу ашиглан хортон шавжтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулна.

5.25.1.үүр болон амьдрах орчныг нь устгах, үйлдвэрийн байр, орчин руу нэвтрэхээс механик аргаар урьдчилан сэргийлэх;

5.25.2.хяналтын камер, авиа, хэт авиа, нарны гэрэл, нарны хэт ягаан туяа, агаарын хэмийг тохируулах арга, цахиурын исэл, агаарын хийн бүрэлдэхүүнийг өөрчлөх зэрэг механик, физик ба биологийн аргуудыг хэрэглэх;

5.25.3.Органик бүтэгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасны дагуу баталсан бодисын жагсаалтад заасан бодисыг хэрэглэх;

5.25.4.Пестицидээс бусад өгөөштэй хавхыг хэрэглэх.

5.26.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийн 13.15- д заасан тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага нь хортон шавж, мэрэгчийг устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаандаа энэ журмын шаардлагыг хангаж ажиллана.

5.27.Хортон шавж, мэрэгчийг утахад этилений исэл, метилбромид, фосфорт хөнгөн цагаан болон ионжуулсан цацраг ашиглахгүй.

5.28.Энэ журмын 5.25-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч гэсэн үр дүнгүй болбол баталгаажуулалтын байгууллагын хяналтын дор органик бүтээгдэхүүн, тэдгээрийн сав баглаа боодлыг үйлдвэр, агуулахаас зөөж холдуулан, бохирдлоос сэргийлсний дараа Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т зааснаас бусад бодисоор хортон шавж, мэрэгчийг устгах, саармагжуулах ба үүнийг баримтжуулсан байна.

5.29.Органик түүхий эд, бүтээгдэхүүний бохирдлыг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь хэсэгт заасан үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлж, хянана.

5.30.Органик хүнстэй шууд харьцах гадаргууг цэвэрлэх, ариутгах, халдваргүйжүүлэхэд ундны ус, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу баталсан “Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, хэрэглэх бодисын жагсаалт”- д заасан бодисыг зааврын дагуу хэрэглэнэ.

5.31.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу баталсан “Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэх бодисын жагсаалт”-д тусгагдаагүй бодис ашиглан цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх зайлшгүй шаардлага тулгарсан тохиолдолд баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэж, бүтээгдэхүүнийг бохирдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, саармагжуулах арга хэмжээг авч, энэ талаар бүртгэл хөтөлж, баримтжуулна.

5.32.Органик бүтээгдэхүүнтэй шууд харьцдаг гадаргууд энэ журмын 6.6.3 дахь хэсэгт заасны дагуу ариутгал цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн тохиолдолд тухайн цувралын бүтээгдэхүүнд органик болохыг илэрхийлсэн тэмдгийг хэрэглэхгүй.

### **Зургаа.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг органик зарчимд нийцүүлэн эрхлэх**

6.1.Органик хоолны газарт MNS 6777:2019 “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томьёо, тодорхойлолт” стандартын 3.2-3.15-

д заасан хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн аж ахуйн нэгж нь сайн дурын үндсэн дээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээ органик зарчимд нийцүүлэн эрхэлж болно.

6.2.Органик зарчимд нийцэх шилжилтийн үеийн хугацаа нь 12 сар хүртэл байж болно.

6.3.Хэрэв хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийг бүхэлд нь баталгаажуулах бол баталгаажуулалт нь бүх нэгж, үйл ажиллагаанд хамаарна. Харин зөвхөн өглөөний цайны хэсгийг баталгаажуулах боломжгүй.

6.4.Хоолны газрыг бүхэлд нь баталгаажуулахгүйгээр хоолны цэсэд органикийг гэрчлэх тэмдэглэгээг хийсэн органик хоол санал болгож болно.

6.5.Органик хоолны газар нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь хэсэгт заасны дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээний шатанд үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал, энэ журам болон MNS 4946:2019 “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага”, MNS CAC RCP 39:2011 “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал” стандартын шаардлагыг мөрдөж, хоолны аюулгүй байдлыг бүрэн хангана.

6.6.Органик хоолны газар нь танхимаар эсхүл хэрэглэгчийн захиалгаар хүргэх хэлбэрээр үйлчилгээ үзүүлж болно.

6.7.Органик сүлжээ хоолны газрын нэгж бүр энэ журмыг мөрдөж ажиллана.

6.8.Органик хоолны газрын ажилчид нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээ органик зарчимд нийцүүлэн эрхлэх цахим сургалтад хамрагдаж, эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

6.9.Органик хоол, органик орц найрлагыг бүрдүүлж буй бүтээгдэхүүн, түүхий эд, хүнсний нэмэлт, орцын бүрэлдэхүүн хэсэг тус бүр органик баталгаажуулалттай, бүртгэлийн дугаартай, ул мөрийг мөшгөх бичиг баримттай байна.

6.10.Зөвхөн баталгаажуулалтын гэрчилгээтэй, бүртгэлтэй органик ханган нийлүүлэгчээс органик хүнс, худалдаж авна.

6.11.Бүтээгдэхүүн, түүхий эдийн байгалийн шинж чанар, шим тэжээлийг хадгалах биологийн болон физикийн гаралтай боловсруулах аргыг ашиглаж органик хоолыг боловсруулна.

6.12.Зохиомол аргаар нийлэгжүүлсэн нэмэлт, амт оруулагч, будагч бодис, хадгалалтын бодис, цацраг идэвхт боловсруулалт ашиглахыг хориглоно.

6.13.Органик хоолны бүх төрлийг үйлчилгээнд гаргахын өмнө ерөнхий (ахлах) тогооч тэдгээрийн амт, үнэр, өнгө, үзэмж, жор найрлага, боловсруулалт зэрэгт чанарын шалгалт хийж үйлчилгээнд гаргах зөвшөөрөл олгож, энэ тухай албан ёсоор тэмдэглэл хөтөлнө.

6.14.Органик хоолны дээжийг журмын дагуу авч хөргөгчид 4°C хэмд 48 цаг тусгайлан хадгална.

6.15.Органик хоолны газрын шавж, мэрэгчтэй тэмцэх, цэвэрлэгээ, ариутгал хийх бодис нь Органик үйлдвэрлэлд ашиглахыг зөвшөөрөгдсөн бодисын жагсаалтад орсон бодис байна.

6.16.Органик хоолны газар нь хүнсний хаягдлыг тодорхой түвшинд багасгах, бууруулах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллана.

6.17.Ашиглаж буй ундны усны шүүлтүүрт асбест хэрэглэхгүй.

6.18.Органик хоолны цэс нь органик болон органик бус орцыг хялбар таньж ялгах боломжтой байна.

6.19.Мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүн нь мал ахуйн органик үйлдвэрлэлийн журам, стандартын дагуу баталгаажсан органик аж ахуйгаас гаралтай, мэдээллийн сангийн бүртгэлийн дугаартай, шошго нь органик болохыг илэрхийлсэн тэмдэгтэй байна.

6.20.Байгалиас түүсэн, авласан ангийн мах, жимс жимсгэнийг эрх бүхий байгууллагаас баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр гэрчилгээгүй бол органикт тооцохгүй.

6.21.Органик хоол, органик орц найрлагыг бүрдүүлж буй бүтээгдэхүүн, түүхий эд, хүнсний нэмэлт, орцын бүрэлдэхүүн хэсэг тус бүр хувиргасан амьд организмгүй гэдэг нь нотлогдсон байна.

6.22.Органик бус түүхий эдийг дараах нөхцөлд ашиглаж болно:

6.22.1.ижил төрлийн Органик бүтээгдэхүүн, түүхий эд, хүнсний нэмэлт, орцын бүрэлдэхүүн хэсэг нь зах зээлд байхгүй эсвэл хангалтгүй байгаа тохиолдолд;

6.22.2.Тухайн бүтээгдэхүүний түүхий эд, хүнсний нэмэлт, орцын бүрэлдэхүүн хэсэг нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-т заасны дагуу баталсан жагсаалтад орсон байх.

6.23.Органик хоол, хоолны газрын хаяг, шошгод Органик бүтээгдэхүүний хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-д заасан Органик бүтээгдэхүүний орц, найрлага тооцох аргачлалын дагуу цэсэд байгаа хоолны жин, илчлэг, органик орцын хувь хэмжээг тооцон, нэршлийг үнэн зөв, бодитойгоор мэдээлсэн байна.

6.24.Халуун, хүйтэн хоол, ундаа, зууш (загас, дарснаас бусад), нарийн боовны 95%-иас дээш орц нь (ус, давснаас бусад) органик гэрчилгээтэй, мэдээллийн санд бүртгэлтэй тохиолдолд хоолны оноосон нэрийн өмнө органик болохыг илэрхийлсэн тэмдэг, мэдэгдлийг цэсэд байршуулна.

6.25.Халуун, хүйтэн хоол, ундаа, зууш (загас, дарснаас бусад), нарийн боовны органик орц нь (ус, давснаас бусад) 70- 95% байвал цэсэд хоолны оноосон нэрийн өмнө органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдэл хэрэглэхийг хориглох бөгөөд хоолны оноосон нэрийн доод хэсэгт хамгийн өндөр хувьтай 3 хүртэлх органик орцын нэрийг зааж, “Органик ... -тай хоол” мэдэгдлийг ашиглаж болно.

6.26.Органик гэсэн үгийн бичвэр нь бусад орцын талаар мэдээлсэн бичиглэлээс өөр өнгө, хэмжээтэй, онцгой байж болно.

6.27.Халуун, хүйтэн хоол, ундаа, зууш, нарийн боовны органик орц нь (ус, давснаас бусад) 30-70% байвал орц бүрдүүлэгчийг жингийн буурах дарааллаар тусгах бөгөөд органик орцын бичвэр нь бусад орцын талаар мэдээлсэн бичиглэлээс өөр өнгө, хэмжээтэй, онцгой байж болохгүй.

6.28.Нийт хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд органик хоол 60%, орон нутгийн, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмждэг ханган нийлүүлэгчдээс түүхий эд, бүтээгдэхүүн 40% эзэлж байвал байгууллагын хаяг дээр органик болохыг илэрхийлсэн тэмдэг, Органик хоолны газар мэдэгдлийг тавьж болно.

6.29.Энэ журмын 6.24-т зааснаас бусад тохиолдолд байгууллагын хаяг дээр органик болохыг илэрхийлсэн тэмдэг, мэдэгдлийг тавихгүй байх, зөвхөн хоолны цэсэд тавина.

6.30.Баталгаажуулаагүй, гэрчилгээгүй, бүртгүүлээгүй тохиолдолд хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 13.6-д заасан монгол болон гадаад хэлээр бичигдсэн «органик», «байгалийн цэвэр», «байгалийн гаралтай цэвэр», «эко», «ногоон», «экологийн гаралтай», «экологийн цэвэр», «экологийн», «био», «биологийн», «биологийн гаралтай», «биологийн цэвэр» гэсэн үг болон эдгээртэй агуулгын хувьд дүйцэх үгийг хоолны цэсэд хэрэглэхгүй.

6.31.Органик хоолны газарт органик, органик бус түүхий эд, бүтээгдэхүүнээр зэрэгцээ, тусгаарласан үйлдвэрлэл явуулж болно.

6.32.Дам бохирдлоос сэргийлэхийн тулд органик болон органик бус хүнсийг тусад нь хадгалж, тээвэрлэж, бэлтгэх зохион байгуулалттай байна.

6.33.Органик хүнсийг ангилж, төрөлжүүлэн технологийн дагуу тусад нь өөр өнгийн тавиурт байршуулж, хурааж хадгална.

6.34.Тавиурын нүүрэн талд органик хүнсний нэр, бүлэг, нэр төрөл, байршил, нөөц тоо хэмжээ, агуулахад хүлээн авсан он, сар, өдөр зэрэг үзүүлэлтийг тодорхойлсон хаяг, тэмдэглэгээг хийнэ.

6.35.Органик хүнсийг бэлтгэх, боловсруулах багаж хэрэгсэл, бэлэн хоол, зууш, ундыг халуун, хүйтэн байлгах төхөөрөмж, халбага, хутгуур, хавчаар, хоолны гүний температурыг хэмжигч багаж нь органик бус

хүнсэнд хэрэглэгдгээс тусдаа байна.

6.36.Хоолны газрын ажилчид нь органик орцыг органик бус орцтой холих, органик хүнсийг бохирдохоос урьдчилан сэргийлж, зайлсхийх арга хэмжээ авна.

6.37.Хүнстэй хүрэлцэх гадарга нь шууд хүрэлцэх хуванцар сав, уут, нэг удаагийн сав баглаа боодол нь хүнсний зориулалтын, химийн хорт бодисын шилжилтгүй, фталат, бисфенол агуулаагүй, байгальд ээлтэй, задардаг байна.

6.38.Хүнстэй шууд хүрэлцэх гадаргуу нь нано материалаар хийгдээгүй байна.

6.39.Нэг удаагийн сав баглаа боодол нь эдийн засгийн хэмнэлттэй, дахин боловсруулж дахивраар ашиглах боломжтой материалаар хийгдсэн байна.

6.40.Баталгаажуулалт нь байгууллагын хаяг дээр органик болохыг илэрхийлсэн тэмдэг, Органик хоолны газар гэсэн мэдэгдлийг тавьсан бүх аж ахуйн нэгж нь органик хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

6.41.Гэрчилгээ олгогч байгууллага нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийнэ.

6.42.Органик хоолны газар нь бүх орц, гарал үүслийн бүртгэл, баримтыг хөтөлж, шалгалтад бэлэн байлгана.

### **Долоо.Хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх**

7.1.Органик түүхий эдэд тулгуурласан ноос, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, шошгололт, баталгаажуулалт, хяналт, гэрчилгээ олголтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлох, улмаар бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулахад оршино.

7.2.Органик гаралтай ноос, ноолуур, арьс, ширэн түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, холбогдох үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, хоршоо, үйлдвэр, баталгаажуулалтын байгууллага болон холбогдох хяналтын байгууллага байна.

7.3.Хүнсний бус органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч нь органик түүхий эдийн гарал үүслийг нотлох, мөшгөх, бүртгэл хөтлөх, баримтжуулах тогтолцоог бүрдүүлсэн байна.

7.4.Үйлдвэрлэлийн бүх шатанд хэрэглэгдэх түүхий эд, туслах материал, химийн бодис, нэмэлт, наалдуулагч, будаг зэрэг нь хүн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, баталгаатай, органик эсхүл байгальд ээлтэй гаралтай байна.

7.5.Үйлдвэрлэлийн бүхий л шатанд эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний эрх, нийгмийн хариуцлагын зарчмыг хэрэгжүүлж, ажилтны эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөлийг хамгаална.

7.6.Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь байгаль орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хаягдлыг дахин ашиглах, ус, эрчим хүчний хэрэглээг оновчлох, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх зарчимд тулгуурлана.

7.7.Органик бүтээгдэхүүнд зориулсан үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, савлагаа, шошгололт нь органик бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй хольж ашиглагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.8.Үйлдвэрлэгч нь хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, бүтээгдэхүүний гарал үүсэл, найрлага, органик орцын хувь, баталгаажуулалтын байгууллагын нэр, гэрчилгээний дугаар зэргийг тодорхой ил тод мэдээлнэ.

7.9.Бүтээгдэхүүний чанар, гарал үүслийн бүртгэл, хяналт, баталгаажуулалт нь итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын схем, журмын дагуу хэрэгжинэ.

7.10.Органик орц, найрлага гэж органик үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан, гарал үүслийн баримт бүхий, баталгаажсан түүхий эд болон нэмэлт материалыг ойлгоно.

7.11.Органик ноос, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүн нь нийт орц, найрлагын 95 ба түүнээс дээш хувийг органик гаралтай түүхий эдээс бүрдүүлсэн байна.

7.12.Хэрэв органик орц, найрлагын хувь хэмжээ 70–94% байвал “органик орцтой бүтээгдэхүүн” гэж нэрлэнэ. Ийм тохиолдолд шошгололтод “органик орцтой” гэж тусгайлан тэмдэглэнэ.

7.13.Органик бүтээгдэхүүнд ашиглагдах түүхий эд, нэмэлт материал, туслах бодис нь дараах байдлыг хангана.

7.13.1.Хүн болон байгаль орчинд хоргүй, дахин сэргээгдэх гаралтай байх;

7.13.2.Химийн нийлэг бодис, хлор, фталат, формальдегид, PFAS, азо будагч бодис агуулаагүй байх;

7.13.3.Баталгаажсан органик мал аж ахуй ферм, үйлдвэр, нийлүүлэгчээс хангагдсан байх;

7.13.4.Тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалтын явцад органик бус бүтээгдэхүүнтэй холилдох, бохирдохоос сэргийлсэн нөхцөлд хадгалагдсан байх.

7.14.Ноос, ноолуурын бүтээгдэхүүний хувьд:

7.14.1.Органик орц нь баталгаажсан мал аж ахуйгаас гарсан ноос, ноолуураар бүрдэнэ;

7.14.2.Ээрэх, угаах, будгийн явцад органик бус бодис нэмэхийг хориглоно;

7.14.3.Будаг, зөөлрүүлэгч, угаагч бодис нь ургамлын эсвэл байгалийн гаралтай байна;

7.14.4.Ноос, ноолуурын холимог бүтээгдэхүүнд органик ба органик бус орцын хувь хэмжээг тодорхой зааж шошголж тэмдэглэнэ.

7.15.Арьс, ширэн бүтээгдэхүүний хувьд:

7.15.1.Органик орц нь хром болон синтетик бодисоор идээлээгүй, ургамлын гаралтай эсвэл биотехнологийн аргаар боловсруулсан түүхий арьс байна;

7.15.2.Идээлэг, будах, өнгөлөх, тослох үйл явцад байгальд ээлтэй, хорт нэгдэлгүй бодис хэрэглэнэ;

7.15.3.Будаг, тос, наалдуулагч бодис нь ISO 14024, IVN, GOTS-ийн шаардлагад нийцсэн байх;

7.16.Органик ноос, ноолуур, арьс, ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэглэгдэх туслах материал (оёдлын утас, доторлогоо, наалдуулагч, гоёл чимэглэл, өнгөлөгч, хамгаалалтын бүрхүүл зэрэг) нь баталгаажсан органик эсвэл гарал үүслийн баримттай, байгальд ээлтэй, химийн хорт бодис агуулаагүй, баталгаажсан гарал үүслийн баримттай нотолгоо бүхий гэрчилгээтэй байна.

7.17.Үйлдвэрлэгч нь эдгээр материалын гарал үүслийг нотлох дараах баримт бичгийг бүрдүүлж хадгална:

7.17.1.Материалын гарал үүслийн гэрчилгээ эсхүл нийлүүлэгчийн баталгааны мэдэгдэл;

7.17.2.Материалын техникийн тодорхойлолт, химийн найрлагын мэдээллийн хуудас (MSDS);

7.17.3.Баримт бичгээр нотлогдоогүй материал ашигласан тохиолдолд тухайн бүтээгдэхүүнийг органик гэж хүлээн зөвшөөрөхгүй.

7.17.4.Хэрэв органик болон дахин боловсруулсан хувилбар зах зээлд байхгүй бол энэ талаар нотолгоог хавсарган баталгаажуулалтын байгууллагад тайлагнана.

7.18.Органик орц, найрлагын бүрдэл, гарал үүслийг нотлох баримт бичиг, гэрчилгээ, бүртгэлийг баталгаажуулалтын байгууллага хянаж, бүртгэлд авна.

7.19.Түүхий эд, гарал үүсэл, мөшгөлт баримтжуулалт нь органик ноос, ноолуур, арьс, ширний үйлдвэрлэлд ашиглагдах түүхий эд нь баталгаажсан органик гаралтай, гарал үүслийн нотолгоотой байна.

7.20.Түүхий эд нь малын эрүүл мэнд, байгаль орчны хамгааллын шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, өрхөөс гаралтай байна.

7.21.Түүхий эд нь органик мал аж ахуйн гэрчилгээтэй, гарал үүслийн бүртгэл, вакцинжуулалт, тэжээл, эмчилгээний мэдээллээр баталгаажсан байна.

7.22.Хорт бодис, хоргүйжүүлэгч, өнгө оруулагч зэрэг химийн боловсруулалт хийгдээгүй байх, бохирдлоос хамгаалсан нөхцөлд хадгалагдсан байна.

7.23.Гарал үүслийн тодорхойгүй, органик бус түүхий эдийг органик үйлдвэрлэлд ашиглахыг хориглоно.

7.24.Мал амьтны гарал үүсэлтэй органик түүхий эдийг үйлдвэрлэл, боловсруулалт, баталгаажуулалт, борлуулалт хүртэлх бүх шатанд мөшгөх бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлж, түүхий эдийн эх үүсвэр, үйлдвэрлэлийн үйл явц, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын мэдээллийг баримтжуулсан байна.

7.25.Органик түүхий эд нь итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага, эсвэл бүртгэгдсэн Хамтын баталгаажуулалтын байгууллагаар гэрчилгээжсэн байх бөгөөд дараах баримт бичгээр гарал үүслийг нотолно:

7.25.1.Органик мал аж ахуйн гэрчилгээ (амьд мал);

7.25.2.Тэжээлийн бүртгэл, гарал үүсэл,

7.25.3.Малын эрүүл мэндийн түүх, эмчилгээ, вакцинжуулалтын мэдээлэл;

7.25.4.Нядалгааны үеийн эрүүл ахуйн хяналтын бүртгэл;

7.25.5.Арьс, ноос, ноолуурыг тусгаарлан боловсруулсан тухай тэмдэглэл;

7.25.6.Түүхий эд бүрийн дугаарлалт, шошго, хяналтын код.

7.25.7.Малын гарал үүслийн болон эрүүл мэндийн мэдээлэл нь Мал эмнэлгийн нэгдсэн системийн цахим бүртгэлд бүртгэгдсэн байна.

7.26.Ноос, ноолуур, арьс, ширний анхан шатны боловсруулалтын үед дараах баримт бичгийг бүрдүүлж, хадгална:

7.26.1.Ашигласан химийн бодис, нэмэлт материалын жагсаалт;

7.26.2.Түүхий эдийн шинжилгээний дүн, чанарын үзүүлэлт;

7.26.3.Хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, хяналтын бүртгэл;

7.26.4.Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, тосолгоо, ариутгалын бүртгэл;

7.26.5.Аюулгүй ажиллагааны болон эрүүл мэндийн зааварчилгаа, бүртгэл;

7.26.6.Мөшгөлт болон дотоод хяналтын системийн баримт бичгийн жагсаалт, хяналтын тайлан;

7.26.7.Дотоод аудитын тайланг 3-аас доошгүй жил хадгалсан байх.

7.27.Гарал үүсэл тодорхойгүй, баримт дутуу, эсвэл мөшгөлтийн бүртгэл хангалтгүй түүхий эдийг органик үйлдвэрлэлд ашиглахыг хориглоно.

7.28.Мал аж ахуйн гаралтай түүхий эд нийлүүлэгч нь энэхүү журмын “Мал аж ахуйн органик үйлдвэрлэл”-ийн шаардлагыг бүрэн хангаж, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 9.1-д заасан баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан, гэрчилгээтэй байна.

7.29.Нийлүүлэгч нь мал төхөөрөх, нядлах үйл явц нь олон улсын “Animal Welfare” (мал амьтны тавлаг байдал) шалгуурыг хангасан байна.

7.30.Нийлүүлэгч нь мал, амьтны арьс тайрах (mulesing) аргыг ашиглаагүйг бичгээр нотолно.

7.31.Нийлүүлэгч нь органик хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд (ноос, ноолуур, арьс шир) нийлүүлэх чадамжтай, тогтвортой нийлүүлэлтийн систем бүрдүүлсэн байна.

7.32.Түүхий эдийн гарал үүсэл, үйлдвэрлэлийн шат бүрийг нотлох баримт, бүртгэлээр баталгаажуулж, гарал үүсэл ба мөшгөлтийн системтэй байна.

7.33.Нийлүүлэгч нь хүрээлэн буй орчныг хамгаалах, мал амьтны тавлаг байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал ба хүний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтална.

7.34.Малыг тэжээхдээ химийн нийлэг тэжээл, антибиотик, дааврын бэлдмэл ашиглахыг хориглоно.

7.35.Малын эрүүл мэндийг дэмжихдээ байгалийн гаралтай, ургамлын ханд эсвэл биологийн аргыг ашиглана.

7.36.Арьс, шир нь зөвхөн хүнсний үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн байх бөгөөд зориулалтын бус агуулах эсвэл хяналтгүй бэлтгэлийг хориглоно.

7.37.Арьс хадгалах үйл явцад химийн бодис ашиглавал Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4-ны дагуу зөвшөөрөгдсөн бодисын жагсаалтад нийцсэн байна.

7.37.1.Органик түүхий эдийн гарал үүсэл, нотолгооны баримтууд (гэрчилгээ, шинжилгээний дүгнэлт, агуулахын бүртгэл гэх мэт) бүрэн хадгалагдаж, баталгаажуулалтын үндэслэл болно.

7.38.Мал, амьтны гарал үүсэл нь цахим бүртгэлийн системд бүртгэгдсэн байх бөгөөд тэжээл, эрүүл мэнд, вакцинжуулалтын мэдээлэл баталгаажсан байна.

7.39.Органик түүхий эд нь баталгаажуулалтын байгууллагаар гэрчилгээжсэн, [www.organic.gov.mn](http://www.organic.gov.mn) мэдээллийн санд бүртгэлтэй, хүчинтэй хугацаатай байна.

7.40.Органик түүхий эдийн гарал үүсэл, тээвэрлэлтийн хяналт, агуулахын бүртгэл зэрэг нотлох баримтыг 3-аас доошгүй жил хадгална.

7.41.Үйлдвэрлэлийн явц ба технологийн шаардлага нь органик ноос, ноолууран (текстил) бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь “Текстилийн

тогтвортой үйлдвэрлэл-Удирдамж” MNS 6926:2021 тогтолцооны стандарт, хамгаалагдсан Газар зүйн заалтын шаардлагууд, энэхүү журмын 7.28, 7.29-д заасан суурь шаардлагыг хангасан байх бөгөөд үйлдвэрлэлийн явцад эрсдлийн менежментийн зарчмыг хэрэгжүүлж, эрсдэлийг тодорхойлж, хяналтад авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

7.42. Анхан шатны боловсруулалт нь

7.42.1. Баталгаажсан органик гаралтай ноос, ноолуурыг холилдолгүйгээр тусгаарлан хүлээн авч, гарал үүслийн баримт болон баталгаажуулалтын гэрчилгээний мэдээллээр баталгаажуулна.

7.42.2. Бохирдлыг гараар эсвэл механик аргаар цэвэрлэнэ;

7.42.3. Химийн бодис хэрэглэхийг хориглоно.

7.42.4. Боловсруулалтын явцад ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, эрүүл ахуйн шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангана.

7.43. Угаахад хэрэглэгдэх бүх угаагч бодис нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4 дүгээр хэсэгт заасан “органик үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалт”-д багтсан, байгальд хоргүй бодис байна.

7.43.1. Хаягдал усны pH, температур, химийн үзүүлэлт нь хүрээлэн буй орчны стандартад нийцсэн байна.

7.43.2. Угаалтын усыг цэвэрлэх байгууламжаар дамжуулж зайлуулан, хяналтын бүртгэл хөтөлнө.

7.43.3. Эрчим хүчний хэмнэлтийн зарчмыг баримталж, бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахгүй нөхцөлд хатаана.

7.44. Хялгас ялгах ба самнахад түүхий эдийг зөвхөн механик аргаар ялгаж, химийн боловсруулалт хийхийг хориглоно.

7.44.1. Соронзон ялгах төхөөрөмж ашиглах тохиолдолд бохирдол оруулахгүй, түүхий эдийн шинж чанарыг өөрчлөхгүй байна.

7.44.2. Машины болон тоног төхөөрөмжийн цэвэрлэгээг тогтмол хийж, бүртгэл хөтөлнө.

7.45. Савлах болон хадгалахад энэхүү журмын 7.43-д заасны дагуу органик бүтээгдэхүүний шаардлага хангасан сав, баглаа боодол ашиглана.

7.45.1. Түүхий эд холилдохоос сэргийлж тусдаа тавиур, өрөө, чийг ба температурын хяналтын системтэй байна.

7.45.2. Хадгалах агуулахыг хортон шавжаас хамгаалж, зөвшөөрөгдсөн ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис хэрэглэнэ.

7.46. Зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд органик болон органик бус ноос, ноолуур холилдохоос урьдчилан сэргийлэх хяналтын системтэй, бүртгэл, хаягжилт тодорхой байна.

7.46.1.Угаагч бодис нь Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7.4 дүгээр хэсэгт заасан жагсаалтад зөвшөөрөгдсөн эсхүл GOTS стандартад нийцсэн байна.

7.46.2.Хог хаягдал, металл хольц орохоос сэргийлэх арга хэмжээ авна.

7.46.3.Ажилчид болон хяналтын ажилтнуудад тогтмол сургалт, зааварчилгаа өгч, баримтжуулна.

7.46.4.Органик бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй, баталгаажаагүй түүхий эд хүлээн авахыг хориглоно.

7.47.Гүн боловсруулалтын үе шатанд зөвхөн баталгаажсан, хоргүй, байгальд ээлтэй нэмэлт бодис, өнгөлөгч, тосолгооны материал хэрэглэнэ.

7.47.1.Байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, хориглосон бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

7.47.2.Дулааны боловсруулалт, индүүдэх, өнгөлөх зэрэг ажиллагаа нь бүтээгдэхүүний чанарыг хадгалж, органик шинжийг алдагдуулахгүй нөхцөлд хийгдэнэ.

7.47.3.Тоног төхөөрөмжийн ажиллагааг хянах бүртгэл, чанарын үнэлгээний баримт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг хадгална.

7.47.4.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байдлыг баталгаажуулна.

7.48.Будаг болон дагалдах бодис нь олон улсын стандартын зөвшөөрөгдсөн жагсаалтад багтсан, хлорт нэгдэл болон хүнд металл агуулаагүй байх. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дахь хэсэгт заасны дагуу баталсан жагсаалтад зөвшөөрөгдсөн бодис хэрэглэх;

7.48.1.Усны хэм, хугацаа, рН зэрэг үзүүлэлтийг тогтмол хянах;

7.48.2.Хаягдал усны менежментийг хэрэгжүүлж, бохирдуулагчийн агууламжийг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас хэтрүүлэхгүй байх. Энэхүү журмын 7.47.4-д заасны дагуу төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжүүлэх;

7.48.3.Ус цэвэршүүлэх, дахин ашиглах горимыг нэвтрүүлж, бохир ус зайлуулах системтэй байх;

7.48.4.Хаягдал усны шинжилгээг хийлгэх, зөвшөөрөгдсөн гормыг мөрдүүлэх;

7.48.5.Ажилчдад хамгаалах хэрэгсэл, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх, бүртгэл хөтлөх;

7.48.6.Хэрэглэсэн будаг болон химийн бодисын аюулгүй байдлын мэдээллийн хуудас болон бүртгэлийг хадгалж, аудитын үед нотлох баримтаар ашиглана.

7.49.Органик утсаар нэхэх, сүлжих үйл ажиллагааг зөвхөн цэвэр, бохирдлоос ангид тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

7.49.1.Тоног төхөөрөмжийг ашиглахын өмнө органик бус түүхий эдтэй холилдохоос сэргийлж цэвэрлэгээ хийж, бүртгэл хөтөлнө.

7.49.2.Ажилчдад аюулгүй ажиллагаа, чанарын хяналтын зааварчилгаа өгч, баримтжуулна.

7.49.3.Нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн тус бүрийн гарал үүслийн мэдээлэл, материалын бүртгэл, үйлдвэрлэлийн кодыг хадгална.

7.50.Гүн боловсруулалтын явцад зөвхөн батлагдсан зөвшөөрөгдсөн бодисын жагсаалтад багтсан химийн бодис, нэмэлт материал ашиглана.

7.50.1.Байгаль орчин болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, хориглосон бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

7.50.2.Дулааны боловсруулалт, индүүдэх, өнгөлөх зэрэг ажиллагаа нь бүтээгдэхүүний чанарыг хадгалж, органик шинжийг алдагдуулахгүй нөхцөлд хийгдэнэ.

7.51.Эцсийн бүтээгдэхүүн нь химийн хорт бодисын үлдэгдэлгүй, эрүүл ахуйн аюулгүй байдлын шалгуурыг хангасан байна.

7.51.1.Өнгө, будгийн тогтворжилт нь угаалт, нар, хөлс, үрэлтэнд тэсвэртэй байна.

7.51.2.Хүний биед тав тухтай, агаар нэвтрэх чадвартай, харшил үүсгэгч агуулаагүй байна.

7.51.3.Дагалдах материал (товч, цахилгаан, утас, наалт гэх мэт) нь хүнд металл, никель агуулаагүй, био-задралтай эсвэл дахин боловсруулах боломжтой байна.

7.51.4.Сав, баглаа боодол нь байгальд ээлтэй, дахин боловсруулах боломжтой материалаар хийгдсэн байна.

7.51.5.Гурван нас хүртэлх хүүхдийн хувцас болон арьстай хүрэлцэх бүтээгдэхүүнд будаг хэрэглэхгүй эсвэл харшил үүсгэгчгүй, аюулгүй байдлын нотолгоотой байна.

7.52.Арьс, шир боловсруулах үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хоргүй, аюулгүй аргаар хийгдсэн байна.

7.52.1.Хромын давхар исэл (Chromium VI), хүнд металл, формальдегид, хлор, перфтор нэгдэл (PFAS) зэрэг химийн бодисыг ашиглахыг хатуу хориглоно.

7.52.2.Үйлдвэрлэлд ашиглагдах бүх химийн бодис, туслах материал нь “Органик үйлдвэрлэлд хориглосон болон зөвшөөрөгдсөн бодисын жагсаалт”-ын шаардлагад нийцсэн байна.

7.53.Зөвшөөрөгдөх технологи нь уусгагчгүй буюу усан суурьтай технологи ашиглана.

7.53.1.Байгалийн гаралтай ургамлын идээлэгч, фермент, ургамлын ханд ашиглан идээлэх, үнэргүйжүүлэх, зөөлрүүлэхийг зөвшөөрнө.

7.53.2.Үйлдвэрлэл нь ариун цэвэр, агааржуулалт, усны хэрэглээ болон хаягдал усны менежментийн зохистой тогтолцоотой байна.

7.54.Урьдчилсан боловсруулалтаар арьс, ширийг механик арга болон байгалийн ферментээр цэвэрлэнэ.

7.54.1.Хлор, хлорын нэгдэл, хүчтэй суурь (NaOH), химийн цайруулагч бодис хэрэглэхийг хориглоно.

7.54.2.Усны хэрэглээ, хаягдал усны цэвэрлэгээ, дахин ашиглалт нь байгаль орчны стандартад нийцсэн байна.

7.55.Идээлэлтэд арьсны бүтцийн уургийг тогтворжуулж ялзрахаас сэргийлэх зорилгоор ургамлын гаралтай эсвэл ферментэн идээлэгч ашиглана.

7.55.1.Хром, глутарилдегид, формальдегид зэрэг химийн идээлэгчийг хатуу хориглоно.

7.55.2.Идээлэлтийн явцын pH, температур, хугацааг хяналттай бүртгэж, баримтжуулна.

7.56.Тослох, зөөлрүүлэхэд байгалийн гаралтай оливын тос, загасны тос, наранцэцгийн тос зэрэг тосолгооны бодис ашиглана.

7.56.1.Синтетик, нефтийн гаралтай, химийн аргаар нийлэгжүүлсэн тос, APEO болон NPEO, силикон агуулсан бодис хэрэглэхийг хориглоно.

7.56.2.Ашигласан тосолгооны материал бүрийн гарал үүсэл, техникийн тодорхойлолт, шинжилгээний гэрчилгээг бүрдүүлж, хадгална.

7.57.Будах ба өнгөлөхөд байгаль орчинд сөрөг нөлөөтэй, хүн болон амьтанд хор учруулж болох бодис ашиглахыг хориглоно.

7.58.Арьсны будаг, зөөлрүүлэгч, өнгөлгөөнд байгалийн гаралтай, биед хоргүй, экологийн баталгаатай бодис хэрэглэнэ.

7.58.1.Боловсруулалтын дараах бүтээгдэхүүн дэх үлдэгдэл химийн бодисын хэмжээ дараах хүлээн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байна:

Формальдегид  $\leq 16$  mg/kg

Хлорфенол  $\leq 0.05$  mg/kg

Азо будаг (амин ялгаруулдаг)  $\leq 20$  mg/kg

APEO  $\leq 100$  mg/kg

7.58.2.Усны pH, температур, хаягдал усны менежмент, дахин ашиглалт, цэвэрлэгээний бүртгэл хөтөлнө.

7.59.Хатаах ба тогтворжуулах

7.59.1.Арьсны чийгийг гадагшлуулж, бүтцийн тогтвортой байдлыг хангахын тулд уурын эсвэл механик аргаар хатаана.

7.59.2.Нүүрстөрөгч-ус төрөгчийн үндсэнд хлор агуулсан полимер (PVC), полиуретан (PU) зэрэг синтетик бүрхүүл хэрэглэхийг хориглоно.

7.59.3.Хатаалтын тоног төхөөрөмж нь ISO 14001 стандартын эрчим хүч ба байгаль орчны менежментийн шаардлагад нийцсэн байх;

7.59.4.Хатаалтын температур, хугацаа, агаарын чийгшлийг тогтмол хянаж, бүртгэл хөтөлнө.

7.60.Эцсийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

7.60.1.Арьс, ширэн бүтээгдэхүүн нь химийн бодисын үлдэгдэлгүй, эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шалгуурыг хангасан байна.

7.60.2.Өнгө, бүтэц, уян чанар нь хэрэглээний явцад тогтвортой байх, биед харшил үүсгэхгүй байх.

7.60.3.Гоёл чимэглэл, металл эд анги нь никель болон хүнд металл агуулаагүй байна.

7.60.4.Сав, баглаа боодол нь дахин боловсруулах боломжтой, байгальд ээлтэй материалаар хийгдсэн байна.

7.61.Нийгмийн хариуцлага, хүний эрх, байгаль орчны шаардлага

7.61.1.Үйлдвэрлэл эрхлэгч нь хүний эрхийг хүндэтгэж, ажилчдын хөдөлмөрийн үндсэн эрх, эрүүл, аюулгүй ажлын орчин, шударга хөлс, ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.61.2.Нийгмийн хариуцлагын зарчмуудыг хэрэгжүүлэхдээ олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-ын конвенц, SA8000 стандарт, ISO 26000 нийгмийн хариуцлагын заавар, Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагыг хангасан байна.

7.62.Байгаль орчны менежмент ба тогтвортой хөгжил

7.62.1.Үйлдвэрлэл эрхлэгч нь ISO 14001 стандартын шаардлагад нийцсэн байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлсэн байна.

7.62.2.Хаягдал ус, агаар, дуу чимээ, хатуу болон шингэн хог хаягдлын нөлөөллийг тогтмол хянаж, бууруулах арга хэмжээг авна.

7.62.3.Үйлдвэрлэлийн эрчим хүч, ус болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хянах, хэмнэлттэй, тогтвортой байлгах хяналтын тогтолцоотой байна. Үүнд эрчим хүчний хэрэглээний бүртгэл, үнэлгээ, сайжруулалтын төлөвлөгөөг багтаана.

7.62.4.Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх технологи, материал хэрэглэхийг хориглоно.

7.62.5.Хаягдлыг ангилан цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, бохир усны цэвэрлэгээ, хаягдал хянах тогтолцоог хэрэгжүүлнэ.

7.63.Ноос, ноолуурын сав баглаа боодол, шошгололтын шаардлага

7.63.1.Сав баглаа боодол нь бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, органик гарал үүслийг хадгалах нөхцөлийг бүрэн хангахуйц байна.

7.63.2.Сав баглаа боодол нь дахин боловсруулах боломжтой, байгальд ээлтэй, био-задралтай материал (цаас, даавуун уут, байгалийн эслэг суурьтай уут гэх мэт)-аар хийгдсэн байх.

7.63.3.Пластик болон полиэтилен суурьтай сав баглаа боодлыг ашиглах тохиолдолд дахин боловсруулах боломжийг нотолсон баримт бичигтэй байна.

7.63.4.Сав баглаа боодол, шошгололт нь дараах мэдээллийг агуулна:

7.63.4.а.Бүтээгдэхүүний нэр;

7.63.4.б.Баталгаажуулалтын байгууллагын нэр, бүртгэлийн дугаар;

7.63.4.в.Органик гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа;

7.63.4.г.Түүхий эдийн гарал үүсэл (органик гаралтай ноос, ноолуур);

7.63.4.д.Жин, ширхэг, үйлдвэрлэсэн огноо;

7.63.4.е.“Монгол Органик бүтээгдэхүүн” эсвэл “Шилжилтийн үеийн Монгол органик бүтээгдэхүүн” гэсэн тэмдэглэгээ.

7.63.5.Хэрэглэж буй шошго, тэмдэг, логог зөвхөн баталгаажсан органик бүтээгдэхүүнд хэрэглэнэ.

7.63.6.Органик тэмдэглэгээг дараах нөхцөлд хэрэглэнэ:

7.63.6.а.“Органик бүтээгдэхүүн” – нийт орцын 95 ба түүнээс дээш хувь нь органик гаралтай;

7.63.6.б.“Шилжилтийн үеийн бүтээгдэхүүн”- баталгаажуулалтын 12–36 сарын шилжилтийн хугацаанд үйлдвэрлэсэн;

7.63.6.в.Органик тэмдэг, логог зөвшөөрөлгүйгээр бусад бүтээгдэхүүнд хэрэглэхийг хатуу хориглоно.

7.63.7.Сав баглаа боодол, шошгололт нь хуурамч мэдээлэл өгөх, хэрэглэгчийг төөрөгдүүлэх үг, дүрс, өнгө, хэллэг ашиглахгүй байна.

7.63.8.Шошгололтод стандартад нийцсэн тэмдэглэгээ хэрэглэнэ.

7.64.Арьс, ширэн бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошгололт ба хадгалалтын шаардлага.

7.64.1.Органик арьс, ширний сав баглаа боодол нь бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, байгаль орчны хамгаалалтыг бүрэн хангахуйц байна.

7.64.2.Сав баглаа боодол нь арьс, ширнийг механик гэмтэл, бохирдол, чийг, хөгц, бактери, үнэр, хортон шавж зэрэг сөрөг

нөлөөллөөс хамгаална.

7.64.3.Сав баглаа боодлын материал нь дахин боловсруулах боломжтой, байгальд хоргүй, био-задралтай материал (цаас, хөвөн даавуу, модон хайрцаг, байгалийн эслэг уут гэх мэт)-аар хийгдсэн байна.

7.64.4.Тээвэрлэлтийн явцад арьс, ширийг хамгаалах зорилгоор модон тавиур, даавуун уут, цаасан хайрцаг, туузан боодол зэрэг амьсгалдаг, механик хамгаалалт сайтай материал ашиглана.

7.64.5.Арьсны бүтцийг хамгаалж, чийг нэвтрүүлэхгүй нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хөвөн, цаас, био суурьт уут хэрэглэнэ.

7.64.6.Полиэтилен болон хуванцар зэрэг химийн гаралтай савлагааг хязгаарлаж, зөвхөн түр хугацааны хамгаалалт буюу тээвэрлэлтийн зайлшгүй тохиолдолд хэрэглэнэ. Энэ тохиолдолд дараах бүртгэлийг хөтөлнө:

7.64.6.а.Ашигласан материалын нэр, тоо хэмжээ;

7.64.6.б.Ашигласан хугацаа, шалтгаан;

7.64.6.в.Хариуцсан ажилтны гарын үсэг, баталгаажуулалт.

7.64.7.Сав баглаа боодол нь арьсны өнгө, бүтэц, үнэр, физик шинж чанарт сөрөг нөлөөгүй байна.

7.64.8.Сав баглаа боодлын дахин ашиглах, дахин боловсруулах бодлого нь байгууллагын дотоод журам болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

#### 7.65.Хадгалалтын шаардлага

7.65.1.Ноос, ноолуурын түүхий эдийн хадгалалтын шаардлага

7.65.1.а.хадгалах орчин нь бүтээгдэхүүний физик, химийн шинж чанарыг алдагдуулахгүй, хуурай, цэвэр, агааржуулалт сайтай байна.

7.65.1.б.чийг, дулааны хяналт тогтмол хийгдэж, хадгалалтын орчны температур 10–25°C, харьцангуй чийгшил 45–60% байна.

7.65.1.в.органик болон органик бус ноос, ноолуур бүтээгдэхүүнийг тус тусад нь, тод тэмдэглэгээ бүхий хэсэгт тусгаарлан хадгална.

7.65.1.г.хадгалах бүсэд “Органик” гэж тодорхой хаяг, тэмдэглэгээ, дугаарлалт байршуулна.

7.65.1.д.шавж, хортон амьтнаас хамгаалах химийн бодис хэрэглэхийг хориглоно, харин байгалийн гаралтай (жишээ нь лаванда, гааны тос, хатаасан ургамал) бодис хэрэглэж болно.

7.65.2.Хадгалалтын явцад тогтмол үзлэг, бүртгэл, цэвэрлэгээ хийнэ.

7.65.2.а.хадгалсан огноо, байршил, хяналтын ажилтны нэр;

7.65.2.б.бүтээгдэхүүний нэр төрөл, багцын дугаар, жин;

7.65.2.в.үзлэг, цэвэрлэгээний давтамжийг бүртгэх.

7.65.2.г.хадгалалт, тээвэрлэлтийн үед бохирдол, ялгаралт, холилдол үүсгэхгүй байх нөхцөлийг хангах.

7.65.2.д.сав баглаа боодол, хадгалалтын нөхцөл нь байгууллагын чанарын болон байгаль орчны менежментийн журамтай уялдсан байна.

7.65.3.Арьс, ширэн түүхий эдийн хадгалалтын шаардлага

7.65.3.а.хадгалах орчин нь арьс, ширний физик болон химийн шинж чанарыг алдагдуулахгүй нөхцөлийг хангана.

7.65.3.б.хадгалах байр нь цэвэр, хуурай, агааржуулалт сайтай, шавж, мэрэгч амьтнаас ангид байна.

7.65.3.в.арьс, ширийг бусад химийн бодис, үнэртэй бүтээгдэхүүн, химийн аргаар боловсруулсан материалаас тусгаарлан хадгална.

7.65.3.г.хадгалалтын орчны температур 5–25°C, харьцангуй чийгшил 50–65%, байхаар тохируулж, чийг, температурын хяналт, бүртгэл хөтөлнө.

7.65.3.д.баталгаажуулалтын дараа арьсыг 12 сараас илүү хугацаагаар хадгалахгүй, үйлдвэрлэлд эргэлтэд оруулах хугацааг төлөвлөнө.

7.65.4.Хадгалалтын явцад тогтмол үзлэг, бүртгэл, цэвэрлэгээ, нөхөн хамгаалалт хийнэ. Дараах мэдээллийг тэмдэглэнэ:

7.65.4.а.анхны шалгалтын огноо;

7.65.4.б.сав баглаа боодлын дугаар;

7.65.4.в.хадгалалтын нөхцөл, хугацаа.

7.65.5.Хадгалах байранд физик урьдчилан сэргийлэх арга (жишээ нь, хашлага, торон хаалт, наалддаг урхи) хэрэглэж, мэрэгч амьтан, шавжаас хамгаална.

7.65.6.Химийн хортон устгал, үнэрт хор, утаа зэрэг бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

7.65.6.а.байгалийн гаралтай (лаванда, гааны эфирийн тос гэх мэт) ургамлын гаралтай үргээлэг бодис ашиглаж болно.

7.65.6.б.органик гэрчилгээтэй арьсыг органик бус түүхий эдтэй холилдохоос сэргийлж тусгаарлан хадгална.

7.65.6.в.хадгалалтын бүсэд “Органик” гэж тодорхой тэмдэглэл бүхий тусдаа хаяг, байршлын тэмдэглэгээ байршуулна.

7.65.7.Бэлэн бүтээгдэхүүний хадгалалтын шаардлага

7.65.7.а.бэлэн бүтээгдэхүүнийг чанар, өнгө, бүтэц, үнэр, органик шинжийг хадгалах цэвэр, хуурай, агааржуулалт сайтай орчинд хадгална.

7.65.7.б.хадгалалтын орчны температур 10–25 °С, харьцангуй чийгшил 45–60 % байна.

7.65.7.в.органик болон органик бус бэлэн бүтээгдэхүүнийг тусгаарлан хадгална, “Органик” гэж тодорхой тэмдэглэгээ бүхий хаяг байршуулна.

7.65.7.г.бэлэн бүтээгдэхүүн нь бохирдол, үнэр, химийн ууршил, нарны шууд тусгалаас хамгаалагдсан байх.

7.65.7.д.хадгалалтын байранд шавж, мэрэгч амьтны хамгаалалтын физик арга (тор, хаалт, урхи гэх мэт) хэрэглэнэ.

7.65.8.Химийн шавж устгал, үнэр дарагч, утаа хэрэглэхийг хориглоно.

7.65.9.Байгалийн гаралтай (лаванда, гааны тос гэх мэт) бодис ашиглаж болно.

7.65.10.Хадгалалтын явцад тогтмол үзлэг, бүртгэл, цэвэрлэгээ, нөхөн хамгаалалт хийнэ. Бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

7.65.10.а.бүтээгдэхүүний нэр, дугаар, хадгалсан огноо, байршил;

7.65.10.б.үзлэгийн огноо, хариуцсан ажилтны нэр;

7.65.10.в.хадгалалтын орчны температур, чийгийн утга.

7.65.10.г.бэлэн бүтээгдэхүүнийг чанар, өнгө, бүтэц, үнэр, органик шинж чанарыг алдагдуулахгүйгээр, эргэлтэд оруулах хүртэл хадгална.

7.65.10.д.ноос, ноолуурын бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа нь 12 сараас хэтрэхгүй байхыг зөвлөнө.

7.65.10.е.арьс, ширэн бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа нь 18 сараас хэтрэхгүй байхыг зөвлөнө.

7.65.11.Хадгалалтын бүс, тавиур, хайрцаг бүрийг кодчилсон тэмдэглэгээтэй байна.

7.65.12.Бэлэн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, экспортлох үед баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээний дугаар, үйлдвэрлэлийн огноо, гарал үүсэл тодорхой тэмдэглэгдсэн байна.

7.66.Хязгаарлалт ба хориглох үйл ажиллагаа

7.66.1.Ноос, ноолуурын үйлдвэрлэлд хамаарах хязгаарлалт ба хориглох үйл ажиллагаа

7.66.2.Органик бус түүхий эдийг органик түүхий эдтэй холих, хамт боловсруулах, хадгалах, тээвэрлэхийг хориглоно.

7.66.3.Химийн гаралтай угаагч, цайруулагч, зөөлрүүлэгч, антисептик болон өнгө хадгалагч бодис хэрэглэхийг хориглоно.

7.66.4.Угаах, будах, боловсруулалтын явцад (GOTS, IVN BEST, IFOAM Norms-т) хориглосон бодисын жагсаалтад багтсан аливаа химийн бодис, уусгагчийг ашиглахыг хориглоно.

7.66.5.Хлорын цайруулагч, формальдегид, фталат, хүнд металл (Pb, Cd, Cr, Hg), азо будаг, PVC, оптик цайруулагч зэрэг бодис хэрэглэхийг хориглоно.

7.66.6.Будаг, өнгөлгөө, тосолгоонд байгалийн бус, нефтийн гаралтай бүтээгдэхүүн ашиглахыг хориглоно.

7.66.7.Ноос, ноолуурын гарал үүсэл нь баталгаагүй, гарал үүслийн бүртгэлгүй аж ахуйн нэгж, өрхөөс авахыг хориглоно.

7.66.8.Хортон шавж устгалд органик бус бодис, утаа, хий ашиглахыг хориглоно; зөвхөн байгалийн гаралтай ургамлын тос, үнэртэн, биологийн аргыг хэрэглэнэ.

7.66.9.Органик түүхий эдийг үйлдвэрлэлийн бус зориулалтаар ашиглахыг хориглоно.

7.66.10.Байгаль орчин, ус, хөрсний бохирдол үүсгэх, хаягдал бодисыг цэвэршүүлэлгүй гадагшлуулах аливаа үйл ажиллагааг хатуу хориглоно.

7.67.Арьс ширний үйлдвэрлэлд хамаарах хязгаарлалт ба хориглох үйл ажиллагаа

7.67.1.Органик бус гаралтай арьс, ширийг органик арьс, ширтэй хамт боловсруулж, хадгалах, тээвэрлэхийг хориглоно.

7.67.2.Хром (VI), глутарилдегид, формальдегид, APEO, NPEO, фенол, аммиак, нитрофенол, фталат, перфтор химийн бодис (PFAS) зэрэг химийн бодисыг ашиглахыг хатуу хориглоно.

7.67.3.Арьс, шир идээлэх, будах, өнгөлөх явцад байгаль орчинд аюултай, задардаггүй, хуримтлагддаг химийн бодис хэрэглэхийг хориглоно.

7.67.4.Байгальд хортой уусгагч, нефтийн гаралтай тос, силикон, синтетик бүрхүүл ашиглахыг хориглоно.

7.67.5.Хлор, хлорын нэгдэл болон хүчил, шүлтэнд суурилсан цайруулагч, цэвэрлэгч бодис хэрэглэхийг хориглоно.

7.67.6.Мэрэгч амьтан, шавж устгалд химийн хорт бодис ашиглахыг хориглоно; зөвхөн байгалийн гаралтай ургамлын тос, үнэрт ургамлын ханд хэрэглэнэ.

7.67.7.PVC, PU, синтетик бүрхүүл, нийлэг наалдуулагч хэрэглэхийг хориглоно.

7.67.8.Органик арьс, ширийг химийн аргаар хадгалах, хамгаалах тохиолдолд зөвхөн батлагдсан зөвшөөрөгдсөн бодис хэрэглэнэ.

7.67.9.Арьсны гарал үүслийн бүртгэлгүй, гарал үүсэл нь баталгаагүй түүхий эд ашиглахыг хориглоно.

7.67.10.Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, хаягдал ус, бохирдлыг цэвэршүүлэлгүй гадагшлуулах, хог хаягдлыг зохисгүй устгах аливаа үйл ажиллагааг хориглоно.

## **Найм.Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх**

8.1.Органик олон байгалийн гаралтай бүтээгдэхүүнд ашиглах бүх түүхий эд, орц найрлага нь хөдөө аж ахуй, байгалийн ургамал, амьтны гаралтай байх бөгөөд генетикийн өөрчлөлтгүй, бохирдлоос ангид, тогтвортой эх үүсвэрээс хангагдсан байна.

8.2.Боловсруулалтын бүх үе шат нь Байгалийн ба органик гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний стандарт (COSMOS), болон IFOAM стандартын шаардлагад нийцсэн зөвшөөрөгдсөн физик эсвэл хязгаарлагдмал химийн аргаар ашиглах ба хориглосон технологи ионжуулагч цацраг, нанотехнологи, генийн инженерчлэлийн арга ашиглахыг хориглоно.

8.3.Үйлдвэрлэлийн орчин нь бохирдлоос сэргийлэх, цэвэрлэгээ, тусгаарлалт, хяналт-шинжилгээний бүртгэлтэй тогтолцоо бүхий нөхцөлд хийгдэнэ.

8.4.Үйлдвэрлэлийн орчин нь бохирдлоос сэргийлэх, цэвэрлэгээ, тусгаарлалт, хяналт шинжилгээний бүртгэлтэй, бүтээгдэхүүн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, аюулгүй байдал хангаж, “Гоо сайхны бүтээгдэхүүн-үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын арга зүйн заавар MNS ISO 22716 стандартыг хэрэгжүүлсэн байна.

8.5.Ашиглаж буй ус, тоног төхөөрөмж, сав баглаа боодол нь химийн аюулгүй, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах боломжтой, байгальд ээлтэй материал байна.

8.6.Бүтээгдэхүүний орц, найрлага, үйлдвэрлэлийн бүртгэл, гарал үүслийн мэдээлэл нь бүрэн мөшгөх боломжтой, баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан байна.

8.7.Бүтээгдэхүүн нь органик эсвэл байгалийн гэж шошгологдохын тулд тухайн ангиллын доод органик орцын хувь, баталгаажуулалтын нотолгоо, гэрчилгээ олгосон байгууллагын тэмдэглэгээг бүрэн хангасан байна.

8.8.Нийлүүлэгч нь Органик болон байгалийн гаралтай гоо сайхан, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглагдах бүх түүхий эд, орц, сав баглаа боодол, туслах материал нь баталгаажсан эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс нийлүүлэгдсэн байна.

8.9.Нийлүүлэгч нь тухайн түүхий эд, орцын гарал үүсэл, чанар, аюулгүй байдлыг нотлох баримт бичгээр баталгаажуулсан байна.

8.9.1.баталгаажуулалтын гэрчилгээ;

8.9.2.гарал үүслийн тодорхойлолт;

8.9.3.бүтээгдэхүүний шинжилгээний дүн;

8.9.4.дагалдах бичиг баримт багтана.

8.10.Импортын гаралтай түүхий эд, орц, материалын хувьд тухайн улсын хүчин төгөлдөр органик, эсвэл байгалийн гаралтай бүтээгдэхүүний стандартын дагуу баталгаажсан байх бөгөөд олон улсын ижил түвшний стандарт буюу COSMOS, ISO 16128, ECOCERT, NATRUE зэрэг баталгаажуулалтын тогтолцоонд хамаарах гэрчилгээтэй байна.

8.11.Нийлүүлэгч нь дараах үндсэн шаардлагыг хангасан байх ёстой:

8.11.1.Түүхий эд нь хувиргасан генийн өөрчлөлтгүй, цацраг идэвхт боловсруулалт хийгдээгүй байх;

8.11.2.Амьтанд туршилт хийгдээгүй, амьд амьтнаас гаралтай хориотой орц агуулаагүй байх;

8.11.3.Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зохистой дадал (GMP, GHP)-ыг хэрэгжүүлж, баталгаатай үйлдвэрлэлийн орчинд үйл ажиллагаа явуулж байх;

8.11.4.Байгаль орчинд сөрөг нөлөө багатай түүхий эд ашиглах, бохирдлын эрсдэлийг бууруулах хяналтын хөтөлбөр хэрэгжүүлсэн байх;

8.11.5.Гарал үүслийн ил тод байдал, хангамжийн сүлжээний хяналтыг хангаж байх.

8.12.Бэлтгэн нийлүүлэгч болон импортлогч нь баталгаажуулалтын байгууллагын хяналт, магадлал, аудитад хамрагдах үүрэгтэй бөгөөд шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.

8.13.Шинэ нийлүүлэгчийг бүртгэх, үнэлэхдээ дараах зарчмыг баримтална:

8.13.1.Анхан үнэлгээг гүйцэтгэж, гарал үүсэл, баталгаажуулалт, чанарын хяналтын тогтолцоог шалгаж, баримтжуулан хадгална;

8.13.2.Үнэлгээний үр дүнгээр нийлүүлэгчийн эрсдэлийн түвшнийг тогтоож, өндөр эрсдэлтэй нийлүүлэгчдэд нэмэлт аудит хийх;

8.13.3.Баталгаатай нийлүүлэгчтэй гэрээ байгуулж, нийлүүлэлтийн хяналтын бүртгэл хөтлөх.

8.14.Нийлүүлэгч, импортлогчийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, эсвэл хангамжийн горимд өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн мэдээллийг 30 хоногийн дотор баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэнэ.

8.15.Нийлүүлэгч, импортлогчийн баталгаажуулалт хүчингүй болсон, эсвэл шаардлага хангахгүй нь тогтоогдсон тохиолдолд тухайн түүхий эд, материал, бүтээгдэхүүнд “органик” нэр томьёо хэрэглэхийг хориглоно.

8.16.Органик болон байгалийн түүхий эд бүтээгдэхүүнд байгальд ээлтэй аргаар олдворлосон, сэргээгдэх эх үүсвэрээс гарган авсан, баталгаажсан органик гаралтай түүхий эдийг хэрэглэнэ.

8.16.1.Органик гаралтай түүхий эд нь баталгаажсан, эсхүл олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтын байгууллагаас олгосон гэрчилгээтэй орц байх, гэрчилгээний хуулбар, гарал үүслийн баталгааг бүртгэж хадгална.

8.16.2.Байгалийн гаралтай түүхий эд нь ISO 16128 стандартад заасан “Байгалийн” болон “Байгалийн гаралтай” ангилалд хамаарч, химийн нийлэг өөрчлөлтгүй, хоргүй, байгальд задардаг шаардлагыг хангана.

8.17.Хориглох бодис ба орц нь:

8.17.1.Генийн өөрчлөлттэй организм

8.17.2.Хиймэл үнэртэн, будагч бодис

8.17.3.Парабен, фталат, силикон, формальдегид, триклозан, SLS (натрийн лаурил сульфат) болон бусад нийлэг химийн бодис.

8.18.Гоосайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь гоосайхан болон ахуйн хэрэглээний ариутгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, боловсруулалтын явц нь физик, байгалийн, химийн, синтетик боловсруулалт хийгдэнэ.

8.19.Физик боловсруулалт: Органик болон байгалийн гаралтай хөдөө аж ахуйн түүхий эдийг механик, дулааны, уур, даралт, шүүх, шингэрүүлэх, усгүйжүүлэх, хөлдөөх, ууршуулах, бутлах зэрэг зөвшөөрөгдсөн физик аргаар боловсруулна.

8.20.Физик боловсруулсан ургамлын ханд: Органик болон байгалийн гаралтай хөдөө аж ахуйн орц найрлагыг зөвшөөрөгдсөн физик аргаар боловсруулж ашиглана. Усгүйжүүлсэн, хандалсан, тосон ханд зэрэг орц найрлагын органик хувь тооцохдоо тухайн анхны органик түүхий эдийн бодит агууламжийг үндэслэнэ.(Жишээ: Aloe vera powder, Calendula extract, Lavender oil)

8.21.Физик боловсруулалтын үед бүтээгдэхүүний орцын бүтцэд химийн өөрчлөлт оруулах, хэт өндөр 80°C дээш ашиглах, Химийн шингэн, уусгагч, хлоржуулсан ус, шингэнийг ашиглах, химийн нийлэгжүүлэлт, хувиргалт ашиглахыг хориглоно.

8.22.Физик боловсруулалтын үед дараах үйлдлийг хийхийг хориглоно.

8.22.1.Бүтээгдэхүүний орцын бүтцэд химийн нийлэгжүүлэлт, хувиргалт, урвал үүсгэх;

8.22.2.Хэт өндөр температур (80°C-аас дээш) ашиглах;

8.22.3.Химийн гаралтай уусгагч, синтетик шингэн, хлоржуулсан ус эсвэл химийн бодисоор баяжуулсан шингэн ашиглах;

8.22.4.Түүхий эдийн байгалийн бүтцэд өөрчлөлт оруулах химийн боловсруулалт хийх.

8.23.Физик боловсруулалтад ашиглагдах ус нь дараах шаардлагыг хангана:

8.23.1.Ус нь бүтээгдэхүүний чанарт нөлөөлөхүйц тул баталгаажуулалтын байгууллагаас хяналт шалгалтад хамрагдсан, эсвэл эрх бүхий лабораторийн шинжилгээгээр баталгаажсан байна.

8.23.2.Ус нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:

8.23.3.Ус нь хүнсний, ундны эсвэл эмийн чанарын ангилалд багтах, аюулгүй байдлын шаардлага хангасан байна.

8.23.4.Ашиглагдаж буй ус нь физик аргаар боловсруулсан байна. Үүнд ионгүйжүүлэлт, урвуу осмос, эрдэсгүйжүүлэлт, хлоргүйжүүлэлт, шүүх, буцалгах, ууршуулах, хөлдөөх зэрэг арга багтана.

8.23.5.Химийн аргаар боловсруулсан, эсхүл синтетик бодисоор сэргээгдсэн шүүлтүүр, ион солилцооны давирхай ашигласан ус хэрэглэхийг хориглоно.

8.23.6.Эрх бүхий байгууллагаар баталгаажсан түүхий эдийн бүрэлдэхүүнд ашиглагдсан усанд нэмэлт шалгалт шаардахгүй.

8.23.7.Түүхий эд боловсруулахад ашиглагдах ус нь стандартын дагуу ионгүйжүүлсэн, урвуу осмосоор боловсруулсан, эрдэсгүйжүүлсэн эсвэл хлоргүйжүүлсэн байж болно.

8.23.8.Ус болон бусад туслах орцын чанар, гарал үүслийг нотлох баримт бичиг(шинжилгээний дүн, тохирлын гэрчилгээ, техникийн тодорхойлолт)тэй байна.

8.24.Байгалийн исэлдэлт (фементчилэл): Ургамлын эсвэл малын гаралтай орцын биологийн идэвхийг нэмэгдүүлэх, рН тохируулах, чийг татах, арьсанд тэжээл өгөх үйлчилгээтэй шинэ нэгдэл үүсгэхэд зөвшөөрөгдсөн, хязгаарлагдмал биологийн боловсруулалт ба биологийн гаралтай бичил биетэн (бактери, мөөг, хөрөнгө гэх мэт)-ийн үйлчлэлээр түүхий эдийг исгэх, өөр бүтэцтэй болгох биохимийн үйл явцад фермент болон исгэгч микро организм ашиглах ба дараах нөхцөлүүдийг зөвшөөрнө.

8.24.1.Микро организмын гарал үүсэл: Органик болон хүнсний аюулгүй байдалд нийцсэн, генийн өөрчлөлтгүй бичил биетэн;

8.24.2.Тэжээллэг орчин: Сахар, цардуул, шүүс зэрэг ферментэд тэжээл болдог бодисууд нь органик гаралтай байх;

8.24.3.Фермент: Байгалийн гаралтай, генийн өөрчлөлтгүй микробоос гаргаж авсан байх;

8.24.4.Ферментчилэх үйл явц: Нээлттэй буюу хяналттай, нэмэлт синтетик бодис оруулахгүйгээр хийгдсэн байх;

8.24.5.Гарал үүсэл: Түүхий эд, бичил биетэн, процесс бүгд мөрдөн шалгах боломжтой байх;

8.24.6.Дараах нөхцөлүүдийг хориглоно. Үүнд:

8.24.6.а.Генийн өөрчлөлттэй фермент эсвэл исгэгч ашиглах;

8.24.6.б.Химийн нэмэлт бодис, хурдасгуур, өнгө үнэр оруулагч ашиглах;

8.24.6.в.Синтетик нэгдэл үүсгэх, био-инженерчлэл ашиглах;

8.25.Спиртийн боловсруулалт нь органик болон байгалийн гаралтай хөдөө аж ахуйн түүхий эдээс идэвхт бодисыг ялган авах, хадгалах, эсвэл найрлага бэлтгэлд боловсруулалтын явцад түүхий эдийн үндсэн химийн бүтцийг өөрчлөхгүй байх зарчмыг баримтална.

8.26.Боловсруулалтад ашиглагдах спирт нь органик гаралтай ургамлын түүхий эдээс (жишээлбэл чихрийн нишингэ, эрдэнэшиш, жимс, усан үзэм, үр тариа гэх мэт) гарган авсан байна.

8.27.Хэрэв спирт нь органик гаралтай бол түүний органик хувийг  $\%CPAI = \%ORG\ CPAI$  гэж тооцно.

8.28.Спиртийн агууламжийг жингийн хувиар тооцно. Хэрэв ус болон бусад шингэрүүлэгч найрлага нэмээгүй бол органик спиртийн агууламжийг 100 хувийн CPAI буюу 100 хувийн ORG CPAI гэж үзнэ.

8.29.Химийн буюу нефтийн гаралтай спирт хэрэглэхийг хориглоно.

8.30.Химийн боловсруулалт нь органик, байгалийн гоо сайхны бүтээгдэхүүний орцын үйлдвэрлэлд дараах химийн боловсруулалтыг зөвшөөрнө.

8.30.1.Гарал үүсэл химийн боловсруулалт хийх түүхий эд нь ХАА-н гаралтай, органик эсвэл байгалийн байх;

8.30.2.Хэрэглэсэн урвалж, катализатор-Зөвшөөрөгдсөн бодисын жагсаалтад орсон байх;

8.20.3.Үр дүнд үүсэх бодис- Эцсийн орц нь хэрэглэгчийн эрүүл мэндэд болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;

8.30.4.Химийн нэгдлийн гарал үүсэл- Газрын тос, генийн өөрчлөлтгүй, хлоржуулсан, этоксилжуулсан, хүнд метал агуулсан урвалж ашиглахыг хориглох;

8.30.5.Үйлдвэрийн орчин-Хүнсний эсвэл органик үйлдвэрлэлийн стандартад нийцсэн-Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлснээ баталгаажуулсан байх;

8.30.6.Органик, байгалийн гоо сайхны бүтээгдэхүүний орцын үйлдвэрлэл дараах химийн боловсруулалтыг хориглоно.

8.30.6.а.Этоксилжуулалт;

8.30.6.б.Хлоржуулалт;

8.30.6.в.Парабен, силикон үүсгэх урвалууд;

8.30.6.г.Генийн инженерчлэлд тулгуурласан химийн боловсруулалт.

8.31.Синтетик химийн боловсруулалт гэж бодисын молекулын бүтцийг химийн урвалын аргаар өөрчлөх, шинэ нэгдэл бий болгох, эсвэл байгалийн гаралтай бодисыг химийн аргаар хувиргах үйл явцыг

хэлнэ.

8.32.Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэлд химийн урвал нь зөвхөн COSMOS стандартын Хавсралт II болон IFOAM хавсрал 1-д зөвшөөрөгдсөн бодисууд болон процесс ашиглан хийгдэнэ. Жишээ нь:-этерификаци, эстерификаци, нейтрализаци, гидролиз, исэлдэлт ба ангижрал гэх мэт бие махбодод болон байгальд хор хөнөөлгүй, зөөлөн урвалууд,-Уусгагч, катализатор, реактив нь ус, спирт, цуу, байгалийн гаралтай тослог, ургамлын хүчил, фермент гэх мэт байгалийн гаралтай бодисоор хязгаарлагдана.

8.33.Синтетик боловсруулалтад петрохимийн гаралтай, нефтийн бүтээгдэхүүн, парафин, силикон, PEG/PPG (полиэтилен/полипропилен гликоль), EDTA, синтетик үнэр, будаг зэрэг бодис ашиглахыг хориглоно.

8.34.Хлоржуулалт, сульфонаци, нитризац, аминжуулалт байгальд хурц нөлөө үзүүлэх химийн урвал хэрэглэхийг хориглоно.

8.35.Генетикийн өөрчлөлттэй организм (ГМО)-ын гаралтай түүхий эд ашиглан химийн боловсруулалт хийхийг хориглоно.

8.36.Химийн боловсруулалт хийгдсэн бүх түүхий эдийн хувьд дараах нотолгоо бүрдүүлнэ.

8.36.1.Урвалын схем, ашигласан бодисуудын жагсаалт, CAS дугаар, гарал үүслийн баримт;

8.36.2.Байгаль орчинд хоргүй, биологийн задралтайг нотлох лабораторийн дүгнэлт.

8.37.Синтетик боловсруулалт хийсэн орц нь нийт найрлагын жингийн 5%-иас хэтрэхгүй байх бөгөөд органик орцын нийт хувь хэмжээг бууруулахгүй байх зарчим баримтална (COSMOS 2.3.3-т нийцүүлэн).

8.38.Үйлдвэрлэлийн орчин байр, цэвэр ариун цэвэр, тусгаарлагдсан, зохистой агааржуулалт, гэрэлтүүлэг, температур ба чийгшлийн хяналттай байх нь бүтээгдэхүүний бохирдол, нөлөөлөл, орчин нөхцөлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

8.39.Түүхий эд, дундын бүтээгдэхүүн, бэлэн бүтээгдэхүүний нэг чиглэлтэй, огтлолцохгүй байх зохион байгуулалттай байна.

8.40.Үйлдвэрийн бүсийг цэвэрлэх, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй, химийн бодис хадгалах хэсгийг тусгаарласан байна.

8.41.Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөөгүй, зэвэрдэггүй, шил, хүнсний зэрэгтэй хуванцар аюулгүй материал ашиглана.

8.42.Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодис нь бүтээгдэхүүнд үлдэгдэл үлдэхгүй, байгальд ээлтэй, хоргүй зөвшөөрөгдсөн бодис байна.

8.43.Үйлдвэрлэлийн орчинд шууд ашиглагдаж буй агаар, ус, нь бүтээгдэхүүнтэй шууд болон харьцах бүх өндөр чанартай, ундны усны

хэмжээнд хязгаарлагдсан байна.

8.44. Агаар, ус, уурын эх үүсвэр, цэвэршүүлэх систем, дамжуулах хоолой нь бохирдол, бичил биетэн, химийн болон хүнд металлын үлдэгдэл үүсгэхгүй бүтэцтэй байна.

8.45. Усыг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн, чанарын хяналтын бүртгэл хөтөлнө.

8.46. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нь түүхий эд хүлээн авах, хадгалах, боловсруулах, савлах хэсэг бүрд бүслэн зохион байгуулалттай бохирдол, холилдолт, нэмэлт нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

8.47. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ба хяналтыг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн стандарт үйлдвэрлэлийн MNS ISO 22716:2008 “Гоо сайхны бүтээгдэхүүн - Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)” ийн дагуу гүйцэтгэнэ.

8.48. Орц найрлагыг баталгаажсан эх үүсвэрээс ханган авч, хүлээн авах бүрд чанарын шалгалт хийнэ.

8.49. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх процесс нь технологийн зааврын дагуу хийгдэнэ.

8.50. Үйлдвэрлэлийн дараах хяналтын баримт бичиг, бүртгэл хөтөлнө:

8.50.1. Түүхий эдийн бүртгэл (гарал, код, шинжилгээний дүн);

8.50.2. Үйлдвэрлэлийн шат бүрийн ажлын карт, температур ба хугацааны бүртгэл;

8.50.3. Бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналтын дүн, сорилтын дүн;

8.50.4. Хяналтын бичиг баримтын хадгалалт, баталгаажуулалтын хянах.

8.51. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлд орсон орц, нэмэлт бодис бүрийг мөшгөх, баталгаажуулж бүртгэл хөтөлнө.

8.52. Үйлдвэрлэлийн чанарын хяналтыг хийж, бүртгэл, тэмдэглэл хөтөлнө.

8.53. Үйлдвэрлэлийн ажилтны эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, ариун цэвэр, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэгсэлтэй байна.

8.54. Ажилтны ариун цэвэр, гар угаах, хувцас солих, амрах зориулалтын өрөө тусгаарлагдсан байна.

8.55. Химийн бодис хадгалах, ашиглах, устгах нь аюулгүй ажиллагааны заавар, мөрдөнө.

8.56. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах аюулгүй байдлын үнэлгээ, хамгаалах хэрэгслийн хэрэглээ, анхан шатны сургалт, онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

8.57.Сав баглаа боодол, хадгалалт, шошгололт болон гэрчлэх тэмдгийн хэрэглээ нь бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, органик болон байгалийн гаралтай шинж чанарыг бүрэн хадгалах нөхцөлийг хангана.

8.58.Сав баглаа боодол нь MNS ISO 22715:2008 “Гоо сайхны бүтээгдэхүүн – Савлалт ба шошгололт” стандартын шаардлагыг хангаж, анхан шатны ба хоёрдогч савлагаанд заавал байх мэдээллийг агуулна.

8.59.Сав баглаа боодол нь хэрэглэгчийн эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, био-задардаг, дахин боловсруулах боломжтой эсвэл сэргээгдэх гаралтай материал ашигласан байна.

8.60.Хориглох материал нь:

8.60.1.PVC (поливинил хлорид), PS (полистирол), BPA (бисфенол А) агуулсан хуванцар;

8.60.2.Нано материал, нано бүрхүүл, нано технологийн гаралтай бүрэлдэхүүн;

8.60.3.Байгаль орчинд сөрөг нөлөөтэй, дахин боловсруулах боломжгүй материал.

8.61.Сав баглаа боодлын шийдэл дараах дараах зарчмуудыг баримтална.

8.61.1.Хэмнэлт – материалын хэрэглээг оновчтой хэмнэлттэй байлгах(нөөцийн хэрэглээг багасгаж, хаягдал үүсэхийг бууруулах)

8.61.2.Дахин ашиглах – сав эсвэл багц дахин ашиглагдах боломжтой байх;

8.61.3.Сэргээгдэх – ургамлын гаралтай, нөхөн сэргээгдэх эх үүсвэр ашиглах;

8.61.4.Дахин боловсруулах – ялган цуглуулж, дахин боловсруулах боломжийг бүрдүүлэх.

8.61.5.Сав баглаа боодлын дизайн, хэлбэр, өнгө, материалын сонголт нь бүтээгдэхүүний зориулалт, баталгаажуулалтын тэмдэг, шошгын мэдээлэлтэй уялдсан байна.

8.62.Хадгалалт нь түүхий эд, дунд шатны болон бэлэн бүтээгдэхүүнийг зориулалтын, цэвэр, тусгаарлагдсан орчинд хадгална.

8.63.Хадгалалтын температур, чийгшил, гэрэл, агааржуулалтын нөхцөл нь бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангахуйц байна.

8.64.Бүх хадгалалтын үе шатанд мөшгөлт, бүртгэлийг тогтмол хөтөлж, хяналт тавина.

8.65.Органик болон байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг синтетик, химийн гаралтай бүтээгдэхүүнтэй хамт хадгалахыг хориглоно.

8.66.Хадгалалтын орчин нь баталгаажуулалтын нөхцөлийг алдагдуулахгүй, бүтээгдэхүүний найрлага, шинж чанарыг өөрчлөхгүй

байна.

8.67.Гэрчлэх тэмдэг ба шошгололт нь хэрэглэгчид бүтээгдэхүүний гарал үүсэл, найрлага, органик эсвэл байгалийн статусыг ойлгомжтой илтгэнэ.

8.68.Шошго нь COSMOS болон IFOAM стандартын шаардлагад нийцсэн дараах мэдээллийг агуулна:

8.68.1.Бүтээгдэхүүний нэр болон төрөл;

8.68.2.Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, бүртгэлийн дугаар;

8.68.3.Орц бүрэлдэхүүний жагсаалт (INCI(Гоо сайхны бүтээгдэхүүний найрлагын олон улсын нэршлийн нэгдсэн жагсаалт) нэршлээр, органик орцын хувь тодотгосон);

8.68.4.Үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа;

8.68.5.Цэвэр жин, эзлэхүүн;

8.68.6.Гэрчилгээ олгосон байгууллагын нэр, бүртгэлийн дугаар;

8.68.7.“Органик” эсвэл “Байгалийн гаралтай” гэдгийг гэрчлэх тэмдэг, зэрэглэл;

8.68.8.Хэрэглэх заавар, анхааруулга.

8.69.Гэрчлэх тэмдэг болон “Органик”, “Байгалийн гаралтай” зэрэг үг хэллэгийг зөвхөн баталгаажсан бүтээгдэхүүнд хэрэглэнэ.

8.70.Баталгаажуулалтын тэмдэг, лого, шошгололтод аливаа хуурамч, төөрөгдүүлсэн, баталгаагүй мэдээлэл ашиглахыг хориглоно.

### **Ес.Органик бүтээгдэхүүнд тавих хяналт**

9.1.Органик үйлдвэрлэл эрхлэгч органик бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдал болон зөрчлөөс үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцна.

9.2.Баталгаажуулалтын байгууллага органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл явцад олон улсын норматив баримт бичиг болон Органик үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.

9.3.Нийтийн хэрэгцээнд нийлүүлсэн органик бүтээгдэхүүний шошгод тавих төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хуулиар зохицуулна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 7452 дугаарт бүртгэв.

## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар А-263

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны хадгаламжийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөлийг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт банканд даалгасугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

*Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 11 дүгээр сарын 18-ны  
өдрийн А-263 дугаар тушаалын хавсралт*

**БАНКНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ  
НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголбанкнаас хадгаламжийн үйл ажиллагааны зөвшөөрөл авсан банкны эрхлэх мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг нөхцөл, шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх банк нь энэхүү журам болон холбогдох хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг дагаж мөрдөнө.

1.3. Банкны мөнгөн хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээл дээр арилжих, төлбөр тооцоог гүйцэтгэхэд хуульд тусгайлан зааснаас бусад мөнгөн хадгаламжтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.4. Банк мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг зохицуулсан журам, заавар, арга, аргачлалыг энэ журамд нийцүүлэн дотооддоо боловсруулж, мөрдөх ба үндэслэлтэй тогтоосон эсэхэд Монголбанкнаас хяналт тавина.

**ХОЁР. МӨНГӨН ХАДГАЛАМЖ**

2.1. Банк иргэн, хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд /цаашид «хадгалуулагч» гэх/-д Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан журам болон энэ журамд заасан ерөнхий нөхцөлийн дагуу мөнгөн хадгаламжийн үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн гэрээ, биет хадгаламжийн сертификатаар байгуулахад хадгалуулагч өөрийн биеэр банканд ирж гэрээ байгуулах ба Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу цахим хэлбэрээр байгуулж болно.

2.3. Банк мөнгөн хадгаламжийн ерөнхий нөхцөлийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн тогтоох ба бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг нийтэд ил тод, үнэн зөв мэдээлэх үүрэгтэй.

2.4. Банкны холбогдох этгээд, харилцан хамаарал бүхий этгээдэд хадгаламжийн үйлчилгээг үзүүлэхдээ Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкнаас баталсан банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах тайлагнах, хяналт тавих харилцааг

зохицуулсан журамтай нийцүүлж, банкны бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлийн хүрээнд давуу байдал үүсгэхгүй байх зарчмыг баримтална.

### **ГУРАВ. ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

3.1. Банк харилцагчтай хадгаламжийн гэрээ байгуулахдаа гэрээний агуулга, зүйл, заалтыг танилцуулж, хүү, шимтгэл, хураамж тооцож буй аргачлал, бодит өгөөж, болон харилцагчийн эрх, үүргийг тайлбарлах үүрэгтэй.

3.2. Банкнаас иргэн, хуулийн этгээд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд мөнгөн хадгаламжийн данс нээх, хаах үйл ажиллагааны зохицуулалт Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулагдана.

3.3. Хадгаламжийн сертификат хэлбэрээр мөнгөн хадгаламжийн гэрээг байгуулахад дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.3.1. Өөрийн интернэт банкаар эсхүл банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан зуучлалын үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдээр дамжуулан хөрөнгийн болон мөнгөний зах дээр нээлттэй арилжих боломжийг бүрдүүлсэн байх;

3.3.2. Хадгаламжийн сертификатыг худалдах, бэлэглэх, барьцаалах эрх боломжтой байх;

3.3.3. Үнэт цаасны зах зээлд хадгаламжийн сертификат гаргахад Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн байх;

3.3.4. Хадгаламжийн сертификатыг анхдагч болон хоёрдогч зах дээр арилжаалахад үнэт цаасны зах зээлийн зохицуулалтад өөрөөр зааснаас бусад тохиолдолд төлбөр тооцоо нь тухайн өдөртөө багтаж хийгдэх нөхцөл бололцоог хангасан байна;

3.3.5. Харилцагч банкнаас гаргасан хадгаламжийн сертификатыг худалдах, худалдан авах, мэдээлэл авах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байх.

3.4. Энэ журмын 3.3.1.-д заасан зуучлалын үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан эсэхэд банк хяналт тавина:

3.4.1. Банктай хадгаламжийн сертификат арилжих, төлбөр тооцоо гүйцэтгэх, эрх, үүргийг тодорхойлсон гэрээтэй байх;

3.4.2. Хадгаламжийн сертификатын арилжаа, бүртгэл, хадгалалт, төлбөр тооцоо гүйцэтгэх, банкнаас санал болгосон хадгаламжийн сертификатыг худалдах, худалдан авах гэрээ байгуулах, хяналт тавих боломжийг хангасан, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан хэлцлийн цахим талбартай байх;

3.4.3.Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу харилцагчийн мэдээллийг банканд дамжуулах зөвшөөрөл авсан байх;

3.4.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу харилцагчийг таньж мэдэх ажиллагааг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;

3.4.5.Харилцагчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, банк болон эрх бүхий этгээд хуульд заасан эрхийн хүрээнд гаргаж өгөхөөс бусдаар гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэг нөхцөлийг тусгасан дотоод журам, заавартай байх.

3.5.Зуучлагчаар дамжуулан хадгаламжийн сертификатыг арилжих, худалдах, худалдан авахтай холбоотой эрсдэлийг тухайн банк хариуцна.

### **ДӨРӨВ. ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ, ХАРИУЦЛАГА**

4.1.Банк энэ журам болон Банкны тухай хууль, тогтоомжоор хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой тогтоосон хэм хэмжээ, хуулийн хязгаарлалтыг ханган ажиллана.

4.2.Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

4.3.Энэ журмын хэрэгжилтэд Монголбанкны хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгж хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч, хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 7453 дугаарт бүртгэв.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 521

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмыг мөрдөх бэлтгэл ажлыг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (В.Жавзан)-нд даалгасугай.

3.Төрийн албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу хөтөлж ажиллахыг томилох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

*Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн  
521 дүгээр тогтоолын хавсралт*

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн /цаашид албан хаагч" гэх/ албан хувийн хэргийг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, хамгаалах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг нь цахим болон цаасан хэлбэртэй байна.

1.3.Хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдөнө.

1.4.Хувийн хэрэг нь төрийн албан хаагчийн иргэний бүртгэлийн мэдээлэл, боловсрол, мэргэжил, мэргэшлийн ур чадвар, ажил эрхлэлт, гүйцэтгэлийн үр дүн, ёс зүй, сахилга хариуцлагын байдал, шагнал урамшуулал зэрэг холбогдох бусад мэдээллийг агуулсан байна.

1.5.Цахим хувийн хэрэг нь төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх болон төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн мэдээллийн сан /цаашид «мэдээллийн сан» гэх/-ийн үндсэн өгөгдөл болно.

1.6.Хувийн хэргийг төрийн албан тушаалд томилогдсоноор нээж, энэ журмын 1.4-д заасан мэдээллийг төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн сангийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” систем /цаашид “систем” гэх/-д бүрэн гүйцэд, үнэн зөв бүртгэж, хадгална.

1.7.Хувийн хэргийн мэдээллийг албан тушаалд томилох, дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэх, албан тушаал бууруулах, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, ёс зүйн хариуцлага хүлээлгэх, нийгмийн баталгааг хангах зэрэг хүний нөөцийн удирдлагын шийдвэр гаргахад мэдээллийн эх сурвалж болгон ашиглана.

1.8.Албан хаагчийг төрийн байгууллага хооронд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах шийдвэр гарснаас хойш түүний хувийн хэргийг ажлын 5 өдрийн дотор томилох эрх бүхий албан тушаалтны албан бичгээр тухайн байгууллагад хүргүүлнэ.

**Хоёр.Хувийн хэргийн бүрдэл**

2.1.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг дараах бүрдэлтэй байна.

- 2.1.1.Төрийн албан хаагчийн анкет /Маягт-1, Маягт-2, Маягт-3/
- 2.1.2.Боловсролын баримт бичиг
- 2.1.3.Сургалтад хамрагдсан болон мэргэшсэн тухай баримт бичиг
- 2.1.4.Ажил эрхлэлттэй холбогдох шийдвэр, хөдөлмөрийн гэрээ
- 2.1.5.Цэргийн үүрэгтний үнэмлэх
- 2.1.6.Албан тушаалын зэрэг дэв, цол, мэргэшлийн зэргийн үнэмлэх, холбогдох шийдвэр
- 2.1.7.Сахилгын болон ёс зүйн шийтгэл хүлээлгэсэн тухай шийдвэр, холбогдох баримт бичиг
- 2.1.8.Шагнал урамшуулалтай холбогдох шийдвэр, холбогдох баримт бичиг
- 2.1.9.Бүтээлийн жагсаалт
- 2.1.10.Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцсэнийг нотлох баримт бичиг
- 2.1.11.Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт
- 2.1.12.Төрийн албан хаагчийн тангаргийн хуудас, тангараг өргүүлсэн тухай шийдвэр
- 2.1.13.Албан тушаалын тодорхойлолт /ажлын байрны тодорхойлолт/
- 2.1.14.Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний хуудас
- 2.1.15.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/ мэдүүлсэн, Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ мэдүүлсэн баталгааны маягт
- 2.1.16.Нөхөх төлбөр, тэтгэмж, дэмжлэгтэй холбогдох шийдвэр, баримт бичиг
- 2.1.17.Хувь хүний намтар
- 2.1.18.Цээж зураг
- 2.1.19.Бусад баримт бичиг

2.2.Энэ журмын 2.1-д заасан бүрдлийн 2.1.2-2.1.8, 2.1.12, 2.1.13, 2.1.16-д заасан баримт бичиг нь хуулбар хувь байна.

2.3.Төрийн албан хаагчийн анкетын Маягт-1-ийг ажилд орох хүсэлтэй иргэн, төрийн албан хаагч, Маягт-2-ыг төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албанд орох хүсэлтэй иргэн, Маягт-3-ыг төрийн албан хаагч нотлох баримтад үндэслэн бөглөж, мэдээллийг тухайн иргэн, албан хаагч баталгаажуулан ашиглана.

### **Гурав.Хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагааны зохион байгуулалт**

3.1.Албан тушаалын тодорхойлолт/ажлын байрны тодорхойлолт/-д хүний нөөцийн болон хувийн хэрэг нээх, бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах, шинэчлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг

тусган тухайн асуудлыг хариуцсан албан хаагчийг байгууллагын хүний нөөц, захиргааны чиг үүргийг хариуцсан нэгж нь удирдлага, зохион байгуулалтаар хангаж, албан хаагч хэрэгжүүлж ажиллана.

3.2.Системд энэ журмын 3.1-д заасан албан хаагч болон байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан мэдээллийг хариуцан ажиллана.

3.3.Төрийн албанд томилогдсон албан хаагч хувийн хэргийг ажлын 3 өдрийн дотор бүрэн гүйцэд бүрдүүлж, энэ журмын 3.1-д заасан албан хаагчид хүлээлгэн өгнө.

3.4.Хувийн хэргийн мэдээллийг энэ журмын 1.5-д зааснаас бусад судалгаа, тайлан боловсруулах, хүний нөөцийн аудит, хяналт, шалгалт хийх зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтан ашиглаж болно.

3.5.Өөр байгууллагад шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаал дэвшүүлэхэд төрийн албан хаагчийн анкетын Маягт-3-ыг ашиглана.

3.6.Хуульд заасан үндэслэлээр албан хаагчийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд байгууллагад хуулбарлан цахимаар архивлан хадгалах бөгөөд энэ журмын 3.1-д заасан албан хаагч нь хувийн хэргийг “Хувийн хэргийг хүлээлгэн өгсөн тухай бүртгэл”-ийг хөтөлж өөрт нь, төрийн албан хаагч нас барсан тохиолдолд ар гэрт нь хүлээлгэн өгнө. Хүлээн авахаас татгалзсан тохиолдолд “Хувийн хэргийг архивд шилжүүлсэн жагсаалт”-ыг хөтөлж, байгууллагын архивд хүлээлгэн өгнө.

### **Дөрөв.Хувийн хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын удирдлага, албан хаагчийн хүлээх чиг үүрэг**

4.1.Байгууллагын удирдлага (томилох эрх бүхий албан тушаалтан) нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх, цахим болон цаасан хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн бүрэн гүйцэд, үнэн зөв байдалд хяналт тавих, хариуцах;

4.1.2.Энэ журмын 3.1-д заасан албан хаагчид системийг хариуцан ажиллах эрх олгох, шилжүүлэх талаар хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх;

4.1.3.Энэ журмын 3.1-д заасан албан хаагч өөрчлөгдсөн тохиолдолд цаасан хувийн хэргийг хүлээлцүүлэхэд хяналт тавих;

4.1.4.Цахим хувийн хэрэгт тухай бүр хяналт тавьж, байгууллагын мэдээллийг баталгаажуулах, цаасан хувийн хэрэгт 2 жил тутам дотоод хяналтыг зохион байгуулах.

4.2.Энэ журмын 3.1-д заасан албан хаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.Төрийн албанд томилогдсон албан хаагчид цахим болон цаасан хувийн хэрэг нээж, түүнд зөвлөн тусалж, хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулан хүлээн авах;

4.2.2.Энэхүү журмын 2.1.1-2.1.19-д заасан бүрдлийн дагуу хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалтад хяналт тавих, албан хаагчаас хувийн хэрэгт холбогдох мэдээллийн нотлох баримтыг шаардах;

4.2.3.Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, албан хаагч шилжих, сэлгэх, дэвших, чөлөөлөгдөх, халагдах болон бусад хөдөлгөөний өөрчлөлтийг нотлох баримтад үндэслэн ажлын 3 өдрийн дотор системд оруулах, цаасан хувийн хэрэгт холбогдох баримт бичгийг хавсаргах;

4.2.4.Цаасан хувийн хэргийг бүтцийн нэгж, албан тушаалын ангиллын дагуу албан хаагч бүрээр хавтас үүсгэн, нууцлал бүхий битүүмжлэлтэй шүүгээнд хадгалах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

4.2.5.Цахим хувийн хэргийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцан улирал тутам мэдээллийг хянах, баталгаажуулах;

4.2.6.Өөр албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд системд хандах эрхийг дараагийн албан хаагчид хүлээлгэж өгөх.

4.3.Төрийн албан хаагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Хувийн хэргийн мэдээлэл, баримтын үнэн зөв, бүрэн байдлыг хариуцан системд оруулах, баталгаажуулах, мэдээллийг засах, шинэчлэх хүсэлтийг гаргах;

4.3.2.Хувийн хэргийг бүрдүүлэх, баяжуулах талаар энэ журмын 3.1-д заасан албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

4.3.3.Хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалт, хадгалалт, хамгаалалттай танилцах, хувийн хэргээс баримт хуулбарлаж авах, нэмж оруулах, хасуулах;

4.3.4.Өөр байгууллагад шилжсэн, сэлгэн ажилласан тохиолдолд томилогдсон байгууллагад хувийн хэргийг шилжүүлэн өгсөн, хүлээж авсан эсэхэд хяналт тавих;

4.3.5.Хувийн хэрэг болон төрийн албан хаагчийн анкетад мэдээлэл дутуу, буруу бүрдүүлснээс гарах аливаа эрсдэлийг хариуцах.

### **Тав.Бусад асуудал**

5.1.Хариуцсан этгээд хувийн хэрэгт байгаа мэдээллийг улс төр, шашны болон албаны бус зориулалтаар ашиглах, баримтыг хуулбарлах, нэмэх, солих, устгах, мэдээлэл задруулах, ажлын байрнаас авч гарах, бусдад дамжуулах, үрэгдүүлэхийг хориглоно.

5.2.Хуульд тусгайлан заасан албан тушаалтны халдашгүй байдлыг хангах зорилгоор түүний хувийн хэрэг, анкетад агуулагдаж байгаа зарим мэдээллийг ил гаргах, ашиглах хүрээг холбогдох хууль, журмын хүрээнд тухайн байгууллагын хүсэлтэд үндэслэн хязгаарлаж болно.

5.3.Энэ журмыг зөрчсөн нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулах үндэслэл болно.

### нэгдүгээр хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНКЕТ

## Маягт-1.Албан хаагчийн ерөнхий мэдээлэл

## 1.Үндсэн мэдээлэл

Цээж зураг  
3x4 см

[illegible]

Цээж зураг  
3x4 см

|  |
|--|
|  |
|--|

\_\_\_\_\_

1.8 Төрсөн: аймаг хот

сүм, дүүрэг

| Аймаг, хот | Сум, дүүрэг | Баг, хороо | Хороолол, хотхон | Байр, гудамж | Тоот |
|------------|-------------|------------|------------------|--------------|------|
|            |             |            |                  |              |      |

\_\_\_\_\_

| Аймаг, хот | Сум, дүүрэг | Баг, хороо | Хороолол, хотхон | Байр, гудамж | Тоот |
|------------|-------------|------------|------------------|--------------|------|
|            |             |            |                  |              |      |

Цахим шуудангийн хаяг:

Утасны дугаар 2

Цахим шуудангийн хаяг:

Утасны дугаар

\_\_\_\_\_

☐ **Харааны**

☐ Сонсголын

☐ Yes

☐ Бусад

□ Бүсэд

## 2.Боловсролын мэдээлэл

| Д/д | Боловсролын түвшин | Элссэн он | Төгссөн он | Суралцсан улс | Сургууль | Эзэмшсэн мэргэжил | Гэрчилгээ, дипломын дугаар | Тэтгэлэгт хамрагдсан эсэх | Тэтгэлэгийн төрөл |
|-----|--------------------|-----------|------------|---------------|----------|-------------------|----------------------------|---------------------------|-------------------|
|     |                    |           |            |               |          |                   |                            | <input type="checkbox"/>  |                   |
|     |                    |           |            |               |          |                   |                            | <input type="checkbox"/>  |                   |
|     |                    |           |            |               |          |                   |                            | <input type="checkbox"/>  |                   |
|     |                    |           |            |               |          |                   |                            | <input type="checkbox"/>  |                   |
|     |                    |           |            |               |          |                   |                            | <input type="checkbox"/>  |                   |

(Суурь, бүрэн дунд, мэргэжлийн, техникийн, дипломын дээд боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэргийг он цагийн дараалал (туруулж төгссөнөөс эхлэн)-аар нөхөх ба сургууль, мэргэжлийн нэрийг бүтэн бичнэ)

Боловсролын доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан сэдэв:

Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан сэдэв:

2.1Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан тухай мэдээлэл

| Д/д | Сургалтын нэр | Сургалтын байгууллага | Хамрагдсан он | Хамрагдсан хугацаа | Үнэмлэх, гэрчилгээний дугаар | Тэтгэлэгт хамрагдсан эсэх | Тэтгэлийн төрөл |
|-----|---------------|-----------------------|---------------|--------------------|------------------------------|---------------------------|-----------------|
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |
|     |               |                       |               |                    |                              | <input type="checkbox"/>  |                 |

3.Хувь хүний чадамжийн мэдээлэл

Чадамжийн түвшнийг 1-4 оноо (1-бага, 2-дунд, 3-сайн, 4-маш сайн)-оор үнэлнэ.  
(Чадамжийн оношилгоонд хамрагдсан бол сүүлийн чадамжийн оношилгооны дүнгээр оруулна)

3.1.Чадамжийн хүрээ

Үнэлгээ

|         |                                                     |  |
|---------|-----------------------------------------------------|--|
| Суурь   | 1.Ёс зүй, үнэт зүйл                                 |  |
|         | 2.Монгол хэл, бичгийн мэдлэг хэрэглээ               |  |
|         | 3.Хууль, эрх зүйн мэдлэг, хэрэглээ                  |  |
|         | 4.Монголын түүх, нийгэм, соёл, эдийн засгийн мэдлэг |  |
| Хувьсах | 5.Цахим чадвар                                      |  |
|         | 6.Шүүх тунгаах                                      |  |
|         | 7.Инноваци ба шинийг санаачлах                      |  |
|         | 8.Өөрчлөлтөд дасан зохицох                          |  |
|         | 9.Манлайлах                                         |  |
|         | 10.Удирдан зохион байгуулах                         |  |
|         | 11.Багаар ажиллах                                   |  |
|         | 12.Гадаад хэлний мэдлэг, хэрэглээ                   |  |

3.1.2.1.Үндэсний бичгийн мэдлэг

| Мэдлэг, чадвар   | Сайн                     | Дунд                     | Мэдлэггүй                |
|------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| Унших            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Бичих            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| Компьютерт шивэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

3.1.12.1.Гадаад хэлний мэдлэг

| Д/д | Гадаад хэл | Сонсож ойлгох            |                          |                          | Ярих                     |                          |                          | Унших                    |                          |                          | Бичих                    |                          |                          |
|-----|------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
|     |            | Анган                    | Дунд                     | Ахисан                   | Анган                    | Дунд                     | Ахисан                   | Анган                    | Дунд                     | Ахисан                   | Анган                    | Дунд                     | Ахисан                   |
|     |            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
|     |            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
|     |            | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

3.1.12.2.Гадаад хэлний түвшний шалгалтын оноо: (TOEFL, IELTS гэх мэт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүчинтэй гадаад хэлний түвшин тогтоох шалгалтын мэдээлэл)

| Д/д | Гадаад хэл | Шалгалтын нэр | Оноо | Шалгалт өгсөн огноо |
|-----|------------|---------------|------|---------------------|
|     |            |               |      |                     |
|     |            |               |      |                     |

4.Ажил эрхлэлт, ажлын туршлагын тухай мэдээлэл

Ажил эрхлэлт (ажил эрхлэлтийн мэдээллийг анх ажилд орсноос эхлэн он цагийн дарааллаар бичнэ)

| Д/д | Байгууллагын нэр | Газар, нэгж, хэлтсийн нэр | Албан тушаал       |                             |                   | Ажилд орсон |                   | Ажлаас гарсан |                   | Үндэслэл |
|-----|------------------|---------------------------|--------------------|-----------------------------|-------------------|-------------|-------------------|---------------|-------------------|----------|
|     |                  |                           | Албан тушаалын нэр | Ангилал (ТУТ, ТЗ, ТТ, ТУ) * | Төрөл (У, Г, Т) * | Огноо       | Шийдвэрийн дугаар | Огноо         | Шийдвэрийн дугаар |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |
|     |                  |                           |                    |                             |                   |             |                   |               |                   |          |

\*Ангилал – төрийн улс төр, төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээ /төрийн албаны ангилал/  
\*Төрөл – удирдах, гүйцэтгэх, туслах /албан тушаалын төрөл/

5.Цэргийн алба хаасан эсэх тухай мэдээлэл

5.1.Цэргийн алба хаасан эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

5.2.Цэргийн үүрэгтний үнэмлэхийн дугаар:

Цэргийн алба хаасан хэлбэр:

6.Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар мэдээлэл

Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

| Д/д | Шүүхийн нэр | Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар | Эрүүгийн хуульд заасан зүйл, анги | Ялын төрөл | Эхлэх огноо | Ялын хугацаа | Үндэслэл |
|-----|-------------|----------------------------------|-----------------------------------|------------|-------------|--------------|----------|
|     |             |                                  |                                   |            |             |              |          |
|     |             |                                  |                                   |            |             |              |          |
|     |             |                                  |                                   |            |             |              |          |

7.Сахилгын шийтгэлийн тухай мэдээлэл

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан сүүлийн 1 жилийн хугацаанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар бичнэ.

Сахилгын шийтгэл хүлээсэн эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

| Д/д | Байгууллагын нэр | Шийдвэрийн огноо | Шийдвэрийн дугаар | Сахилгын шийтгэлийн төрөл | Шийтгэл ногдуулах үндэслэл |
|-----|------------------|------------------|-------------------|---------------------------|----------------------------|
|     |                  |                  |                   |                           |                            |

8. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл

Хууль тогтоомжид заасан сүүлийн 1 жилийн хугацаанд ногдуулсан ёс зүйн хариуцлагын мэдээллийг бичнэ.

Ёс зүйн зөрчил гаргасан эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

| Д/д | Байгууллагын нэр | Зөрчсөн нийтлэг шаардлага | Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрөл | Хүлээсэн хариуцлага | Зөрчил гаргасан огноо |
|-----|------------------|---------------------------|-----------------------------------|---------------------|-----------------------|
|     |                  |                           |                                   |                     |                       |

9. Шагналын тухай мэдээлэл

| Д/д | Шагналын төрөл | Шагналын нэр | Шийдвэрийн нэр | Шийдвэрийн огноо | Шийдвэрийн дугаар |
|-----|----------------|--------------|----------------|------------------|-------------------|
|     |                |              |                |                  |                   |
|     |                |              |                |                  |                   |
|     |                |              |                |                  |                   |
|     |                |              |                |                  |                   |
|     |                |              |                |                  |                   |

10. Бүтээлийн жагсаалт

| Д/д | Бүтээлийн нэр | Бүтээлийн төрөл | Бүтээл гаргасан огноо | Нэмэлт мэдээлэл |
|-----|---------------|-----------------|-----------------------|-----------------|
|     |               |                 |                       |                 |
|     |               |                 |                       |                 |
|     |               |                 |                       |                 |
|     |               |                 |                       |                 |
|     |               |                 |                       |                 |

(Нэмэлт мэдээлэл хэсэгт бүтээлийн тухай мэдээллийг АРА стандартын дагуу бичнэ)

Энэхүү маягаар мэдээлэл цуглуулж буй байгууллага, албан хаагч нь Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу хамгаалах бөгөөд хууль бусаар ашигласан, задруулсан бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Төрийн албан хаагчийн анкетын мэдээллийн үнэн зөв байдлыг иргэн, албан хаагч өөрөө хариуцна.

Төрийн байгууллагуудын мэдээллийн санд байгаа өөрийн мэдээллийг албан хэрэгцээнд зориулан төрийн байгууллагуудын мэдээллийн систем хооронд дамжуулан ашиглахыг зөвшөөрч байна.

Анкетаа үнэн зөв бичсэн:

/Эцэг (эх)-ийн нэр/

Өөрийн нэр

Гарын үсэг

он

сар

өдөр

Маягт-2.Төрийн албаны шалгалт, нөөцийн мэдээлэл

Эцэг(эх)-ийн нэр

Өөрийн нэр:

Иргэний бүртгэлийн дугаар

1.Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн тухай мэдээлэл

Төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн эсэх:

☐ Тийм☐ Үгүй

| Д/д | Шалгалт өгсөн байршил | Шалгалт өгсөн огноо | Шалгалтын оноо |
|-----|-----------------------|---------------------|----------------|
|     |                       |                     |                |

Төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа эсэх:

☐ Тийм☐ Үгүй

| Д/д | Нөөцийн сангийн бүрэлдэхүүн | Нөөцөд бүртгэгдсэн үндэслэл | Нөөцөд бүртгэгсэн шийдвэрийн нэр | Шийдвэрийн огноо |
|-----|-----------------------------|-----------------------------|----------------------------------|------------------|
|     |                             |                             |                                  |                  |

Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн эсэх:

☐ Тийм☐ Үгүй

| Д/д | Шалгалт өгсөн байршил | Байгууллага | Албан тушаал | Албан тушаалын төрөл | Шалгалтын оноо |
|-----|-----------------------|-------------|--------------|----------------------|----------------|
|     |                       |             |              |                      |                |

2.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай мэдээлэл

Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэх:

☐ Тийм☐ Үгүй

Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэх тодорхойлолт гаргасан байгууллагын нэр

(Төрийн жинхэнэ албан тушаалд томилогдоход сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг хавсаргана)

3.Улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцсон тухай мэдээлэл

| Улс төрийн албан тушаал | Төрийн захиргааны албан тушаалын зохих ангилал | Төрийн албанд ажилласан хугацаа         |                                                                                     | Төрийн албаны зөвлөлийн тогтоол |        |
|-------------------------|------------------------------------------------|-----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|---------------------------------|--------|
|                         |                                                | Төрийн албанд ажилласан хугацааг тооцох | Төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацааг дүйцүүлэн тооцох | Огноо                           | Дугаар |
|                         |                                                |                                         |                                                                                     |                                 |        |
|                         |                                                |                                         |                                                                                     |                                 |        |
|                         |                                                |                                         |                                                                                     |                                 |        |

4.Төрийн албан тушаалд туршилтын хугацаагаар ажилласан байдал

| Д/д | Байгууллага | Албан тушаал | Туршилтын хугацаа /6-12 сар/ | Эхэлсэн хугацаа | Дууссан хугацаа |
|-----|-------------|--------------|------------------------------|-----------------|-----------------|
|     |             |              |                              |                 |                 |

5.Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн тухай мэдээлэл

|   |                            |  |
|---|----------------------------|--|
| 1 | Тангаргийн хуудасны дугаар |  |
| 2 | Байгууллагын нэр           |  |
| 3 | Тангараг өргөсөн огноо     |  |

6.Албан тушаалын зэрэг дэв, цол, мэргэшлийн зэрэг

| Д/д | Албан тушаалын ангилал, зэрэглэл | Зэрэг дэв, мэргэшлийн зэрэг цол | Шийдвэрийн нэр | Шийдвэрийн огноо | Шийдвэрийн дугаар | Үнэмлэхийн дугаар |
|-----|----------------------------------|---------------------------------|----------------|------------------|-------------------|-------------------|
|     |                                  |                                 |                |                  |                   |                   |
|     |                                  |                                 |                |                  |                   |                   |
|     |                                  |                                 |                |                  |                   |                   |
|     |                                  |                                 |                |                  |                   |                   |
|     |                                  |                                 |                |                  |                   |                   |

7.Оршин сууж буй сууцны мэдээлэл (Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд)

Сууцны төрөл:

☐ Гэр

☐ Орон сууц

☐ Бие даасан тохилог сууц(хаус)

☐ Нийтийн байр

☐ Сууцны тусдаа байшин

☐ Бусад

Өмчлөлийн хэлбэр:

☐ Өөрийн

☐ Бусдын (түрээстэй)

☐ Бусад

☐ Түрээслээд өмчлөх

☐ Бусдын (түрээсгүй)

Орон сууцны зээлтэй эсэх:

☐ Тийм

☐ Зээлийн төрөл:

☐ Ипотекийн зээл

☐ Энгийн орон сууцны зээл

☐ Бусад зээл

☐ Үгүй

8.Нөхөх төлбөр, тэтгэмж, дэмжлэг авч байсан тухай мэдээлэл

| Д/д | Нөхөх төлбөр, тэтгэмж, дэмжлэгийн нэр | Мөнгөн дүн (мян.төг) | Шийдвэрийн нэр | Шийдвэрийн огноо, дугаар | Олгосон үндэслэл |
|-----|---------------------------------------|----------------------|----------------|--------------------------|------------------|
|     |                                       |                      |                |                          |                  |
|     |                                       |                      |                |                          |                  |
|     |                                       |                      |                |                          |                  |

\*Албан томилолтоос бусад нөхөх төлбөр хамаарна.

9.Гэр бүлийн байдал (зөвхөн гэр бүлийн бүртгэлд байгаа хүмүүсийг бичнэ)

| Д/д | Таны хэн болох | Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Төрсөн он | Төрсөн аймаг, хот | Хөдөлмөр эрхлэлт |
|-----|----------------|--------------------------------|-----------|-------------------|------------------|
|     |                |                                |           |                   |                  |
|     |                |                                |           |                   |                  |
|     |                |                                |           |                   |                  |
|     |                |                                |           |                   |                  |

10.Садан төрлийн байдал (эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өрх тусгаарласан хүүхдийг оруулан бичнэ)

| Д/д | Таны хэн болох | Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр | Төрсөн он | Төрсөн аймаг, хот | Хөдөлмөр эрхлэлт |
|-----|----------------|--------------------------------|-----------|-------------------|------------------|
|     |                |                                |           |                   |                  |
|     |                |                                |           |                   |                  |
|     |                |                                |           |                   |                  |

11.Хувь хүний намтар

Өөрийн, эцэг /эх/, асран хамгаалагчийн, түүний эцэг эхийн намтар

Анкетаа үнэн зөв бичсэн:

/Эцэг (эх)-ийн нэр/

Өөрийн нэр

Гарын үсэг

\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

Маягт-3.Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, хөдөлгөөний мэдээлэл

Эцэг(эх)-ийн нэр

Өөрийн нэр:

Иргэний бүртгэлийн дугаар

1.Одоо ажиллаж байгаа албан тушаалын мэдээлэл

|   |                                         |  |
|---|-----------------------------------------|--|
| 1 | Нэгжийн нэр                             |  |
| 2 | Албан тушаалын нэр                      |  |
| 3 | Төрийн албаны ангилал                   |  |
| 4 | Албан тушаалын төрөл                    |  |
| 5 | Албан тушаалын ангилал                  |  |
| 6 | Албан тушаалын зэрэглэл                 |  |
| 7 | Албан тушаалын зэрэг дэв, цол, мэргэшил |  |
| 8 | Томилогдсон огноо                       |  |

2.Албан хаагчийн ажилласан хугацаа (жилээр)

- 2.1.Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн ажилласан хугацаажил
- 2.2.Төрийн албанд ажилласан хугацаажил
- 2.3.Тухайн байгууллагад ажилласан хугацаажил
- 2.4.Тухайн албан тушаалд ажилласан хугацаажил

Ажилласан жил (албан тушаалын ангилал, төрөл)

| Д/д | Үзүүлэлт  | Төрийн улс төр | Төрийн захиргаа | Төрийн тусгай | Төрийн үйлчилгээ | Нийт |
|-----|-----------|----------------|-----------------|---------------|------------------|------|
| 1   | Удирдах   |                |                 |               |                  |      |
| 2   | Гүйцэтгэх |                |                 |               |                  |      |
| 3   | Туслах    |                |                 |               |                  |      |
| 4   | Нийт      |                |                 |               |                  |      |

Үүнээс төрийн захиргааны албанд ажилласан, дүйцүүлсэн, адилтгасан жил:

| Д/д | Үзүүлэлт              | Туслах түшмэл | Дэс түшмэл | Ахлах түшмэл | Эрхэлсэн түшмэл | Тэргүүн түшмэл |
|-----|-----------------------|---------------|------------|--------------|-----------------|----------------|
| 1   | Удирдах               |               |            |              |                 |                |
| 2   | Гүйцэтгэх             |               |            |              |                 |                |
| 3   | Дүйцүүлсэн/адилтгасан |               |            |              |                 |                |
| 4   | Нийт                  |               |            |              |                 |                |

3.Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ

| Д/д | Он | Ерөнхий үнэлгээ |         | Үнэлгээний дүнг үндэслэн гаргасан шийдвэр |
|-----|----|-----------------|---------|-------------------------------------------|
|     |    | Оноо            | Үнэлгээ |                                           |
| 1   |    |                 |         |                                           |
| 2   |    |                 |         |                                           |
| 3   |    |                 |         |                                           |

4.Төрийн албан хаагчийн чадамжийн оношилгоо (Тухайн жилийн мэдээллийг оруулна)

| Чадамжийн хүрээ |                                                   | Хөдлөнгийн үнэлгээ |         |         |
|-----------------|---------------------------------------------------|--------------------|---------|---------|
|                 |                                                   | ....ОН             | .....ОН | .....ОН |
| Суурь           | Ёс зүй, үнэт зүйл                                 |                    |         |         |
|                 | Монгол хэл, бичгийн мэдлэг хэрэглээ               |                    |         |         |
|                 | Хууль, эрх зүйн мэдлэг, хэрэглээ                  |                    |         |         |
|                 | Монголын түүх, нийгэм, соёл, эдийн засгийн мэдлэг |                    |         |         |
| Хувьсах         | Цахим чадвар                                      |                    |         |         |
|                 | Шүүх тунгаах                                      |                    |         |         |
|                 | Инноваци ба шинийг санаачлах                      |                    |         |         |
|                 | Өөрчлөлтөд дасан зохицох                          |                    |         |         |
|                 | Манлайлах                                         |                    |         |         |
|                 | Удирдан зохион байгуулах                          |                    |         |         |
|                 | Багаар ажиллах                                    |                    |         |         |
|                 | Гадаад хэлний мэдлэг, хэрэглээ                    |                    |         |         |

5.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогыг мэдүүлсэн тухай

| Д/д | ХАСХОМ-ийг мэдүүлэх үндэслэл                               | Огноо |
|-----|------------------------------------------------------------|-------|
| 1   | Томилогдсон, сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор гаргасан |       |
| 2   | Шинэчлэн гаргасан тайлант он                               |       |
| 3   | Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт               |       |

Анкетаа үнэн зөв бичсэн:

/Эцэг (эх)-ийн нэр/Өөрийн нэрГарын үсэг

\_\_\_ он \_\_\_ сар \_\_\_ өдөр

*Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх  
журмын хоёрдугаар хавсралт*

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНКЕТ БӨГЛӨХ ЗААВАР**

**1.Ерөнхий ойлголт**

1.1.Төрийн албан хаагчийн анкетыг “Анкет бөглөх заавар”-ын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөнө.

1.2.Төрийн албан хаагчийн анкетын маягт нь дараах агуулгатай байна.

**1.2.1 Маягт-1.Албан хаагчийн ерөнхий мэдээлэл**

1/Үндсэн мэдээлэл

2/Боловсролын мэдээлэл

3/ Хувь хүний чадамжийн мэдээлэл

4/ Ажил эрхлэлт, ажлын туршлагын тухай мэдээлэл

5/ Цэргийн алба хаасан тухай мэдээлэл

6/ Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар мэдээлэл

7/ Сахилгын шийтгэлийн тухай мэдээлэл

8/ Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл

9/ Шагналын тухай мэдээлэл

10/ Бүтээлийн жагсаалт

1.2.2.Маягт-2.Төрийн албан хаагчийн шалгалт, нөөцийн мэдээлэл

1/Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн тухай мэдээлэл

2/Сэтгэцийн эрүүл мэндийн тухай мэдээлэл

3/Улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцсон мэдээлэл

4/ Төрийн албан тушаалд туршилтын хугацаагаар ажилласан эсэх

5/ Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн тухай мэдээлэл

6/ Албан тушаалын зэрэг дэв, цол, мэргэшлийн зэрэг

7/ Оршин сууж буй сууцны мэдээлэл

8/ Нөхөх төлбөр, тусламж, дэмжлэгийн тухай мэдээлэл

9/ Гэр бүлийн байдал

10/ Садан төрлийн байдал

11/ Хувь хүний намтар

1.2.3.Маягт-3.Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, хөдөлгөөний мэдээлэл

1/Одоо ажиллаж байгаа албан тушаалын мэдээлэл

2/Албан хаагчийн ажилласан хугацаа

3/Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ

4/Төрийн албан хаагчийн чадамжийн оношилгоо

5/Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогыг мэдүүлсэн тухай

1.3.Төрийн албан хаагчийн анкетыг бөглөхийн өмнө маягтын асуулт бүртэй сайтар танилцаж, иргэний үнэмлэх, боловсрол, мэргэжлийн диплом, гэрчилгээ зэрэг баримт бичгийнхээ мэдээллийг анкетын асуулттай тулган нягталж, үнэн зөв оруулж, гарын үсгээр баталгаажуулна.

1.4.Анкетад байгууллага, албан тушаалын нэрийг товчлолгүй, бүтэн бичнэ.

1.5.Төрийн албан хаагчийн анкетын “Маягт-1”, “Маягт-2”, “Маягт-3” маягт дахь мэдээлэл нь төрийн албаны тоо бүртгэлийн мэдээллийн сангийн анхан шатны бүртгэл болох бөгөөд маягтыг шинэчлэх, сайжруулахад холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг авна.

## **2.Төрийн албан хаагчийн анкетыг бөглөх заавар**

### **2.1.Маягт-1.Албан хаагчийн ерөнхий мэдээлэл**

#### **2.1.1.Үндсэн мэдээлэл**

“Иргэний бүртгэлийн дугаар” гэж Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-ийг ойлгоно.

“Иргэний харьяалал” хэсэгт ямар улсын иргэний харьяалалтай болохыг бичнэ. Монгол Улсын харьяат бол гэрчлэх үндсэн баримт болох иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана.Төрийн жинхэнэ албанаас бусад албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн өөрийн үндсэн болон давхар иргэншлээ бүрэн бичиж баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргана.

“Ургийн овог” хэсэгт иргэний үнэмлэхэд бүртгэлтэй ургийн овгийг бичнэ.

“Эцэг(эх)-ийн нэр” хэсэгт иргэний үнэмлэхэд бүртгэлтэй албан ёсоор овоглодог хүний нэрийг,

“Өөрийн нэр” хэсэгт нэрээ тус тус бичнэ.

“Хүйс” хэсэгт эрэгтэй, эмэгтэй аль болохыг ☐ хэсэгт тэмдэглэнэ.

“Төрсөн он, сар, өдөр” хэсэгт өөрийн төрсөн он, сар, өдрийг регистрийн дугаарт бичигдсэн огноогоор бичнэ.

“Үндэс, угсаа” хэсэгт халх, буриад, дөрвөд, казах гэх мэтээр өөрийн үндэс угсааг бичнэ.

“Төрсөн аймаг, хот, сум, дүүрэг” хэсэгт өөрийн төрсөн аймаг, хот, сум, дүүрэг, төрсөн газрын нэрийг бичнэ.

“Байнгын, түр оршин суугаа хаяг” хэсэгт байнгын, эсвэл

түр оршин суугаа хаягийг бичнэ. Хаягт аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, хорооллын нэр, гудамж, байр, орц, хаалганы дугаарыг товчлохгүй, бүтэн бичнэ.

“Холбоо барих” хэсэгт өөрийн идэвхтэй ашиглаж буй гар утасны дугаар, хувийн цахим шуудангийн хаягийг бүрэн бичнэ.

“Зайлшгүй шаардлага гарсан үед харилцах хүн” хэсэгт зайлшгүй шаардлага гарсан үед холбогдох ойр дотны хүнийг таны хувьд хэн болох, нэр, утасны дугаарыг бичнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй эсэх” хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй эсэх талаар ☐ хэсэгт тэмдэглэх ба хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг ☐ хэсэгт тэмдэглэнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-ийг ойлгоно.

“Гэрлэлтийн байдал” хэсэгт өөрийн гэрлээгүй, гэрлэсэн, бусад байдлыг ☐ хэсэгт тэмдэглэнэ.

### **2.1.2.Боловсролын мэдээлэл**

“Боловсролын мэдээлэл” хэсэгт суурь боловсролоос дээш бүх түвшний боловсролын мэдээллийг хүснэгтэд оруулна (суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын үнэмлэх, дипломын дээд боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын дипломын мэдээлэл).

“Боловсролын түвшин” гэдэгт Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасныг доктор, магистр, бакалавр, дипломын болон дэд бакалавр, техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, бүрэн дунд, суурь, бага, боловсролгүй гэж нарийвчлан ангилсныг ойлгоно. Ерөнхий боловсролыг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.1-ийн дагуу суурь, бүрэн дунд түвшнээр нь мэдээллийг оруулж, гэрчилгээ, диплом зэрэг нотлох баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргана.

- Боловсролгүй гэж ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүйг;

- Бага боловсрол гэж ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөнийг;

- Суурь боловсрол гэж ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой, эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн ба суурь боловсролын гэрчилгээтэй байхыг тус тус ойлгоно.

“Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг

хамгаалсан сэдэв” хэсэгт докторын зэрэг хамгаалсан сэдвийг бүтэн бичнэ.

“Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан тухай мэдээлэл” хэсэгт мэргэжлийн болон бусад чиглэлээр хамрагдсан үнэмлэх, сертификаттай сургалтын тухай мэдээллийг оруулна. Богино хугацааны сургалт гэж 3 сараас доош, дунд хугацааны сургалт гэж 3-6 сар, урт хугацааны сургалт гэж 6 сараас дээш хугацааны сургалтыг тус тус ойлгоно.

Богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх багц сургалт, арга зүйн, гадаад, дотоодын богино хугацааны сургалт, семинарт хамрагдсан гэрчилгээ, үнэмлэх, сертификатын хуулбарыг хувийн хэрэгт хавсаргана.

Тэтгэлэгт хамрагдсан гэдэгт суралцах хугацааны туршид бүрэн тэтгэлэг авсныг ойлгоно /кредитийн, семестрийн зэрэг хэсэгчилсэн тэтгэлгийг оруулахгүй/. Боловсролын баримт бичгийг боловсролын салбарын мэдээллийн системд бүртгүүлсэн байна /гадаад улсад төгссөн бол хамаарахгүй/.

Тэтгэлгийн төрөл хэсэгт

- Гадаад орны ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрөөр
- МУ-ын ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрөөр
- Өөрийн ажиллаж буй байгууллагатай байгуулсан гэрээний дагуу
- Олон улсын байгууллагын болон гадаадын сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрөөр
- Бусад тэтгэлэгт хөтөлбөрөөр зэргээс аль тохирохыг бичнэ.

Хувийн хэрэгт: Боловсролын баримт бичгийн хуулбарыг хавсаргана.

### **2.1.3.Хувь хүний чадамжийн мэдээлэл**

Хувь хүн өөрийн чадамжийн хүрээний түвшнийг 1-4 оноо (1-бага, 2-дунд, 3-сайн, 4-маш сайн)-оор тус бүрээр үнэн зөв үнэлж тэмдэглэнэ.

“Үндэсний бичгийн мэдлэг” болон “гадаад хэлний мэдлэг” хэсэгт өөрийн чадварын аль тохирохыг тэмдэглэнэ.

“Гадаад хэлний түвшний шалгалтын оноо” хэсэгт TOEFL, IELTS гэх мэт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний түвшин тогтоох шалгалтын өгч байсан бол хүчинтэй байгаа шалгалтын мэдээллийг бичнэ.

### **2.1.4.Ажил эрхлэлт, ажлын туршлагын тухай мэдээлэл**

Энэ хэсэгт өөрийн орон тооны үндсэн албан тушаал эрхэлж байсан ажил эрхлэлтийн мэдээллийг хүснэгтийн дагуу он цагийн дарааллаар, байгууллага, албан тушаалын нэрийг товчлохгүйгээр

бичнэ. Үндэслэл хэсэгт ажлаас чөлөөлсөн, халсан, шилжүүлсэн, сэлгэн ажилласан шийдвэрт заасан гол үндэслэлийг хуулийн заалтаар бичнэ. Жишээ нь: ТАтХ-ийн 46.1.1, ХтХ-ийн 79.1 гэх мэт /Тухайн салбарын ажил эрхлэлттэй холбоогүй хууль тогтоомжийн заалтыг оруулахгүй/.

Хувийн хэрэгт: Төрийн албан хаагчийг албан тушаалд томилсон, сэлгэн болон шилжүүлсэн, түр орлон ажиллуулсан, чөлөөлсөн, халсан зэрэг ажил эрхлэлтийн тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал, шийдвэрийн хуулбарыг хувийн хэрэгт он цагийн дарааллаар хавсаргана.

#### **2.1.5.Цэргийн алба хаасан эсэх тухай мэдээлэл**

"Цэргийн алба хаасан эсэх" тухай мэдээллийг тохирох ☐ хэсэгт тэмдэглэнэ.

Цэргийн алба хаасан бол цэргийн үүрэгтний үнэмлэхийн дугаар, цэргийн алба хаасан байдлыг бичнэ. Цэргийн алба хаасан байдал гэдэгт цэргийн жинхэнэ алба, оюутан цэрэг /цэргийн үүрэгтэн/, цэргийн дүйцүүлэх албыг хаасан гэх мэт цэргийн алба хаасан хэлбэрийг тодорхой бичиж, цэргийн үүрэгтний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана.

Эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн алба хаах боломжгүй бол тайлбар хэсэгт энэ талаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дугаар, огноог бичнэ.

#### **2.1.6.Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай мэдээлэл**

Эрүүгийн хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар ☐ хэсэгт тэмдэглэх ба "Тийм" бол хүснэгтийн дагуу холбогдох мэдээллийг бөглөнө. Ялын төрөл гэж Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд заасан төрлийг ойлгоно.

Хувийн хэрэгт: Тодорхойлолтыг хавсаргана.

#### **2.1.7.Сахилгын шийтгэлийн тухай мэдээлэл**

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын шийтгэл хүлээсэн эсэх талаар ☐ хэсэгт тэмдэглэх ба "Тийм" бол мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөнө. Сахилгын шийтгэлтэй холбоотой тушаал шийдвэр, өргөдөл, албан хаагчийн тайлбар зэргийн хуулбарыг хувийн хэрэгт хавсаргана.

#### **2.1.8.Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу сүүлийн 1 жилийн хугацаанд зөрчил гаргасан эсэх талаар ☐ хэсэгт тэмдэглэх ба "Тийм" бол хүснэгтийн дагуу холбогдох мэдээллийг бөглөнө. Ёс зүйн зөрчилтэй холбоотой тушаал шийдвэр, өргөдөл, албан хаагчийн тайлбар зэргийн хуулбарыг хувийн хэрэгт хавсаргана.

### **2.1.9.Шагналын тухай мэдээлэл**

Байгууллагын шагнал, Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, жуух бичиг, Монгол Улсын цол, одон, медалийн тухай мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөж бичнэ. Төрийн албан хаагчид төрийн дээд одон, медаль, цол, тэмдэг, байгууллагын болон салбарын шагнал, урамшуулал олгосон тухай тушаал, шийдвэр, шагналын холбогдох баримт бичгийн хуулбарыг хувийн хэрэгт хавсаргана.

### **2.1.10.Бүтээлийн жагсаалт**

Төрийн албан хаагч өөрийн туурвиж нийтлүүлсэн ном, зохиол, судалгаа шинжилгээний өгүүлэл, зохих журмын дагуу баталгаажсан шинэ бүтээл, оновчтой санал зэргийг оруулна. Бүтээлийн жагсаалтыг туурвисан он, цагийн дарааллаар жагсааж бичнэ. Нэмэлт мэдээлэл хэсэгт бүтээлийн тухай мэдээллийг АРА стандартын дагуу бичнэ.

## **2.2.Маягт-2.Төрийн албан хаагчийн шалгалт, нөөцийн мэдээлэл**

### **2.2.1.Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн тухай мэдээлэл**

“Төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн эсэх” талаар ☐ хэсэгт тэмдэглэнэ.Тэнцсэн бол хүснэгтийн дагуу холбогдох мэдээллийг оруулна.

“Төрийн жинхэнэ албаны нөөцөд байгаа эсэх” хэсэгт тохирох мэдээллийн өмнөх ☐ хэсэгт тэмдэглэнэ.Төрийн жинхэнэ албаны нөөц гэдэгт Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 498 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.1-2.1.7 дахь заалтад заасныг ойлгоно. Нөөцөд байгаа бол хүснэгтийн дагуу холбогдох мэдээллийг бөглөнө. Нөөцөд бүртгэгдсэн үндэслэл хэсэгт нөөцөд бүртгэгдсэн шийдвэрт заасан гол үндэслэлийг хуулийн заалтаар бичнэ. Жишээ нь: ТАТХ-ийн 33.8, ТАТХ-ийн 46.1.1-46.1.4 гэх мэт. Нөөцөд бүртгэсэн шийдвэрийн нэр, огноо дугаар хэсэгт дараах байдлаар бичнэ.ТАЗ-ийн тогтоол ... оны ... дугаар; ... байгууллагын даргын тушаал, ... оны ... дугаар гэх мэт./ Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журамд заасан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан удирдах албан тушаалтны нөөцөд энэ хүснэгтийн Нөөцөд бүртгэсэн шийдвэрийн нэр, огноо дугаар хэсэгт хамааралгүй/.

“Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн эсэх” талаар ☐ хэсэгт тэмдэглэнэ. Энэ хэсэгт хамгийн сүүлд өгч тэнцсэн тусгай шалгалтын тухай мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөж бичнэ. Мэдээллийг байгууллагын энэ журмын 3.1-д заасан ажилтан баталгаажуулна.

**Хувийн хэрэгт:** Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгсөн бол тухайн шалгалтын дүнгийн хуудас, нэр дэвшүүлсэн тухай тогтоолын хуулбар, лавлагаа, тодорхойлолтыг албан хаагчийн хувийн хэрэгт хавсаргана.

### **2.2.2.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай мэдээлэл**

Сэтгэцийн эмгэгтэй эсэх талаар ☐ хэсэгт тэмдэглэх ба сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэх талаар тодорхойлолт гаргасан байгууллагын нэрийг бичнэ. Тодорхойлолтыг хувийн хэрэгт хавсаргана.

### **2.2.3.Улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцсон тухай мэдээлэл**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журам”-ын дагуу дүйцүүлсэн мэдээллийг оруулна. Холбогдох баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргана.

### **2.2.4.Төрийн албан тушаалд туршилтын хугацаагаар ажилласан байдал**

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол журам батлах тухай”-ын дагуу үйл ажиллагааны үр дүнг бүртгэнэ.

### **2.2.5.Төрийн албан хаагчийн тангараг өргөсөн тухай мэдээлэл**

Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дугаар зарлигаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам батлах тухай”-ын дагуу үйл ажиллагааны үр дүнг бүртгэнэ. Тангаргийн хуудсыг хувийн хэрэгт хавсаргана.

### **2.2.6.Албан тушаалын зэрэг дэв, цол, мэргэшлийн зэрэг**

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр олгосон төрийн захиргааны тэргүүн зэргийн тэргүүн түшмэл, дэд зэргийн эрхэлсэн түшмэл, төрийн тусгай албан хаагчийн хувьд хууль цаазын итгэмжит зөвлөх, тэргүүлэх аудитор, төрийн үйлчилгээний албан тушаалтны хувьд ахлах багш, дэд профессор, профессор, академич, тэргүүлэх зэргийн эмч, зөвлөх инженер гэх мэтээр зэрэг дэв, цэргийн болон дипломат цол олгосон тухай мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөж бичнэ.

Цэргийн цолтой бол тухайн цолны нэр, олгосон шийдвэр, холбогдох бусад мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөж бичнэ.

### **2.2.7.Албан хаагчийн оршин сууж буй сууцны мэдээлэл**

Оршин сууж буй сууцны мэдээлэл хэсэгт өөрийн оршин сууж буй сууцны талаар тохирох мэдээллийн өмнөх ☐ хэсэгт тэмдэглэнэ.

Сууцны төрлийг дараах байдлаар ойлгоно.

Гэр гэж бүх төрлийн монгол гэр болон цаатны урцыг хамааруулж;

Орон сууц гэж бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалтай, бүртгэл хийх үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг;

Бие даасан тохилог сууц (хаус) гэж нэг өрх амьдрах зориулалтай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж ба холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай (ус татдаг) сууцыг;

Сууцны тусдаа байшин гэж ихэвчлэн гэр хорооллын хашаанд нэг ба түүнээс олон өрөөтэй, дэд бүтцийн (гал тогоо, онгоц, шүршүүр, халаалтын систем, усан хангамж, дотроо бие засах газар зэрэг) хангамжууд бүхэлдээ болон аль нэг нь байхгүй сууцыг;

Нийтийн байр гэж иргэд бөөнөөрөө буюу хэсэг бүлгээрээ амьдран суудаг, олон өрөөтэй, бүртгэх үед хүн амьдарч байгаа сууцыг;

Бусад сууц гэж анхнаасаа хүн амьдрах зориулалтаар бариагүй эсвэл хүн амьдрахад зориулан өөрчлөн засаж тохижуулсан сууцыг тус тус ойлгоно.

#### **2.2.8.Нөхөх төлбөр, тусламж, дэмжлэгийн тухай мэдээлэл**

Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хуульд зааснаар төрийн албан хаагчид олгосон нөхөх төлбөр, тусламж, дэмжлэгийн мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөж бичнэ. /Жишээ нь: Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4-59.1.8 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 61.1.5, 61.1.7, 61.1.8 заалт гэх мэт/. Нөхөх төлбөрт албан томилолтоос бусад нөхөх төлбөр хамаарна. Мөнгөн тусламж, дэмжлэгээс бусад хэлбэрээр нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг үзүүлсэн бол үнийг мөнгөн дүнд шилжүүлж тооцно.

**2.2.9.“Гэр бүлийн байдал”** хэсэгт зөвхөн гэр бүлийн өрхийн бүртгэлд буй нэг өрхөд байнга оршин суудаг хүмүүсийн мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөнө.

**2.2.10.“Садан төрлийн байдал”** хэсэгт эцэг, эх, ах, эгч, дүү, өрх тусгаарласан хүүхэд зэрэг гэр бүлийн бүртгэлд ороогүй хүмүүсийн мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөнө.

**2.2.11.“Хувь хүний намтар”-ын** бүрдэлд өөрийн болон эцэг /эх/, асран хамгаалагчийн, түүний эцэг /эх/-ийн намтар багтана.

Эцэг /эх/, асран хамгаалагч болон түүний эцэг /эх/-ийн намтарт нэр, үндэс угсаа, төрсөн аймаг, хот, сум, дүүрэг, он, сар, өдөр, боловсрол, мэргэжил, ажил эрхлэлт, гавьяа шагнал, бүтээл туурвил,

ял шийтгэлийн талаар бичнэ.

Өөрийн намтарт төрсөн аймаг, хот, сум, дүүрэг, баг, хороо, газар, он, сар, өдөр, үндэс угсаа, хаана, ямар сургуульд суралцаж, ямар мэргэжил, боловсрол эзэмшсэн, ямар сэдвээр боловсролын болон эрдмийн зэрэг хамгаалсан, хаана, ямар ажил хөдөлмөр эрхэлсэн, одоо ямар ажил эрхэлж байгаа, хэзээ, ямар шагнал хүртсэн, эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байсан эсэх талаар бичнэ. Өөрийн авьяас чадвар, тусгай бэлтгэл, гадаад хэл, компьютер, монгол хэл, бичгийн чадвар, цаашид хөгжүүлэх хэрэгцээ, сонирхлоо тодорхойлон бичиж болно.

### **2.3.Маягт-3.Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, хөдөлгөөний мэдээлэл**

Маягт-3-ийн 2.3.2-оос 2.3.5 хэсгүүдийг жил бүр шинэчлэх бөгөөд тухайн жилд орсон албан хаагчийн хөдөлгөөний мэдээлэл маягт-1-ийн ажил эрхлэлт хэсэгт мөн шинэчлэгдэнэ.

**2.3.1.Одоо ажиллаж байгаа албан тушаалын мэдээлэл** гэдэгт тухайн албан хаагч ямар ангилал, зэргийн албан тушаалд ажиллаж байгаа мэдээлэл системээс гарна. Энэхүү мэдээлэл нь «Маягт-1-ийн 4.Ажил эрхлэлт, ажлын туршлагын тухай мэдээлэл»-ээс системээр тооцон гаргана.

Хувийн хэрэгт: Томилох эрх бүхий этгээдийн баталсан албан тушаалын тодорхойлолтыг хавсаргана.Албан тушаалын тодорхойлолтыг шинээр томилогдож буй албан хаагчид заавал танилцуулж, тэмдэглэл хөтөлнө.Төрийн албан хаагчтай байгуулсан хүчин төгөлдөр хөдөлмөрийн гэрээ /Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажил олгогчтой байгуулсан бусад хөдөлмөрийн гэрээ/-г хувийн хэрэгт хавсаргана.

**2.3.2.Албан хаагчийн ажилласан хугацаа** - «Маягт-1-ийн 4.Ажил эрхлэлт, ажлын туршлагын тухай мэдээлэл»-ээс системээр тооцон гаргана.

**2.3.3.Ажлын гүйцэтгэл, үр дүн, чадамжийн түвшингийн үнэлгээ** - Албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг энэ журмын 3.1-д заасан албан хаагч оруулна.

Хувийн хэрэгт: Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, чадамжийн түвшинг үнэлсэн үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан болон төрийн албаны бусад ангиллын албан хаагчийн үйл ажиллагааны тайлан, үнэлсэн үнэлгээний хуудсыг хавсаргана.

**2.3.4.Төрийн албан хаагчийн чадамжийн хүрээ** - Хөндлөнгийн үнэлгээний үр дүнг оруулна.

2.3.5.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогыг

мэдүүлсэн тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргасан тухай мэдээллийг оруулна. Он, сар, өдөр хэсэгт мэдүүлэг баталгаажуулан илгээсэн хугацааг бичнэ.

Хувийн хэрэгт: Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/ мэдүүлсэн болон Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ мэдүүлсэн баталгааны маягтыг хавсаргана.

Төрийн албан хаагчийн албан тушаалд томилогдоход мэдүүлсэн болон жил бүр шинэчлэн мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийн баталгааны маягтыг хувийн хэрэгт хавсаргах ба баталгааны маягтыг мэдүүлэг гаргасан албан хаагч болон байгууллагын эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/ гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын гуравдугаар хавсралт

“Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хүлээлгэн өгсөн тухай” маягт

| Д/д | Албан хаагчийн нэр | Албан тушаал | Хувийн хэргийн хуудасны тоо | Хүлээн авсан |               |
|-----|--------------------|--------------|-----------------------------|--------------|---------------|
|     |                    |              |                             | Гарын үсэг   | Он, сар, өдөр |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |
|     |                    |              |                             |              |               |

Бүртгэл хөтөлсөн:  
Албан тушаал .....  
Албан хаагчийн нэр /...../

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дөрөвдүгээр  
хавсралт

“Төрийн албан хаагчийн хувийн хэргийг архивд шилжүүлсэн  
тухай” маягт

| Д/д | Албан хаагчийн нэр | Нэгжийн нэр | Албан тушаал | Хувийн хэргийн хуудасны тоо |
|-----|--------------------|-------------|--------------|-----------------------------|
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |
|     |                    |             |              |                             |

Хүлээлгэн өгсөн:

Албан хаагч ..... /...../

Албан тушаал .....

Хүлээн авсан:

Архивч ..... /...../

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 703

Улаанбаатар  
хот

### ТАРИФТ ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын цагийн ялгаварт тарифт тоолууртай өрхийн хэрэглэсэн цахилгааны тарифыг бууруулж дараах хөнгөлөлтийг үзүүлэхийг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай. Үүнд:

1.1. 220 В-ын хүчдэлийн түвшинд холбогдсон өрхийн нэг сарын хугацаанд оройны 21.00 цагаас өглөөний 09.00 цагийн хооронд хэрэглэсэн 1500 кВт.цаг хүртэлх цахилгааны тарифыг 100 хувиар,

1.2. 380 В-ын хүчдэлийн түвшинд холбогдсон өрхийн нэг сарын хугацаанд оройны 21.00 цагаас өглөөний 09.00 цагийн хооронд хэрэглэсэн 3000 кВт.цаг хүртэлх цахилгааны тарифыг 100 хувиар,

1.3. Энэ тогтоолын 1.1, 1.2-т заасан хэмжээнээс илүү хэрэглэсэн цахилгааны тарифыг 50 хувиар.

2. Цахилгаан шугам, сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, гэр хорооллын өрхөд цахилгааны ашиглалтын аюулгүй байдалтай холбоотой сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

3. Энэ тарифын хөнгөлөлтийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллахыг цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны “Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай” 749 дүгээр тогтоол, 2025 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 42 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

ЗОХИЦУУЛАГЧ

Б.ЭНХЖАРГАЛ

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар А/413

Улаанбаатар  
хот

### ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм, түүнд тавигдах шаардлага, гэрээний загвар”-ын Олон нийтийн цагдаагийн дүрмийн 1.5, 3.4, 5.2 дахь хэсгийн “Нутаг дэвсгэр” гэсний өмнө “Алба, нэгж,” гэж, 2.3 дахь хэсгийн “хэрэгслийг” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 4.5, 9.7 дахь хэсгийн “тухайн” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 2.6 дахь хэсгийн “гүйцэтгэхдээ” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 3.2 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 3.3 дахь хэсгийн “үндэслэн” гэсний дараа “алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас” гэж, 5.1 дэх хэсгийн “хангах” гэсний дараа “алба болон Тээврийн цагдаагийн” гэж, 5.4 дэх хэсгийн “оруулж,” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 9.2 дахь хэсгийн “алба,” гэсний дараа “Тээврийн цагдаагийн алба,” гэж, 9.5 дахь хэсгийн “судалгааг” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 9.6 дахь хэсгийн “асуудлыг” гэсний дараа “алба, нэгж,” гэж тус тус нэмсүгэй.

2.Мөн дүрмийн “Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”-ын 1.1 дэх хэсгийн “талаас” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 2.1, 3.1, 4.1, 5.2, 6.1, 7.3 дахь хэсэг, 4.2.5, 4.2.6, 6.1.6 дахь заалтын “Нутаг дэвсгэр” гэсний өмнө “алба, нэгж,” гэж тус тус нэмсүгэй.

3.Мөн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.10 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/“Хоёрдугаар зүйл.Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааны чиглэл

2.1.Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, эрүүгийн болон хэв журам, замын хөдөлгөөний нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлд тулгуурлан олон нийтийн цагдааг Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу ажиллуулна.

2.10.Олон нийтийн цагдааг нутаг дэвсгэрийн онцлог, эрүүгийн болон хэв журам, замын хөдөлгөөний нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөлд тулгуурлан ажлын ачааллыг харгалзан хуульд зааснаас бусад чиглэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллуулж болно.”.

4.Мөн дүрмийн “Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”-ын 6.1 дэх хэсгийн 6.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй.

1/“6.1 дэх хэсэг:

6.1.1.олон нийтийн цагдаагийн өдөр тутмын үйл ажиллагаанд тухайн алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгжийн дарга, хариуцсан ахлах байцаагч, ахлах зохицуулагч, хэсгийн байцаагч, зохицуулагч нар хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.”.

5.Мөн дүрмийн “Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”-ын 4.2.19 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/“4.2 дахь хэсэг:

4.2.19.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх, үүрэг гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ бусдаар гүйцэтгүүлэх, эдлэх эрхээ бусдад шилжүүлэхгүй байх;”.

6.Мөн дүрмийн 2.2.1 дэх заалтын “аж ахуйн нэгж, байгууллага” гэснийг “хүн, хуулийн этгээд” гэж, 2.9 дэх хэсгийн “код 202, 205, 207, 213, 214, 222, 223, 224, 226, 227, 231, 234, 243, 400, 401, 404, 406, 408-д” гэснийг “код 202, 204, 207, 208, 209, 211, 215, 400, 401, 402, 403-д” гэж, 6.1 дэх хэсгийн “аж ахуйн нэгж” гэснийг “хуулийн этгээд” гэж, 6.7 дахь хэсгийн “код 133-д” гэснийг “код 129-д” гэж тус тус өөрчилсүгэй.

7.Мөн дүрмийн “Олон нийтийн цагдаатай байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар”-ын 2.2 дахь хэсгийн “гэмт хэргээс” гэснийг “гэмт хэрэг, зөрчлөөс” гэж, 2.3 дахь хэсгийн “эрүү, хэв журмын нөхцөл байдал,” гэснийг “эрүүгийн болон хэв журам, замын хөдөлгөөний нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл,” гэж, 4.2.2 дахь заалтын “аж ахуйн нэгж” гэснийг “хүн, хуулийн этгээд” гэж, 4.2.9 дэх заалтын “нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас зарласан, түргэн цугларалтын үед нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын холбогдох албан

тушаалтан” гэснийг “алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас зарласан, түргэн цугларалтын үед тухайн цагдаагийн байгууллагын холбогдох албан тушаалтан” гэж, 5.3 дахь хэсгийн “аж ахуйн нэгж” гэснийг “хүн, хуулийн этгээд” гэж, 5.10 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйл” гэснийг “Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

8.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (бригадын генерал О.Ганбат)-д даалгасугай.

9.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авсан.

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр  
сарын 24-ний өдөр

Дугаар А/217

Улаанбаатар  
хот

### МАЯГТЫН ЗАГВАР, ИНДЕКСИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд хөтлөх үйл ажиллагаанд цаасан хэлбэрээр хэрэглэх маягтын загварыг 1, цахим хэлбэрээр хэрэглэх маягтын загварыг 2, хуулийн этгээдийн хэлбэрийн индексийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (Ж.Аюуш)-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Маягтын загвар, индексийг шинэчлэн батлах тухай” А/130 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалыг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Д.ДАВААНЯМ

[illegible]

ନିମ୍ନ/ଉପର ଭିତ୍ତି/ଉପର ଭିତ୍ତି : :

በፊት ሕግ ላይ በፊት ሕግ ላይ «ከፍተኛ ስልጣን ለሕዝብ ማስገኘት» እና በፊት ሕግ ላይ

12. ત્ર ગુજરાત વિધાનસભા ના સાંચિકાગ્રામીણ જિલ્લા ના સામાજિક અને આરોગ્ય વલ 2022 ત્ર 6

9 ମିଶ୍ରର ସିନାପାଟନା +

[illegible]

.. சமீபத்தில் நான் எழுதியிருக்கிற கட்டுரைகள் ..

[illegible]

၂. အကယ်၍ ကျွန်ုပ်တို့၏ အမတ် ၆ ဦးထဲတွင် အမတ် ၁ ဦး၏ အမတ်ခန့်အပ်မှုကို ချုပ်ဆိုနိုင်ပါက အမတ် ၅ ဦး၏ အမတ်ခန့်အပ်မှုကို ချုပ်ဆိုနိုင်ပါသည်။

[illegible][illegible]

1. የጥራት ማረጋገጫ ስርዓት፡ የጥራት ማረጋገጫ ስርዓት በጥራት ማረጋገጫ ስርዓት  
 2. የጥራት ማረጋገጫ ስርዓት፡ የጥራት ማረጋገጫ ስርዓት በጥራት ማረጋገጫ ስርዓት

பெரிய நகரங்களில் உள்ள பள்ளிகளில் படிப்பவர்களுக்கு

\_\_\_\_\_ १०/८ \_\_\_\_\_ १०/८ \_\_\_\_\_ १०/८

॥ श्रीगणेशाय नमः ॥

● ॥ ॐ ॥  
 ॐ नमो भगवते वासुदेवाय  
 ॐ नमो भगवते वासुदेवाय

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авсан.

## **ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар А/219, А/441

Улаанбаатар  
хот

### **ТУШААЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/76, А/515 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-д “Энэ журмын 3.7-д заасан цогц үнэлгээг ахмад настанд цахимаар хийж болно” гэсэн агуулга бүхий 3.8 дахь хэсэг нэмсүгэй.

2. “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ын хавсралтаар баталсан “Ахмад настны цогц үнэлгээний дүгнэлтийн загвар”-ын “хяналтын дүгнэлт” гэсний дараа “эсхүл Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн эмчийн дүгнэлт” гэж нэмсүгэй.

3. “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ын 3.7 дахь хэсгийг “Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээнд хамрагдах ахмад настанд цогц үнэлгээг энэ журмын 3.1-д заасан эрүүл мэндийн ажилтнаас гадна үйлчилгээ үзүүлэх тухайн төвийн эмч хийж болно.” гэж өөрчлөн найруулсугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙД

Т.АУБАКИР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН

## САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар А/204

Улаанбаатар  
хот

### ТУШААЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2019 оны 101 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам” (цаашид “журам” гэх)-д дараах өөрчлөлт оруулсугай:

1.1.Журмын 2.5.2 дахь дэд заалтын “2.5 цаг” гэснийг “3 цаг” гэж, 2.5.3 дахь дэд заалтын “Хууль эрх зүй 2.5 цаг” гэснийг “Хууль эрх зүй - Татварын бодлого 3 цаг” гэж, 2.6 дахь заалтын “70 /дал/” гэснийг “75 /далан тав/” гэж, 2.7 дахь заалтын “70” гэснийг “75” гэж, 2.9 дэх заалтын “24 цагийн” гэснийг “ажлын 2 хоногийн” гэж, 2.12.3 дахь дэд заалтын “Татвар, нягтлан бодох бүртгэлийн” гэснийг “Татварын” гэж, 3.5 дахь заалтын “нягтлан бодох бүртгэлийн” гэснийг “татварын” гэж, 3.7 дахь заалтын “нягтлан бодох бүртгэлийн” гэснийг “татварын бодлогын” гэж, 5.6 дахь заалтын “3 сарын” гэснийг “1 жилийн” гэж, 9.2 дахь заалтын “байгууллагын нягтлан бодох бүртгэлийн газар нь” гэснийг “байгууллага” гэж, 10.3 дахь заалтын “гомдол үндэслэлтэй тохиолдолд” гэснийг “зүгээс гаргасан гомдол нь шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний явцад гарсан зөрчилтэй холбоотой тохиолдолд тус гомдлыг хянан үзэж” гэж тус тус өөрчилсүгэй.

1.2.Журмын 3.5 дахь заалтын “/нийгэмлэг санал болгох/” гэснийг, 8.3 дахь заалтын “8.1.1-д заасан нөхцөлийг Татварын албанаас ирүүлсэн албан бичиг, эсхүл нийгмийн даатгалын дэвтэр, ажилласныг нотлох архивын газрын лавлагаа, мөн эрх зүйч мэргэжлээр төгссөн диплом, эсхүл хуульч, өмгөөлөгчийн гэрчилгээ,” гэснийг, 8.4 дэх заалтын “ба 8.2” гэснийг тус тус хассугай.

1.3.Журмын 2.3, 2.4 дэх заалт, 2.12.2 дахь дэд заалт, 3.8 дахь заалт, 6.5.7 дахь дэд заалт, 8.1.1, 8.2.1-8.2.3 дахь дэд заалт, 8.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалт авах арга хэмжээг батлагдсан журмын дагуу зохион байгуулахыг Татварын бодлогын газар /Б.Тэлмүүн/-т даалгасугай.

3.Журамд орсон өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Татварын бодлогын газар /Б.Тэлмүүн/-т даалгасугай.

4.Энэхүү тушаалыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Б.ЖАВХЛАН

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 12 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар А/707

Сайншанд сум

## СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, 68 дугаар зүйлийг түс түс үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гарсан саналын дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/774 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарт дор дурдсанаар өөрчлөлт оруулсугай.

| № | Тусгай зөвшөөрлийн төрөл       | Цагийн хязгаар |
|---|--------------------------------|----------------|
| 1 | 2                              | 3              |
| 1 | Согтууруулах ундаа худалдах    | 07:00-00:00    |
| 2 | Согтууруулах ундаагаар үйлчлэх | 11:00-22:00    |
| 3 |                                | 14:00-02:00    |

2.Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цагийн хязгаарыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын захирал, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Батзориг), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Наранболд), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Ч.Нандин-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

## О.БАТЖАРГАЛ

“ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛ”-Д 2025  
ОНД НИЙТЛЭГДСЭН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН ЭРХ ЗҮЙН  
АКТЫН ЖАГСААЛТ

| Д/д                                        | Хаанаас гарсан                                             | Тушаалын дугаар, он, сар, өдөр | Тушаалын агуулга                                                                                                                                                                                                                                                                           | Улсын бүртгэлийн дугаар | Улсын бүртгэлд орсон он, сар |
|--------------------------------------------|------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|------------------------------|
| ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛ №1 |                                                            |                                |                                                                                                                                                                                                                                                                                            |                         |                              |
| 1                                          | Монгол Улсын Зам, тээврийн сайд                            | A/272<br>2024.12.16            | <b>ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ</b><br>Монгол Улсын Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн A/272 дугаар тушаал                                                                                                                                                               | 7011                    | 2024.12.27                   |
| 2                                          | Баян-Өлгий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал            | 09<br>2024.12.04               | <b>ОРОН НУТГИЙН, ХОТ ДОТОРХ БОЛОН ХОТ ОРЧМЫН НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР, ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ</b><br>Баян-Өлгий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоол | 7012                    | 2024.12.27                   |
| 3                                          | Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд | A/844<br>2024.12.12            | <b>ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн A/249 дүгээр тушаал                                                                                                                                                                         | 7013                    | 2024.12.27                   |
| 4                                          | Санхүүгийн зохицуулах хороо                                | 587<br>2024.12.17              | <b>ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 587 дугаар тогтоол                                                                                                                                                                        | 7014                    | 2024.12.30                   |

|                                                   |                                             |                     |                                                                                                                                                                                                             |      |            |
|---------------------------------------------------|---------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 5                                                 | Эрчим хүчний зохицуулах хороо               | 749<br>2024.12.18   | <b>ТАРИФТ ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ</b><br>Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 749 дүгээр тогтоол                                                                           | 7015 | 2024.12.30 |
| 6                                                 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал     | 24/28<br>2024.12.04 | <b>АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/28 дугаар тогтоол | 7016 | 2024.12.31 |
| 7                                                 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал     | 24/29<br>2024.12.04 | <b>АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/29 дүгээр тогтоол                                   | 7017 | 2024.12.31 |
| 8                                                 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | A/67<br>2024.12.12  | <b>ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ</b><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн A/67 дугаар тушаал                                                                     | 7018 | 2025.01.03 |
| <b>ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛ №2</b> |                                             |                     |                                                                                                                                                                                                             |      |            |
| 9                                                 | Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга          | A/496<br>2024.12.24 | <b>ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ</b><br>Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн A/496 дугаар тушаал                                                                                | 7019 | 2025.01.06 |
| 10                                                | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга     | A/246<br>2024.12.26 | <b>ЖУРАМ, ЗААВАР, ӨРГӨДЛИЙН МАЯГТЫН ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ</b><br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн A/246 дугаар тушаал                                           | 7020 | 2025.01.06 |

|    |                                                                         |                    |                                                                                                                                                                                                                                                                   |      |            |
|----|-------------------------------------------------------------------------|--------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 11 | Дундговь<br>аймгийн<br>иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал               | 14<br>2024.12.20   | <b>МАЛ ЭМНЭЛГИЙН<br/>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ<br/>ТӨЛБӨРИЙН ЖИШИГ<br/>ҮНЭЛГЭЭНИЙ<br/>НОРМАТИВЫГ<br/>ШИНЭЧЛЭН БАТЛАХ<br/>ТУХАЙ</b><br>Дундговь аймаг<br>иргэдийн Төлөөлөгчдийн<br>Хурлын 2024 оны 12<br>дугаар сарын 20-ны<br>өдрийн 14 дүгээр тогтоол                         | 7021 | 2025.01.06 |
| 12 | Дундговь<br>аймгийн<br>иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал               | 15<br>2024.12.20   | <b>БИЧИЛ ХУДАЛДАА,<br/>АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ<br/>ОРЛОГО ОЛЖ БАЙГАА<br/>ХУВЬ ХҮНИЙ САРД<br/>ТӨЛӨХ АЛБАН<br/>ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ<br/>ТОГТООХ ТУХАЙ</b><br>Дундговь аймаг<br>иргэдийн Төлөөлөгчдийн<br>Хурлын 2024 оны 12<br>дугаар сарын 20-ны<br>өдрийн 15 дугаар тогтоол | 7022 | 2025.01.06 |
| 13 | Увс аймаг<br>Зүүнхангай<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал     | 2/08<br>2024.12.19 | <b>ХОГ ХАЯГДЛЫН<br/>ХУРААМЖИЙГ<br/>ШИНЭЧЛЭН ТОГТООХ<br/>ТУХАЙ</b><br>Увс аймаг Зүүнхангай<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн Хурлын<br>Хуралдааны 2024 оны<br>12 дугаар сарын 19-ний<br>өдрийн 2/08 дугаар тогтоол                                                | 7023 | 2025.01.06 |
| 14 | Архангай аймаг<br>Жаргалант<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал | 18<br>2024.12.25   | <b>МАЛЫН ТОО ТОЛГОЙН<br/>АЛБАН ТАТВАРЫН<br/>ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН<br/>ТОГТООХ ТУХАЙ</b><br>Архангай аймаг Жаргалант<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн Хурлын<br>2024 оны 12 дугаар сарын<br>25-ны өдрийн 18 дугаар<br>тогтоол                                         | 7024 | 2025.01.06 |

|    |                                                            |                  |                                                                                                                                                           |      |            |
|----|------------------------------------------------------------|------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 15 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 50<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоол | 7025 | 2025.01.08 |
| 16 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 51<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 51 дүгээр тогтоол | 7026 | 2025.01.08 |
| 17 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 52<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоол | 7027 | 2025.01.08 |
| 18 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 53<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 53 дугаар тогтоол | 7028 | 2025.01.08 |
| 19 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 54<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 54 дүгээр тогтоол | 7029 | 2025.01.08 |
| 20 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 55<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 55 дугаар тогтоол | 7030 | 2025.01.08 |
| 21 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 56<br>2024.12.13 | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 56 дугаар тогтоол | 7031 | 2025.01.08 |

|    |                                                            |                         |                                                                                                                                                                                         |      |            |
|----|------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 22 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 57<br>2024.12.13        | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар тогтоол                               | 7032 | 2025.01.08 |
| 23 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 58<br>2024.12.13        | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоол                               | 7033 | 2025.01.08 |
| 24 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 59<br>2024.12.13        | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 59 дүгээр тогтоол                               | 7034 | 2025.01.08 |
| 25 | Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурал | 60<br>2024.12.13        | <b>ТАРИФ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 60 дугаар тогтоол                               | 7035 | 2025.01.08 |
| 26 | Өвөрхангай аймгийн Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 02/04<br>2024.12.25     | <b>МАЛЫН ТОО, ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ</b><br>Өвөрхангай аймгийн Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02/04 дүгээр тогтоол | 7036 | 2025.01.10 |
| 27 | Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хороо                     | A/243/208<br>2024.12.26 | <b>ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Сангийн сайд, Сонгуулийн ерөнхий хорооны хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн A/243/208 дугаар тушаал, тогтоол                                  | 7037 | 2025.01.13 |

|    |                                                                                   |                    |                                                                                                                                                                                                                                                                      |      |            |
|----|-----------------------------------------------------------------------------------|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 28 | Өвөрхангай аймаг Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                     | 3/01<br>2024.12.26 | <b>ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ, ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ</b><br>Өвөрхангай аймаг Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 3/01 дүгээр тогтоол           | 7038 | 2025.01.13 |
| 29 | Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо                                             | 209<br>2024.12.30  | <b>ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 209 дүгээр тогтоол                                                                                                                                        | 7039 | 2025.01.14 |
| 30 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо | 103<br>2024.12.27  | <b>ЗАВХАН АЙМГИЙН “АМЬ УС” ХХК-ИЙН АЖ, АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 103 дугаар тогтоол | 7040 | 2025.01.14 |
| 31 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо | 105<br>2024.12.27  | <b>ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “УС-ДУ” ОНӨААТҮГ-ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 105 дугаар тогтоол                      | 7041 | 2025.01.14 |

|    |                                                                                                        |                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                         |      |            |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 32 | Хот, суурины<br>ус хангамж,<br>ариутгах<br>татуургын<br>ашиглалт,<br>үйлчилгээг<br>зохицуулах<br>хороо | 109<br>2024.12.27 | <b>БАГАНУУР ДҮҮРГИЙН<br/>“БАГАНУУР-УС” ААТҮГ-<br/>ЫН ЦЭВЭР, БОХИР УСНЫ<br/>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ<br/>БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж,<br>ариутгах татуургын<br>ашиглалт, үйлчилгээг<br>зохицуулах хорооны 2024<br>оны 12 дугаар сарын 27-ны<br>өдрийн 109 дүгээр тогтоол                                                       | 7042 | 2025.01.14 |
| 33 | Хот, суурины<br>ус хангамж,<br>ариутгах<br>татуургын<br>ашиглалт,<br>үйлчилгээг<br>зохицуулах<br>хороо | 112<br>2024.12.27 | <b>ДАРХАН-УУЛ АЙМГИЙН<br/>“ДУЛААН ШАРЫН<br/>ГОЛ” ТӨХК-ИЙН<br/>ЦЭВЭР, БОХИР УСНЫ<br/>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ<br/>БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж,<br>ариутгах татуургын<br>ашиглалт, үйлчилгээг<br>зохицуулах хорооны 2024<br>оны 12 дугаар сарын 27-ны<br>өдрийн 112 дугаар тогтоол                                              | 7043 | 2025.01.14 |
| 34 | Хот, суурины<br>ус хангамж,<br>ариутгах<br>татуургын<br>ашиглалт,<br>үйлчилгээг<br>зохицуулах<br>хороо | 114<br>2024.12.27 | <b>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН<br/>“ОНГИ УС СУВАГ” ХХК-<br/>ИЙН ЦЭВЭР, БОХИР<br/>УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ<br/>ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж,<br>ариутгах татуургын<br>ашиглалт, үйлчилгээг<br>зохицуулах хорооны 2024<br>оны 12 дугаар сарын 27-ны<br>өдрийн 114 дүгээр тогтоол                                                     | 7044 | 2025.01.14 |
| 35 | Хот, суурины<br>ус хангамж,<br>ариутгах<br>татуургын<br>ашиглалт,<br>үйлчилгээг<br>зохицуулах<br>хороо | 115<br>2024.12.27 | <b>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН<br/>“ХАРХОРИН-УС СУВАГ”<br/>ХХК-ИЙН ҮЙЛДВЭР,<br/>АЖ АХУЙН НЭГЖ,<br/>БАЙГУУЛЛАГЫН<br/>ЦЭВЭР, БОХИР ЭСНЫ<br/>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ<br/>БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж,<br>ариутгах татуургын<br>ашиглалт, үйлчилгээг<br>зохицуулах хорооны 2024<br>оны 12 дугаар сарын 27-ны<br>өдрийн 115 дугаар тогтоол | 7045 | 2025.01.14 |

|    |                                                                                                        |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |      |            |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 36 | Хот, суурины<br>ус хангамж,<br>ариутгах<br>татуургын<br>ашиглалт,<br>үйлчилгээг<br>зохицуулах<br>хороо | 117<br>2024.12.27   | <b>СЭЛЭНГЭ АЙМГИЙН<br/>МАНДАЛ СУМЫН “ЦАНТ<br/>ОРХОН” ОНӨААТҮГ-ЫН<br/>УС ТҮГЭЭХ БАЙРНЫ<br/>ТАРИФ, ҮЙЛДВЭР,<br/>АЖ АХУЙН НЭГЖ,<br/>БАЙГУУЛЛАГЫН БОХИР<br/>УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ<br/>ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Хот, суурины ус хангамж,<br>ариутгах татуургын<br>ашиглалт, үйлчилгээг<br>зохицуулах хорооны 2024<br>оны 12 дугаар сарын 27-ны<br>өдрийн 117 дугаар тогтоол | 7046 | 2025.01.14 |
| 37 | Өвөрхангай<br>аймгийн<br>Хархорин<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал                          | 02/07<br>2024.12.27 | <b>МАЛЫН ТОО ТОЛГОЙН<br/>АЛБАН ТАТВАРЫН<br/>ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН<br/>ТОГТООХ ТУХАЙ</b><br>Өвөрхангай аймгийн<br>Хархорин сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн Хурлын<br>2024 оны 12 дугаар сарын<br>27-ны өдрийн 02/07 дугаар<br>тогтоол                                                                                                                                     | 7047 | 2025.01.14 |
| 38 | Дорноговь<br>аймаг<br>Сайхандулаан<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал                         | 2/18<br>2024.12.09  | <b>МАЛЫН ТОО ТОЛГОЙН<br/>АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ<br/>ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН<br/>ТОГТООХ ТУХАЙ</b><br>Дорноговь аймаг<br>Сайхандулаан сумын<br>иргэдийн Төлөөлөгчдийн<br>Хурлын 2024 оны 12<br>дугаар сарын 09-ний<br>өдрийн 2/18 дугаар тогтоол                                                                                                                               | 7048 | 2025.01.14 |
| 39 | Дорноговь<br>аймаг<br>Сайхандулаан<br>сумын иргэдийн<br>Төлөөлөгчдийн<br>Хурал                         | 2/19<br>2024.12.09  | <b>ХОГ ХАЯГДЛЫН<br/>ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ<br/>ШИНЭЧЛЭН ТОГТООХ<br/>ТУХАЙ</b><br>Дорноговь аймаг<br>Сайхандулаан сумын<br>иргэдийн Төлөөлөгчдийн<br>Хурлын 2024 оны 12<br>дугаар сарын 09-ний<br>өдрийн 2/19 дүгээр тогтоол                                                                                                                                             | 7049 | 2025.01.14 |

|    |                                                                       |                     |                                                                                                                                                                                                                   |      |            |
|----|-----------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------------|
| 40 | Монгол Улсын Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын тушаал | 147<br>2024.12.26   | <b>“БАРИЛГЫН ХӨНГӨН ЦАГААН БҮТЭЭЦ”/БНБД 53-04-24/ БАРИЛГЫН НОРМ, ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ</b><br>Монгол Улсын Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 147 дугаар тушаал | 7050 | 2025.01.15 |
| 41 | Архангай аймаг Эрдэнэмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал        | 09<br>2024.12.30    | <b>МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ</b><br>Архангай аймаг Эрдэнэмандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр тогтоол                          | 7051 | 2025.01.15 |
| 42 | Баянхонгор аймгийн Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал          | 02/31<br>2024.12.26 | <b>МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ</b><br>Баянхонгор аймгийн Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/31 дүгээр тогтоол              | 7052 | 2025.01.15 |
| 43 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                               | 24/18<br>2024.11.29 | <b>ГАЗРЫГ ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВАХ ТУХАЙ</b><br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/18 дугаар тогтоол                                                   | 7053 | 2025.01.15 |
| 44 | Харилцаа холбооны зохицуулах хороо                                    | 242<br>2024.12.16   | <b>“ДОМЭЙН НЭРИЙГ БҮРТГЭХ, АШИГЛАХ ЖУРАМ”-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ</b><br>Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 242 дугаар тогтоол                                           | 7054 | 2025.01.15 |

|                                                   |                                                                               |                     |                                                                                                                                                                                                                         |                    |            |
|---------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|------------|
